

МОНГОЛ ОРНЫ ХУВЬД БАРИМТЛАХ СТРАТЕГИ

2006 оны 12-р сарын 5-ны өдрийн Захирлуудын Зөвлөлөөс баталсан
байдлаар

Баримт бичгийн эх сурвалжийн орчуулгыг гагцхүү уншигчийн тохь тухын тулд ЕСБХБ-аас хангасан болно. Хэдийгээр орчуулгын үнэн зөв байдлыг хангах талаар ЕСБХБ-аас зохих анхаарал тавьсан боловч, түүний үнэн зөвийг баталгаажуулахгүй буюу ноглохгүй. Орчуулсан сурвалжийг уншигч хэрэглэх эсэхийг тухайн уншигч өөрөө хариуцна. Орчуулгын аливаа буруу зөрүү, алдаа, орхидуулсан зүйлийн төлөө, буюу эдгээрээс үүдэн гарч болзошгүй аливаа хохирлын төлөө, түүний учир шалтгаанаас үл хамааран, ЕСБХБ, түүний ажилтан буюу агентууд уншигчийн болоод өөр хэн нэгний өмнө хариуцлага хүлээхгүй. Баримт бичгийн англи болон орчуулсан хувилбарын хооронд гарч болзошгүй зөрчилдөөн буюу үл зохицолдсон тохиолдолд, англи эх давамгайлна.

ГАРЧИГ

I. ТОВЧ ХУРААНГУЙ	3
ТОВЧЛОЛУУДЫН ЖАГСААЛТ	7
II. СТРАТЕГИ	9
1. Банкны санхүүжилтийн багц	9
1.1. Өнөөг хүртэлх хугацаанд явуулсан үйл ажиллагааны тойм	9
1.2 Шилжилтийн үр нөлөө ба авсан сургамж	10
2. Үйл ажиллагааны орчин	10
2.1 Өөрчлөлт шинэчлэлийн ерөнхий орчин	10
2.1.1 Улс төрийн байдал	10
2.1.2 Хууль эрх зүйн орчин	11
2.1.3 Байгаль орчны асуудал	11
2.1.4 Нийгмийн асуудал	12
2.2 Эдийн засгийн хөгжил ба шилжилтийн явцад хүрсэн ололт амжилт	14
2.2.1 Макро эдийн засгийн нөхцөл байдал	14
2.2.2 Шилжилтийн явцад хүрсэн ололт амжилт ба шийдвэрлэгдээгүй асуудлууд	16
2.3 Хөрөнгө санхүүгийн хүртээмж	21
3. Стратегийн үндсэн чиглэл	23
3.1 Банкны тэргүүлэх чиглэл	23
3.1.1 Хувийн хэвшлийн хөгжлийн санхүүжилт	23
3.1.2 Санхүүгийн салбарыг бэхжүүлэх	23
3.1.3 Байгалийн нөөцийн салбарын салбарын тогтвортой хөгжил	24
3.1.4 Зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн хөгжлийг дэмжих	24
3.1.5 Бодлогын яриа хэлэлцүүлэг	25
3.2 Салбарын шийдвэрлэвэл зохих асуудлууд ба Банкны үйл ажиллагааны зорилтууд	25
3.2.1 Хувийн хэвшил	25
3.2.2 Санхүүгийн байгууллагууд	27
3.2.3 Байгалийн нөөцийн салбар	28
3.2.4 Агробизнес	29
3.2.5 Дэд бүтэц	29
4. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон олон талт хандивлагчид	32
4.1 Олон Улсын Валютын Сан (ОУВС)	32
4.2 Дэлхийн Банкны Бүлэг	33
4.3 Азийн Хөгжлийн Банк (АХБ)	33
4.4 НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ).....	34
III. ХАВСРАЛТ	35
Хавсралт 1 – Улс төрийн нөхцөлүнэлгээ	36
Хавсралт 2 - Байгаль орчны болон нийгмийн гол асуудлууд	39
Хавсралт 3 – Санхүүжилт хийхээр бэлтгэж буй төслийн жагсаалт	45
Хавсралт 4 - Техникийн туслалцааны төслүүдэд амласан дүн	46
Хавсралт 5- Төлөвлөж буй техникийн туслалцааны төслүүд.....	47
Хавсралт 6 – Хууль эрх зүйн үнэлгээ	48
Хавсралт 7 - Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд	54
Хавсралт 8 – Хоёр талт тусламж	56
Хавсралт 9 – Монгол Улсын газрын зураг	61

I. ТОВЧ ХУРААНГУЙ

Энэ оны 6-р сард Банкны бүх гишүүн орнууд соёрхон баталсны дагуу, Монгол Улс 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдөр тус Банкны үйл ажиллагааны орон (country of operation) боллоо. Иймд энэ нь Монгол Улсын хувьд баримтлах анхны стратеги болж байгаа юм. Чухам энэ утгаараа Банкны зүгээс бүсийн бусад орнуудад хуримтлуулсан туршлага мэдлэгээ Монгол Улсын шилжилтийн үйл явц ба хөгжлийг дэмжих зорилгоор хэрэглэхийг зорино. Өнөөг хүртэлх хугацаанд энэхүү үйл явцыг дэмжихэд хандивлагчдын дэмжлэг ба хандив, нэн ялангуяа Монголтой Хамтран Ажиллах Санд хандивлагчдаас оруулсан хандив тусламж нэн чухал үүргээ гүйцэтгэсэн билээ. Монгол Улс нь Шилжилтийн Эхний Үе Шатан Дахь Орнуудыг Дэмжих Санаачилга (ETCI)-ад хамрагдах болсон ба энэхүү Санаачилга нь Монгол Улсын шилжилт, хувийн хэвшлийн хөгжлийг түргэтгэхэд шаардлагатай бүхий л арга хэрэгслийг дайчлах боломжийг Банкнд олгох юм.

Монгол Улс нь олон намын тогтолцоо, олон үзэлт нийгэмтэй орон бөгөөд Банкийг Үүсгэн Байгуулах тухай Гэрээний Зүйл 1-д заасны дагуу зах зээлийн эдийн засагт шилжих явцад нааштай ахиц гаргаж байгаа билээ. Монгол Улсын хэвлэл мэдээлэл харьцангуй эрх чөлөөтэй, төрийн бус байгууллагууд харьцангуй идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг, хүний эрхийн стандартуудыг дагаж мөрдөх явдал улам сайжирч байна. 2006 оны 1 дүгээр сард шинэ эвслийн засгийн газар байгуулагдаж, улс төр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийг үргэлжлүүлэх хүсэл эрмэлзэл дүүрэн байгаагаа илэрхийлсэн.

Монгол Улс нь том газар нутагтай, далайд гарцгүй, Хятад ба Орос Улстай хил залгаа оршдог юм. Хүн ам нь аажмаар өсч байгаа ч, 2.6 сая хүн амтай байгаа нь бага хэвээр байна. Тус орон нь бага орлоготой орны тоонд багтаж 2005 онд нэг хүнд ногдох ДНБ 710 ам. доллар байсан ба хүн амын 36 орчим хувь ядуу амьдралтай байна. Ажилгүйдэл, хот хөдөөгийн болоод үе хоорондын ялгаа нь нийгмийн сэтгэлийг зовниулсан асуудал болж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд төр засгаас үндэсний хөгжлийн төлөвлөгөөг Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжих, Ядуурлыг Бууруулах Стратегийн хэлбэрээр боловсруулан гаргаад байгаа.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн байдал ихээхэн сайжирч байна. ДНБ-ний өсөлт 2004 онд 10.6 хувь, 2005 онд 6.2 хувьд тус тус хүрсэн нь чамгүй сайн үзүүлэлт байв. Өсөлтөд цаг агаарын тааламжтай нөхцөл, эрдэс түүхий эдийн дэлхийн зах зээлийн өндөр үнэ, өсч буй хүн амын орлого ба гадаадаас хийх мөнгөн гуйвуулгын дүнд хэрэглээ өссөн зэрэг хүчин зүйл нөлөөлөв. Татварын орлого нэмэгдэж, төсвийн зарлагын удирдлага сайжирснаар улсын төсвийн гүйцэтгэл мөн сайжирч, 2005 онд ДНБ-ний 3 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарсан нь сүүлийн жилүүдэд тохиолдоогүй үзэгдэл боллоо. Гадаад худалдааны хувьд урсгал данс мөн ашигтай гарсан нь эрдэс түүхий эдийн өндөр үнэ ба гадаад гуйвуулгын өсөлттэй тодорхой хэмжээгээр холбоотой байв.

Монгол Улс нь Орост төлөх ёстой шилжилтийн өмнөх өрийн асудлыг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдэж чадлаа. Үүний үр дүнд гадаад өрийн байдал дорвитойгоор сайжирлаа. Хэдийгээр тус улсын өр нэрлэсэн дүнгээр ДНБ-ний 62 хувьтай тэнцэж байгаа ч өрийн ихэнхийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан тул, зээлийн эргэн төлөлт улсын төсвийн зардалд томоохон хэмжээг эзлэхгүй байна. Улсын өрийн чадавхийг зохистой удирдах нь Засгийн Газрын эн тэргүүний асуудал хэвээр байх учиртай бөгөөд чухам энэ шалтгаанаар Засгийн Газар хөнгөлөлттэй бус нөхцөлөөр зээл авахгүй байх бодлогоо үргэлжлүүлэх болно.

Монгол Улс либералчлал, бүтцийн өөрчлөлтийн хэд хэдэн чиглэлээр, түүний дотор үнэ, худалдааг чөлөөлөх, түүнчлэн өмч хувьчлалын чиглэлээр томоохон амжилт гаргасан юм. Монгол орон ДХБ-ын гишүүнээр 1997 онд элссэн бөгөд валют бүрэн хөрвөх боломжтой хөвөгч валютын тогтолцоотой. Өмч хувьчлал дээд үе шатандаа орсон (хувийн хэвшил ДНБ-ний 70 хувийг эзэлж байна). Гэвч хувьчлалын дараахь бүтцийн өөрчлөлт, компанийн засаглал нь сул гэж тооцогдож,

цаашид боловсронгуй болгох шаардлагатай. Хэдийгээр Засгийн Газраас санхүүгийн салбарын өөрчлөлт шинэчлэлийн тал дээр ахиц гаргасан боловч аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүү эх үүсвэрийн өртөг, хүртээмж нь үйл ажиллагаа явуулахад саад болсоор байна. Дэд бүтцийн хөгжил дорой байгаа ба зах зээлийн нөхцөлд ажиллах ёстой байгууллагуудын хөгжил эхний үе шатандаа байна. Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзвэл Монгол Улсын шилжилтийн үйл явцын хамгийн чухал шийдвэрлэвэл зохих асуудлыг дараахь байдлаар тодорхойлж болно. Үүнд: (а) бизнесийн орчин ба компанийн засаглалыг боловсронгуй болгох, (б) санхүүгийн салбарыг улам бэхжүүлэн хөгжүүлэх, (в) байгалийн нөөцийн салбарт өрсөлдөөнт, ил тод орчинг бүрдүүлэх, (г) төрийн мэдлийн дэд бүтцийг арилжааны хэлбэрт шилжүүлэх, түүнд хувийн хэвшлийн оролцоог хангах явдлыг хөхиүлэн дэмжих зэрэг багтана.

Иймд дээр дурдсан макро эдийн засгийн орчин, өөрчлөлт шинэчлэлийн үе шатыг харгалзан үзэж, Банк нь энэхүү стратегийг хэрэгжүүлэх хугацаанд үйл ажиллагааны дараах тэргүүлэх чиглэлд анхаарлаа төвлөрүүлэх болно. Үүнд:

Хувийн хэвшлийн хөгжлийг санхүүжүүлэх

Хувийн бизнесийг хөгжүүлэх нь Банкны стратегийн үндсэн тулгуур байх болно. Банк нь хөдөө аж ахуйн бизнес, зочид буудал ба аялал жуулчлал, дэд бүтэц, барилга, үл хөдлөх хөрөнгө, үйлчилгээ болоод хамгийн чухал нь байгалийн нөөцийн зэрэг хэд хэдэн гол салбарт шууд санхүүжилт хийх боломжийг судлана. Түүнчлэн цаашид хийгдэх ёстой томоохон өмч хувьчлал, төрийн эзэмшлийн томоохон үйлдвэрийн газруудыг арилжааны хэлбэрт шилжүүлэх, корпорацжуулах ажлыг дэмжих боломжийг эрэлхийлнэ. Банк нь олон улсын томоохон нэр хүнд бүхий хөрөнгө оруулагчдыг татахын төлөө ажиллана.

Монгол Улсыг ШЭҮШОДС-д (ETC Initiative) хамруулснаар Дунд Хэмжээний Хамтран Санхүүжүүлэх Хэрэгсэл (MCFF), Шууд Хөрөнгө Оруулалтын Хэрэгсэл (DIF) ба Зээлийн Шууд Санхүүжилтийн Хэрэгсэл (DLF), тухайн компаниудын үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд олгох техникийн туслалцааны хөтөлбөрүүдэд хамрагдах хүртээмж нэмэгдэж, тус улсад санхүүжүүлэх төслүүдийг бэлтгэх боломжийг нэмэгдүүлэх юм. ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих хүчин чармайлтынхаа хүрээнд, Банк нь Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр (TAM)-ийг хэрэгжүүлсэн туршлагад тулгуурлах ба цаашид Бизнесийн Зөвлөгөө Өгөх Хөтөлбөр (BAS)-ийг бий болгох чиглэлд ажиллана.

Бүрэлдэн хөгжиж буй хувийн хэвшлийн бүтцийн хувьд Банкны зүгээс бичил бизнесийг тусгайлан анхаарч Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хувийн банкуудаас олгож буй бичил, жижиг бизнесийн зээлийн шугамыг бэхжүүлэн хөгжүүлэх, нэн ялангуяа илүү алслагдсан бүс нутагт хийгдэж буй үйл ажиллагааг хөгжүүлэхийг эн тэргүүлэх зорилтоо болгон ажиллана.

Санхүүгийн салбарыг бэхжүүлэх

Банкны хувьд санхүүгийн салбарт олгох дэмжлэг туслалцаа нь тэргүүлэх чиглэлийн гол зорилт байх болно. Арилжааны банкуудад урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр дутагдаж санхүүжилтийн өртөг өндөр байна. Банк нь санхүүгийн зуучлал болон банкууд нэгдэх үйл явцыг дэмжиж, тус орон дахь санхүүгийн хүртээмжийг сайжруулахыг эрмэлзэнэ. Энэ зорилгоор Банкны санхүүгийн ба үнэнч шударга байдлын (integrity) шалгуурыг хангасан арилжааны банкуудад төрөл бүрийн зээлийн шугам, өрийн санхүүжилтийн бүтээгдэхүүнээр хангах болно. Худалдааны санхүүжилт өндөр эрэлт хэрэгцээтэй байгаа тул Банк нь Худалдааг Дэмжих Хөтөлбөр (TFP)-ийг хэрэгжүүлэх ажлыг идэвхтэй эхлүүлнэ. Арилжааны банк, банк бус байгууллагуудад, ялангуяа нийслэлээс гадуур үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад зээлийн шугам нээх замаар бичил ба жижиг бизнесүүдэд зориулсан санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Монгол Улсыг үйл ажиллагааны орноор соёрхон баталснаас хойш хөдөө орон нутгийн санхүүжилтийн эрэлт хэрэгцээг дэмжих зорилгоор ЕСБХБ нь Монгол дахь санхүүжилтийн анхны гэрээг бичил зээлийн тэргүүлэх байгууллагатай байгуулсан.

ЕСБХБ-ны зүгээс арилжааны банкуудад хувь эзэмших замаар (equity) хөрөнгө оруулах боломжийг эрэлхийлнэ. Ингэснээр дотоодын банкнуудын дүрмийн санг бэхжүүлж, компанийн засаглалыг боловсронгуй болгоход тус дөхөм болох юм. Түүнчлэн банк бус бичил санхүүгийн байгууллага (ББСБ), лизинг, орон сууцны ипотекийн зээл, хэрэглээний санхүүжилт, даатгал ба тэтгэврийн байгууллага зэрэг банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх явдлыг дэмжихийг эрмэлзэнэ.

Монголын харьцангуй залуу санхүүгийн салбарын байгууллагын бэхжилт хөгжил, шинээр олгосон ур чадварын тогтвортой байдлыг хангах зорилгоор эхний ээлжинд бичил ба ЖДҮ-д зориулсан зээлийн шугам, худалдааг дэмжих хөтөлбөр, ББСБ, улмаар лизинг, орон сууцны ипотека, даатгал, тэтгэвэр гэх мэт чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бусад хандивлагчдаас эрэлхийлэх болно.

Монголбанктай бодлогын түвшинд хийх яриа хэлэлцүүлгийг идэвхитэй явуулж, ингэхдээ хяналт шалгалтыг боловсронгуй болгож банкуудын нэгдэх үйл явцыг хөхиүлэн дэмжиж, мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх зэрэг тодорхой асуудлыг түлхүү анхаарна.

Байгалийн нөөцийн салбарыг тогтвортой байдлаар хөгжүүлэх нь

Монгол Улс ашигт малтмалын арвин их нөөцтэй бөгөөд энэ нь тус улсыг ирээдүйд хөгжүүлэх, ядуурлыг бууруулах томоохон боломж бүрдүүлж байгаа юм. Дэлхийн Банкны ивээл дор боловсруулсан Ашигт малтмалын тухай хуулийг 1997 онд баталснаас хойш нааштай ахиц гарсан боловч түүнийг хэрэгжүүлэх журам зааврыг хожимдуулж нэвтрүүлсэн, мөн алт, зэс үйлдвэрлэгч нарт гэнэтийн ашгийн татварыг саяхнаас ногдуулах болсон нь энэ салбарт үйл ажиллагаа явуулах зардлыг нэмэгдүүлэхэд хүргэлээ. Гэнэтийн ашгийн татвар хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой мэтгэлцээнийг эцэслэн шийдвэрлэх шаардлагатай болж байна. 1997 онд хууль баталсны дараа Монгол Улсад ашигт малтмалын эрэл хайгуулын ажил огцом өссөн боловч уурхайн ашиглалтын чиглэлээр бодит хөрөнгө оруулалт хийгдсэнгүй. Энэхүү хуулийг 2006 онд шинэчлэн баталсан болно. 1997 оны хуультай харьцуулахад шинэ хуулийн заалтууд тодорхой биш, хөрөнгө оруулагч нарын хувьд төдийлөн ээлтэй бус боловч Засгийн Газраас орд ашиглалтын зориулалттай бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэсэн оролдлогыг энэхүү хуулиар хийсэн болно. Банк нь ил тод байдал, засаглал, байгаль орчин ба салбарын зохицуулалт зэрэг асуудалд түлхүү анхааран энэ салбарын тогтвортой хөгжлийг дэмжих зорилт тавьж байгаа болно.

Цаашилбал Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачилга (ЕИП)-ын хэрэгжилт нь шийдвэрлэвэл зохих асуудал хэвээр байна. Засгийн Газар Банк болон Дэлхийн Банктай бодлогын түвшинд яриа хэлэлцүүлэг хийсний дараагаар 2005 оны сүүлчээр ОСИТБС-ыг батлах тухайгаа зарласан боловч түүний хэрэгжилт удааширч байна. Банк нь ОСИТБС-ыг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэх талаар Дэлхийн Банк, Засгийн Газар, салбарын төлөөлөл болоод ТББ-уудын нийгэмлэгтэй нягт холбоотойгоор ажиллаж байна.

Үндсэн дэд бүтцийн хөгжлийг дэмжих

Дэд бүтэц дэх хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага асар их боловч, улсын төсвийн хөрөнгө хязгаарлагдмал, засгийн газрын баталгаатай зээлийг авахдаа 35 хувиас доошгүй хувийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр авах шалгуур үзүүлэлтийг хангасан байх зэргээс шалтгаалан хязгаарлагддаг юм. Дээрх нөхцөл байдлыг харгалзан, Банк нь засгийн газрын баталгаагүйгээр зээлийн эргэн төлөлтийг хийхэд шаардлагатай бэлэн мөнгөний урсгал бүрдүүлж чадахуйц улсын эзэмшлийн бус дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх боломжийг судална. Ийм боломж нисэх, цахилгаан харилцаа холбоо, зарим нийтийн аж ахуйн үйлчилгээ, түүнчлэн уул уурхайн салбарын хөгжлийг дагасан эрчим хүчний ба тээврийн шинэ дэд бүтцийг байгуулах чиглэлд байж болох юм. Улмаар, Банк нь ус, салхины эрчим хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчний үр ашигтай байж болох төслүүдийг судлах болно.

Банк нь засгийн газрын баталгаатай улсын эзэмшлийн дэд бүтцийг тодорхой сонголт хийх үндсэн дээр санхүүжүүлэхэд бэлэн байна. Ингэхдээ, санхүүжилтийн өртгийг бууруулах, зохих хөнгөлөлттэй нөхцлийг хангахын тулд хандивлагчдын буцалтгүй тусламжийн хөрөнгийг дайчлан гаргуулан, өөрийн санхүүжилтийн хамт ашиглах болно. Шилжилтийн Эхний Үе Шатан дахь Орнуудыг Дэмжих Санаачилга, хоёр талт тусламжийн хүрээнд ийм хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж өгөх юм. Жижиг хэмжээний, зорилтоо зөв тодорхойлсон (болж өгвөл олон улсын санхүүгийн бусад байгууллагуудаас санхүүжүүлэх томоохон хэмжээнээс бусад) төслүүд дээр анхаарлаа төвлөрүүлснээр Банк нь дорвитой үр дүнд хүрэх боломжтой гэж үзэж байна.

АХБ, ДБ болон Мянганы Сорилтын Корпораци зэрэг хоёр талт хандивлагч нартай хамтран ажилласнаар онгоцны буудал, авто зам, төмөр зам, эрчим хүч дамжуулах шугам барих төслүүдэд оролцох боломж Банкинд гарах болно. ДБ ба АХБ-ны Монголд хуримтлуулсан урт хугацааны туршлагыг харгалзан Банк нь аливаа давхардлыг арилгах, мөн эдгээр байгууллагуудаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд өөрийн хувь нэмрийг оруулж чадах төслүүдийг тодорхойлох зорилгоор тэдэнтэй нягт холбоо тогтоон ажиллах болно. Аль ч тохиолдолд Банк нь тус улсын хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийн асуудлууд дээр бусад хандивлагч нар, ОУСБ ба Монгол Улсын Засгийн Газартай нягт уялдаа холбоог ханган ажиллана.

Бодлогын түвшинд хийгдэх яриа хэлэлцүүлэг

Тухайн бүсэд үйл ажиллагаа явуулж хуримтлуулсан өвөрмөц туршлага ба мэдлэгт үндэслэн Банк нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, бизнесийн орчинг боловсронгуй болгох, өөрчлөлт шинэчлэлийн хүчин чармайлтыг дэмжих зорилгоор төр засгийн байгууллагуудтай иж бүрэн бодлогын түвшний яриа хэлэлцүүлэг хийнэ. Либералчлал, арилжааны хэлбэрт оруулах ажлыг үргэлжүүлэх, сайн засаглал, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон Засгийн Газар хоорондын яриа хэлэлцүүлгийг илүү үр дүнтэй болгох нь Банкны шууд оролцоотой шийдвэрлэгдэх асуудлууд байх болно. Энэ зорилгоор Банк нь эрх бүхий байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалтын орчны асуудлаар зөвлөлдөх шинэ зөвлөл байгуулах санал дэвшүүлж байна. Банк нь уул уурхайн салбарыг хөгжүүлэх урт хугацаанд тогтвортой, шударга шийдлийг эрэлхийлэхэд Засгийн газар ба УИХ-д дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн болно. Ингэхдээ бусад ОУСБ ба бизнесийн хамтын нийгэмлэгтэй ажлаа нягт уялдуулан зохицуулна. Банкны Байгаль орчны талаархи бодлого ба Олон нийтэд өгөх мэдээллийн бодлого Монгол Улсад хэрэгжүүлэх бүх төслүүдэд хамаарах болно.

ТОВЧЛОЛЫН ЖАГСААЛТ

АХБ	Азийн Хөгжлийн Банк
СТДА	Санхүүгийн Технологи Дамжуулах Агентлаг
ЖУ	Жилийн уулзалт
МУЭ	Мөнгө угаахын эсрэг
ХТОХ	Хөгжлийн төлөө оролцооны холбоо
МБ	Монголбанк (Төв Банк)
БЗӨҮ (BAS)	Бизнесийн Зөвлөлгөө Өгөх Хөтөлбөр
МУЗТС	Монгол Улсад Үзүүлэх Зээл Тусламжийн Стратеги
НҮБОҮ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Орны Үнэлгээ
ТТОХН	Тусгаар Тогтносон Орнуудын Хамтын Нийгэмлэг
ЗШ	Зээлийн шугам
ХХЗХ	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
ОСХ	Тухайн Орны хувьд Баримтлах Стратеги ба Хөтөлбөр
ШХОХ (DIF)	Шууд Хөрөнгө Оруулалтын Хэрэгсэл
ШЗХ (DLF)	Шууд Зээлжилтийн Хэрэгсэл
ЭЗӨДЯБС	Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжих ба Ядуурлыг Бууруулах Стратеги
ОСИТБС (EITI)	Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачилга
ШЭҮОДС (ETCI)	Шилжилтийн Эхний Үе дэх Орнуудыг Дэмжих Санаачилга
БЗХ (ESAF)	ОУВС-ийн Бүтцийн Зохицуулалтын Хэрэгсэл
ЭЗБХКЗАХ	Эдийн засгийн байнгын хорооны Компанийн засаглалын ажлын хэсэг
ЕХ	Европын Холбоо
Евро	Евро
ҮГ	Үнэлгээний Газар
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
СБ	Санхүүгийн байгууллагууд
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
БНАГУ	Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс
GSM	Хөдөлгөөнт холбооны глобал систем
ГТХАС	Германы Техникийн Хамтын Ажиллагааны Сан
МХХУГ	Мэдээлэл Харилцаа Холбоо, Технологийн Удирдах Газар
МХХТХТ	Мэдээлэл Харилцаа Холбоо, Технологийн Хөгжлийн Төв
ICDF	Тайванийн Олон Улсын Хамтын Ажиллагаа Хөгжлийн Сан
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
ОУСБ	Олон улсын санхүүгийн байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
KfW	Сэргээн Босголтын Банк
KEGOC	Казахстаны цахилгаан эрчим хүчний компани
КТ	Кореа Телеком
ХЭЗШБ	Хууль эрх зүйн шинэчлэлийн баг
МСК	Мянганы Сорилтын Корпораци
МХАС	Монголтой Хамтран Ажиллах Сан
ДХХСХ (MCFF)	Дунд Хэмжээний Хамтран Санхүүжүүлэх Хэрэгсэл
ТЭХЯ	Түлш Эрчим Хүчний Яам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
БС	Бичил санхүү
МИАТ	Монголын Иргэний Агаарын Тээвэр
ХЗДХЯ	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
МНТ	Монгол Улсын төгрөг
ДБХЯ	Дэд Бүтцийн Хөгжлийн Яам
БЖҮ	Бичил ба жижиг үйлдвэр
БЖДҮ	Бичил ба жижиг дунд үйлдвэр
МЦХ	Монголын Цахилгаан Холбоо

БОХҮМХ	Байгаль орчныг хамгаалах үндэсний мөрийн хөтөлбөр
ТББ	Төрийн бус байгууллага
ӨЦҮЦ	Өнөөгийн цэвэр үнэ цэнэ
ХАЁТ (ODA)	Хөгжлийн албан ёсны тусламж
ЭЗХАХБ (OECD)	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага
ГТХЭГ	Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар
УТХОХ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ЯБӨХ	Ядуурлыг Бууруулах ба Өсөлтийн Хэрэгсэл
ХХО	Хувийн хэвшлийн оролцоо
СТГ	Суурин Төлөөлөгчийн Газар
РЖД	Оросын Төмөр Зам
ААХЦШ	Азийн амьсгалын хурц цочмог шинж тэмдэг
ШХАБ	Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
УҮГ	Улсын үйлдвэрийн газар
ТӨХ	Төрийн Өмчийн Хороо
TACIS	ТТУХН-т Үзүүлэх Техникийн Тусалцааны Хөтөлбөр
TAM	Turn Around Management-Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр
ТТ	Техникийн тусалцааны төсөл
ХДХ	Худалдааг Дэмжих Хөтөлбөр
НҮББОХХ	НҮБ-ын Байгаль Орчныг Хамгаалах Хөтөлбөр
НҮБХТХ	НҮБ-ын Хөгжлийн Тусламжийн Хөтөлбөр
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
ЮНИСЕФ	НҮБ-ын Хүүхдийн Сан
ЮНСИТРАЛ	НҮБ-ын Олон Улсын Худалдааны Хуулийн Комисс
Ам дол	АНУ-ын доллар
АНУ-ын ОУХА	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
ДБ	Дэлхийн Банк
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ДХБ	Дэлхийн Худалдааны Байгууллага
ДАС	Дэлхийн Амьтны Сан

Мөнгөний нэгж

евро	Европын Холбооны мөнгөн тэмдэгт
ам дол	АНУ-ын мөнгөн тэмдэгт
төгрөг	Монгол Улсын мөнгөн тэмдэгт

II. СТРАТЕГИ

1. Банкны санхүүжилтийн багц

1.1. Өнөөг хүртэлх хугацаанд явуулсан үйл ажиллагааны тойм

Монгол Улс Банкны 61 дэх гишүүнээр 2000 оны 11 дүгээр сард элсэж, 2006 оны 6 дугаар сард бүх гишүүн орнууд соёрхон баталсны дараа 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдөр тэрээр Банкны үйл ажиллагааны орон боллоо. Тус Банкны Ерөнхийлөгч энэ оны 9 дүгээр сард Монгол Улсад айлчлахад тус Банкны Улаанбаатар дахь Суурин Төлөөлөгчийн Газрыг нээв. Банкны үйл ажиллагаа эхэлснийг тэмдэглэх үүднээс Банк нь Монгол улсын бичил зээлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүгийн салбарт анхны төслөө баталж гарын үсэг зурсан.

Өнөөг хүртэл Банкны Монгол Улс дахь үйл ажиллагаа техникийн туслалцаагаар хязгаарлагдаж ирсэн. 2001 оны 3 дугаар сард Захирлуудын Зөвлөлөөс Монголтой Хамтран Ажиллах Сан (МХАС) байгуулахыг зөвшөөрөв. МХАС нь Япон (5 сая евро), Нидерланд (3.3 сая евро), Люксембург (1 сая евро) ба Тайван (1 сая евро) буцалтгүй тусламжийн журмаар тус тус хандивласан нийт 10.3 сая еврогийн хөрөнгөнөөс бүрдсэн юм. МХАС-ийн зорилго нь Монгол Улсын зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг техникийн туслалцаа үзүүлэх замаар жигдрүүлэхэд оршиж байсан юм. Уг Сан нь хувийн хэвшлийн, нэн ялангуяа жижиг дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжихийг зорьдог. Түүнчлэн санхүүгийн байгууллагууд, дэд бүтэц ба байгалийн нөөцийн зэрэг үндсэн салбарыг хөгжүүлэхэд туслана. Монгол Улсад эдийн засгийн болоод хууль эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын анхаарал татахуйц орчинг бүрдүүлэхэд туслэх нь Сангийн эн тэргүүний зорилт юм.

Хүснэгт 1 МХАС-ийн хүрээнд хэрэгжүүлсэн техникийн туслалцааны төслүүд- 2006 оны 10 дугаар сарын байдлаар

	ТТ-ны төслийн тоо	Нийт амласан дүн (мян €)	Нийт ашигласан дүн (мян €)	Нийт амласан дүнд эзлэх хувь хэмжээ - %
Санхүүгийн байгууллага	8	512	456	5.8
БЖҮ-ийн санхүүжилт	1	850	850	9.6
Харилцаа холбоо	2	550	466	6.2
Тээвэр	4	1,904	1,002	21.4
Эрчим хүч	1	500	271	5.6
Байгалийн нөөц/ уул уурхай	2	168	49	1.9
Боловсруулах үндсэн аж үйлдвэр	1	73	56	0.8
Удирдлагын Өөрчлөн Байгуулах ТАМ	24	2,395	1,796	26.9
Хөтөлбөр				
Эрх зүйн шинэчлэл	4	1,207	264	13.6
Бусад	8	735	718	8.3
Нийт дүн	55	8,894	5,928	100.0

Өнөөдрийн байдлаар Банкнаас техникийн туслалцааны 55 төслийг хэрэгжүүлж (түүний дотор оффис ажиллуулах зэрэг захиргааны 8 төсөл) МХАС-аас Монгол Улсад 8.9 сая еврогийн туслалцаа дэмжлэг батлагдсан. Техникийн туслалцаа нь санхүүгийн байгууллагууд, иргэний агаарын тээвэр, эрчим хүч, цахилгаан харилцаа холбоо зэрэг олон салбарыг хамарсан. Түүнчлэн МХАС нь эрх зүйн шинэчлэл, сургалтын хөтөлбөр, Удирдлагын Өөрчлөн Байгуулах ТАМ хөтөлбөр зэрэгт туслалцаа үзүүлдэг. МХАС-ийн шугамаар өнөөг хүртэл хэрэгжүүлсэн техникийн туслалцааны чухал ач холбогдол бүхий төслүүдээс заримыг дурдвал, арилжааны банкны ажилтнуудад зориулсан банкны үндсэн ур чадвар олгох сургалт, бичил санхүүгийн зөвлөх үйлчилгээ, эрчим хүч, харилцаа холбооны салбарын хувьчлал явуулахад зориулсан

зөвлөлгөө өгөх үйлчилгээ, нисэхийн салбарын мастер төлөвлөгөө боловсруулах, үндэсний агаарын тээврийн МИАТ компанийн менежментийн гэрээ, компанийн засаглал, баталгаат хэлцлийг хөгжүүлэх эрх зүйн шинэчлэлийн дэмжлэг зэргийг нэрлэж болох юм.

Монгол Улсыг үйл ажиллагааны орноор соёрхон баталсны дараа 2006 оны 11 дүгээр сард болсон МХАС-ийн хандивлагчдын Удирдах Хорооны хурлаас шийдвэрлэсний дагуу, МХАС цаашид дараах хоёр чиглэлийн техникийн туслалцаанд төвлөрч ажиллахаар болов. Үүнд: (а) зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилтийн тодорхой төслүүдийн бэлтгэл ажлыг хангах техникийн туслалцаа (техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан дүн шинжилгээ г.м), (б) Улаанбаатар хотын нийтийн тээврийн төслийн техникийн туслалцаа багтана. Дээр дурдсан техник туслалцааны хоёр төслийг 2007 оны 6 дугаар сарын эцсээр, хөрөнгийн ашиглалтыг 2008 оны 12 дугаар сар гэхэд дуусгавар болгосон байхаар Хорооноос шийдвэрлэсэн болно. МХАС-г ашиглаж дууссаны дараа Монголд хэрэгжүүлэх техникийн туслалцааны үйл ажиллагааг Шилжилтийн Эхний Үе дэх Орнуудыг Дэмжих олон талт хандивлагчдын сан ба хоёр талт хандивлагчдын хөрөнгөөр санхүүжүүлэх болно.

1.2 Шилжилтийн үр нөлөө ба авсан сургамж

Дээр дурдсанчлан Монгол дахь Банкны үйл ажиллагаа нь МХАС-ийн хүрээнд хэрэгжүүлсэн техникийн туслалцааны үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байв. 2005 оны 10 дугаар сард тус Банкны Үнэлгээний Газраас МХАС-ийн үйл ажиллагаанд дунд хугацааны үнэлэлт шалгалт хийж Банкны үндсэн зорилгод хэр зэрэг нийцсэн байдлыг үнэлэн шалгалтын дүнг үндэслэн зөвлөмж гаргасан юм.

Шалгалтын дүнгээс үзэхэд ТТ-ны төслүүд ерөнхийдөө амжилттай үр дүнд хүрч чаджээ. Хувийн компани буюу байгууллагуудад чиглэсэн төслүүд амжилтанд хүрсэн буюу буюу амжилтад хүрэх магадлал өндөр байв. Тухайлбал Хаан Банкинд үзүүлсэн БЖҮ-ийн зөвлөлгөө өгөх үйлчилгээ, Удирдлагыг үндсээр нь өөрчлөх ТАМ хөтөлбөр, сургалтын хөтөлбөрүүд багтаж байна. Эдгээр техникийн туслалцааны төслүүдийн амжилт Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөж Банкны үйл ажиллагааг нааштай хүлээж авсан.

Нөгөөтэйгүүр, улсын хэвшлийн аж ахуйн нэгжид чиглэсэн буюу илүү өргөн хүрээний зорилго агуулсан төслүүдийн үр дүн жигд бус байв. Үндэсний нисэхийн компанид үзүүлсэн техникийн туслалцаа, газрын тос боловсруулах үйлдвэрийн талаархи судалгаа зэрэг төслүүдийн үр дүн доогуур гарсан нь эрх бүхий байгууллагууд төслийн дараа хийгдэх хувьчлалыг явуулаагүйтэй холбоотой. Цахилгаан харилцаа холбоо ба эрчим хүчний салбар дахь хувьчлалын талаархи техникийн туслалцааны төслийн үнэлгээ цаашид хийгдэх ёстой.

Техникийн туслалцааны төсөл тус бүрээр гаргах дүгнэлтийн зэрэгцээ энэхүү шалгалтаар гаргасан ерөнхий дүгнэлт зөвлөмж бол оролцогч бүх талуудтай тогтмол уулзах замаар хандивлагч нартай илүү нягт холбоотой ажиллах ба тэдэнтэй ажлаа уялдуулан зохицуулах шаардлагатай гэж үзсэн болно.

2. Үйл ажиллагааны орчин

2.1 Өөрчлөлт шинэчлэлийн ерөнхий орчин

2.1.1 Улс төрийн байдал

Олон намын тогтолцоот ардчилал, олон ургалч үзлийг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улс үлэмж амжилт гаргаад байгаа билээ. Тус улсад олон тооны улс төрийн нам байдаг бөгөөд жинхэнэ сөрөг хүчин болж чадах ч нам бий. Мөн ТББ-уудын идэвхитэй сүлжээ бүрэлдэж чадсан. Хэвлэл мэдээлэл харьцангуй чөлөөтэй хөгжиж, хүний эрхийн нөхцөл байдал сайжирч түүнийг сахих тал дээр дэвшил гарч байна. Монгол Улс нь далайд гарцгүй, цөөн боловч тархмал хүн амтай бөгөөд Хятад, Орос улстай хил залгаа оршдог. Гадаад бодлогын хувьд хоёр томоохон бөгөөд

хүчирхэг хөршүүдтэйгээ харилцах харилцаанд тэнцвэртэй байдлыг бий болгохыг зорьж байна. 1992 онд батлагдсан Үндсэн Хуулиар тус улс парламентын засаглалтай болж Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-аас нэр дэвшсэн, Ерөнхий Сайд, Улсын Их Хурал (УИХ)-ын даргын албыг хашиж байсан Намбарын Энхбаяр 2005 оны 5 дугаар сард Ерөнхийлөгчөөр сонгогдсон. Тус сонгуулийн явцад жижиг зөрчил гарсныг ажиглагчид дурьдаж байсан.

Үндсэн хуульд заасны дагуу нэг танхимтай парламент болох УИХ-ыг дөрвөн жил тутамд сонгодог. УИХ-ын сонгууль хамгийн сүүлд 2004 оны 6-р сард болж улс төрийн намуудын аль нь ч Засгийн Газрыг дангаар байгуулахад хангалттай олонхийн санал авч чадаагүй билээ. Ийнхүү Монголын анхны эвслийн Засгийн Газар байгуулагдсан боловч хоёр жил хүрэхгүй хугацаанд ажилласан. 2006 оны 1 дүгээр сард МАХН-аас шинэ эвслийн Засгийн газрыг УИХ-д суудалтай жижиг намуудын оролцоотойгоор байгуулж МАХН-аас нэр дэвшсэн Миеэгомбын Энхболдоор тэргүүлүүлсэн. Шинэ Засгийн Газарт шийдвэрлэх асуудал олон байна. Тухайлбал, олныг хамарсан ядуурал, ажилгүйдэл, нийгэм эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад тогтвортой амжилтанд хүрэх зэрэг болно. Гадаад бодлогын хувьд хоёр томоохон бөгөөд хүчирхэг хөршүүдтэйгээ харилцах харилцаанд тэнцвэртэй байдлыг бий болгохыг зорьж байна.

2.1.2 Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын хууль эрх зүйн тогтолцоонд сүүлийн 15 жилд томоохон өөрчлөлт гарсан. Одоо хүчин төгөлдөр байгаа 1992 оны Үндсэн Хуулиар бүгд найрамдах улсын зарчимд суурилсан ардчилсан төрийг бий болгох үндэс суурийг тавьж өгсөн билээ. Монгол Улсын төрийн стратеги нь гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааг хөхүүлэн дэмжих замаар дотоодын нээлттэй зах зээлийг байгуулахад оршиж байна. Олон улсын жишигт нийцүүлэн бизнес арилжааны хууль тогтоомжийг баталж байгаа нь бизнесийн харьцангуй таатай орчинг бүрдүүлээд байна. Гэвч бизнесийн оршин тогтнохуйг хангах нь сорилт хэвээр байгаа бөгөөд засаг захиргааны зохион байгуулалт, одоогийн татварын тогтолцоо нь бизнесийн үйл ажиллагаанд томоохон саад болсоор байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засаг руу шилжих үйл явцад аж ахуйн үйл ажиллагааг зохицуулсан 500 гаруй хуулиуд сүүлийн арван жилд батлагдаж, аж ахуйн нэгж, татвар, банкны үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээл, арбитра, валют арилжаа зэрэг харилцааг зохицуулж байна. 2002 онд Иргэний Хуулийг баталсан нь орчин үеийн иргэний эрх зүйн тогтолцооны үндэс суурийг тавихад томоохон алхам болж чадсан. Иргэний Хуулийн зүйл заалтыг хоёрдогч хууль тогтоомж, шүүх засаглалаар дамжуулан зохих ёсоор хэрэгжүүлэх нь тухайн орны хууль тогтоох байгууллага, шүүх засаглалын шийдвэрлэх ёстой зорилт хэвээр байна. Түүнчлэн шүүгчид хэт хялбарчилсан, заримдаа хэт дур мэдэн шийдвэр гаргах хандлагатай болжээ. Авилгал газар авч байгууллагын үйл ажиллагаа үр ашиггүй оновчтой биш байна.

Цаашилбал, аж ахуйн нэгжид олгох зээл, тэр дундаа жижиг дунд бизнесийн зээлийн хүү өндөр байгаагийн зэрэгцээ урт хугацаат санхүүжилт дутагдаж байгууллагын бүтэц зохион байгуулалт зохих түвшинд хүрэхгүй байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор жижиг дунд бизнесийн шинэ хууль тогтоомж, татварын урамшуулал, зээлийн үйлчилгээ ойрын хугацаанд бий болно гэж найдаж байна. Мөн татварын удирдлага, банкны хяналт шалгалт, төрийн өмчит аж ахуйн нэгжийн өөрчлөн байгуулалтын чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарна гэсэн хүлээлт бий. Ядуурлыг бууруулах стратеги, концесси, барьцаат хэлцлийг зохицуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд Засгийн Газар анхаарч ажиллана.

2.1.3 Байгаль орчны асуудал

Монгол Улсад тулгараад байгаа байгаль орчинтой холбоотой шийдвэрлэвэл зохих гол асуудлууд нь байгалийн нөөцийн тогтвортой удирдлагын төлөвлөгөө байхгүй байгаа явдал, биологийн болон амьтны төрөл зүйл устаж үгүй болох аюул зэрэг болно. Эдгээр нь хууль бус ан агнуур, амьтан ургамлын амьдарч ургах орчин алдагдах явдал, ой сүйтгэлт, бэлчээрийн талхлалт, уул уурхай, томоохон хэмжээний усан цахилгаан станцын үйл ажиллагаанаас намаг,

гол мөрөнд үзүүлж буй хохирол, мал аж ахуйг зохисгүй байдлаар эрхэлсний улмаас үүдсэн цөлжилт, бэлчээрийн даац хэтрүүлэлт, хөрсний идэгдэл, уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас үүссэн газрын хөрсний талхлалт, усны бохирдол; усны эрэлт хэрэгцээ эрс нэмэгдсэн, хангалттай нийлүүлэлт байхгүй, нүүрсээр ажилладаг цахилгаан станци, ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар түлш шатааснаас үүдсэн агаарын бохирдол, аюултай болоод аюулгүй хог хаягдлыг зохих ёсоор зайлуулахгүй байгаа зэрэгтэй шууд холбоотой. Дээрхи асуудлын талаар нарийвчилсан судалгаа, үндсэн мэдээлэл байдаггүй учраас эдгээр асуудлыг тодорхойлж зохицуулан шийдвэрлэх боломжгүй байна.

Байгаль Орчны Үндэсний Мөрийн Хөтөлбөрт Засгийн Газрын тэргүүлэх чиглэлийг тогтоож байгаль орчны чанарыг хамгаалах, байгалийн нөөцийн хамгаалал, байгууллагын чадавхийг бэхжүүлэх асуудлуудыг тусгаж 2010 он хүртэл авах хэмжээг зааж өгсөн. Уг Хөтөлбөр нь цөлжилт, ойжуулалт, биологийн тархац, ус, ховор амьтны төрөл зүйлийн хамгаалал, хадгалж үлдээх зэрэг чиглэлээр үндэсний байгаль орчны 25 орчим хөтөлбөрийг өөртөө багтаасан.

Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Тусгай хамгаалалттай газрын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Ой, хээрийн ан амьтан, ан агнуурын тухай, Газрын нөөцийг хамгаалах тухай, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай, болон Ашигт малтмалын тухай хууль зэрэг нь байгаль орчны асуудлыг зохицуулсан гол хуулиудыг бүрдүүлж байна. Монгол Улс нь хэд хэдэн олон улсын байгаль орчны конвенцид нэгдсэн байна. Байгаль орчны ТББ-ын үйл ажиллагааг гол төлөв гадаадын хандивлагчид дэмждэг бөгөөд ТББ-уудын ихэнх нь Улаанбаатар хотод төвлөрч, байгаль орчны асуудлыг сурталчлан ойлгуула, хамгаалал, ойжуулах үйл ажиллагаанд чиглэж байна.

Банкны зүгээс Монголд хэрэгжүүлж болох төслийн нарийвчилсан дүн шилжилгээг хийхээр төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр тус Банкнаас явуулах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй байгаль орчин, нийгэм эдийн засаг, хөдөлмөр хамгаалал, орон нутгийн иргэдийн оролцоо, соёлын өвтэй холбоотой асуудлыг тодорхойлох юм. Түүнчлэн ийнхүү олж тогтоосон болзошгүй сөрөг үр дагаврыг багасгахад чиглэсэн байгаль орчны болоод нийгмийн арга хэмжээг боловсруулах, Монгол Улсад хэрэгждэг байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн үндэсний болоод олон улсын дүрэм журам, стандарт, салбарын түвшний оновчтой стандартууд, ялангуяа байгалийн нөөцийн олборлолтын үйл ажиллагааны стандартуудыг мөрдүүлэх тал дээр Банкны зүгээс өөрийн үйлчлүүлэгчидтэй нягт хамтран ажиллах болно. Банкны Байгаль Орчны Бодлогод заасны дагуу өөрийн төслүүд дээр олон нийтийн хэлэлцүүлгийг хөхиүлэн дэмжиж, мэдээ мэдээллийг нээлттэй байлгах болно. Эрчим хүчний үр ашиг, хог хаягдал, байгаль орчны удирдлага болон бусад чиглэлд боломжийг олж тогтоон, одоо хэрэгжиж байгаа эсхүл цаашид хэрэгжих боломжтой хөрөнгө оруулалтын төсөлтэй холбоотой байгаль орчин, хөдөлмөр, иргэний нийгмийг хөгжүүлэх асуудал, байгууллагын чадавхийг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор техникийн хамтын ажиллагааны санаа санаачлагыг дайчлах болно.

2.1.4 Нийгмийн асуудал

Монгол Улс 2.6 сая хүн амтай нь тус улсын асар том нутаг дэвсгэрийн хэмжээтэй (1.6 сая км кв.) харьцуулахад нилээд жижиг юм. Хүн ам нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн бөгөөд ерөнхий нэг үндэстэн зонхилсон байдаг. Гэхдээ цөөн тооны жижиг үндэстэн бий. Тухайлбал, 100,000 орчим хүнийг багтаасан Казах үндэстний ихэнх нь тус улсын баруун хэсэгт амьдардаг.

Өнөөдөр нийт хүн амын 60 хувь нь хот суурин газарт оршин амьдарч байна. 1999-2001 оны хэд хэдэн удаагийн байгалийн гамшгийн дараа хөдөөнөөс хот уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдсэн. Эдгээр гамшгийн дүнд олон тооны малчид орлогогүй болж ажил хийх, орлогын өөр эх үүсвэртэй болох, дэд бүтэц, үйлчилгээ хүртэх зорилгоор хот суурин газар руу нүүх болсон. Эмч, багш зэрэг мэргэжлийн боловсон хүчин мөн хөдөө орон нутгаас хот суурин газар уруу шилжин суурьшсан. Үүний улмаас хөдөө орон нутгийн нийгмийн дэд бүтцийн хүртээмж муудаж байна.

НҮБХХ-өөс гаргасан Монгол Улсын Эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдлын 2005 оны тайланд 1990 оноос хойш эдийн засгийн эмзэг байдал нэмэгдсэн гэж дурджээ. Тэгсэн хэдий ч, 2002 онд 36 хувьтай байсан ядуурал 2006 онд 32 хувь болж буурсан.¹ Хөдөөгийн ядуурал 43 хувьтай байхад хот суурин газрынх 30 хувьтай байна.² Ажилгүйдэл 2004 оны байдлаар 3.6 хувьтай байсан гэсэн албан ёсны статистик байгаа ч, дутуу тооцоологдсон үзүүлэлт мэт санагдана. Гэхдээ 2000 оны хүн амын тооллогоор бодит ажилгүйдлийг 17 хувьтай гэсэн тооцоо гарсан. Ажилгүйдлийн ихэнх нь залуу ажиллах хүчин бөгөөд хөдөө орон нутгийн хүмүүс ажил хайж хот суурин газар ирснээс ажилгүйдлийн түвшин өндөр байна.

Бүсийн бусад улс орнуудтай харьцуулахад Монголд жендерийн тэгш байдал харьцангуйгаар хангагдсан гэж хэлж болно. Эмэгтэйчүүд нийт ажиллах хүчний тэн хагасыг бүрдүүлж, өрхийн орлогын гол хэсгийг бүрдүүлдэг эмэгтэйчүүд цөөнгүй байна. Гэвч сүүлийн үед явуулсан судалгаа³, статистик тоо мэдээ, дүн шинжилгээнээс харахад эдийн засгийн шилжилтийн үр дагавар эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд ялгаатай туссан байна. Энэхүү өөрчлөлтийн шатанд жендерийн ялгаа үүссэн нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон асуудал дээр Монголын хувьд шинэ зүйл болж байна. Засгийн Газрын 2006 оны 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий Сайдаар ахлуулсан Жендерийн Тэгш Байдлын Үндэсний Хороог жендерийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор байгуулж, энэхүү бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг нь үнэлэх зорилго тавьсан.

Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гол конвенцүүдийг бүгдийг соёрхон баталсан. Албадан хөдөлмөр эрхлүүлэхийг хуулинд тусгайлан хориглож Засгийн Газраас уг заалтыг мөрдүүлж ажиллаж байна. Засгийн Газар ОУХБ-ын Албадан Хөдөлмөрийн эсрэг Конвенцид нэгдэн орсон. 16-аас доош насны хүүхдийг хөдөлмөр эрхлэхийг хуулиар хориглосон хэдий ч, 14-15 настай хүүхдүүд эцэг эхийн зөвшөөрлөөр долоо хоногт 30 хүртэл цаг ажиллахыг зөвшөөрдөг. 18 нас хүрээгүй хүүхдүүд шөнийн цагаар ажиллах, хүнд хүчир ажил хийх, уул уурхай, барилга угсралт зэрэг аюултай мэргэжлээр ажиллах нь хуулиар хориотой. Эдгээр хуулийн зүйл заалтын хэрэгжилт дутагдалтай байгаа нь хөдөлмөрийн байцагчид цөөн, нөгөөтэйгүүр, бие даасан аж ахуйн нэгжийн тоо олширч байгаатай холбоотой.

Хүүхдүүд албан бусаар жижиг худалдаа эрхэлж, хогийн цэг дээр хог түүж, зохих зөвшөөрөлгүй жижиг уурхайд ажиллаж, мал маллаж байна. Хүүхдийн хөдөлмөр гол төлөв хөдөө аж ахуйд тохиолдож байгаа тул аюулгүй гэж тооцогддог. Архидан согтууралт нэмэгдэж, эцэг эхийн хараа хяналт байхгүй болсноос олон тооны хүүхдүүд өөрсдийгөө, ах дүүгээ, заримдаа эцэг эхээ тэтгэх зорилгоор орлого олохоос өөр аргагүй байдалд ордог байна. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн тоо ойролцоогоор 58,000 гэсэн өндөр тооцоо гарчээ. Засгийн Газар хүүхдээр албадан хөдөлмөр эрхлүүлэхийг хориглож, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ажил эрхлэлтийг дэмжих тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг УИХ-аас батлахдаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажил эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгод нийцүүлэхийг зорьсон. Ажил эрхлэлтийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, албан бус секторт ажиллагдсад, малчдад ажил эрхлэлтийн үйлчилгээг хүргэх, шинэ үйлчилгээ, үйлчилгээ хүргэх арга замыг боловсруулах, Ажил Эрхлэлтийг Дэмжих Сангийн орлого бүрдүүлэлт, зарлагын журам, удирдлагын зохион байгуулалтыг сайжруулах зэрэгтэй холбоотой олон чухал зүйл заалтыг эдгээр нэмэлт өөрчлөлтөнд тусгажээ. Засгийн Газраас албан бус сектор дахь эрхлэлтийн талаар баримтлах бодлого боловсруулж гаргасан.

Шилжилтийн эдийн засаг бүхий бусад олон улс орнуудын адил Монгол Улс бэлгийн зорилгоор ашиглах, албадан хөдөлмөрийн зорилгоор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг хил дамнуулан наймаалах эх сурвалж орон болжээ. Мөн хүүхдийг тус оронд бэлгийн зорилгоор ашиглан мөнгө

¹ Монгол улсын 2006 оны Ядуурлын үнэлгээ, Дэлхийн Банк. Ядуурлын харьцааг сарын орлого нь 25,000 төгрөг (20 ам. долл) буюу түүнээс бага хүн амын хувьд тооцож гаргасан.

² Монгол Улсын 2006 оны Ядуурлын үнэлгээ, Дэлхийн Банк.

³ Монгол Улсын жендерийн үнэлгээ, Азийн хөгжлийн банк ба Дэлхийн банк, 2005.

олж байгаа асуудал тулгараад байна. Хил дамнуулан наймаалах үйл ажиллагааг зогсоох чиглэлээр тогтоосон стандартыг Монголын Засгийн Газар одоогоор бүрэн хангаж ажилладаггүй ч гэсэн, хангаж ажиллахын төлөө үлэмж хүч чармайлт гаргаж байгаа билээ. 2006 оны 3-р сард Хүүхэд Эмэгтэйчүүдийг Хил Дамнуулан Наймаалах, Бэлгийн Зорилгоор Ашиглахаас Хамгаалах Арга Хэмжээний Үндэсний Төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний гол зорилго нь хил дамнуулан наймаалахаас урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх, хил дамнуулан наймаалахын тухай ойлголтыг хүн амын дунд нэмэгдүүлэх, хохирогчдын хамгаалал, нөхөн сэргээлтийг сайжруулахад оршиж байна. Түүнчлэн Монгол Улсын төр хил дамнуулан наймаалахын тэмцэх арга хэмжээн дээр ТББ, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

2.2 Эдийн засгийн хөгжил ба шилжилтийн явцад хүрсэн ололт амжилт

2.2.1 Макро эдийн засгийн нөхцөл байдал

Монгол Улсын эдийн засагт хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуй давамгайлж ирсэн уламжлалтай. ДНБ дэх аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь хэмжээ 30 хувьтай байгаа бөгөөд уул уурхайн салбар давамгайлж байна (зэс, алт). Өнгөрсөн арван жилд ноос, ноолуурын үйлдвэрлэл мөн чухал байр суурь эзлэх болсон. Үйлчилгээний салбарын хөгжил хоцорсон хэвээр байгаа ч, гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулга, өрхийн орлого нэмэгдэж байгаатай холбоотойгоор хурдацтай өсөж байна. Эдийн засгийн өсөлт цаг агаарын нөхцөл байдал, дэлхийн зах зээл дээрх бараа түүхий эдийн үнээс (өөрөөр хэлбэл, нефть, метал, сүлжмэл эдлэлийн үнэ) хамааралтай байна. Шилжилт хийж байгаа бусад орнуудад тулгарч буй асуудлын олонхи нь тус орныг тойрон өнгөрөөгүй ч, Монгол Улсын нийт эдийн засаг харьцангуй таатай үр дүнг харуулж байгаа. Энэ нь шилжилтийн эхний шатанд тохиолддог коммунизмын дараахь эдийн засгийн “цочрол” харьцангуй богино хугацаанд туулж чадсантай холбоотой. ДНБ-ний одоогийн түвшинг (2005) 1990 оныхтой харьцуулахад бодит үзүүлэлтээр 30 хувиар өндөр байна. 2005 онд Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ 710 ам. долл байгаа нь тус орныг бага орлоготой улсын тоонд багтаасан хэвээр байна. Эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжиж, ядуурлыг бууруулах зорилгоор Засгийн Газраас үндэсний хөгжлийн төлөвлөгөөг Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжих, Ядуурлыг Бууруулах Стратегийн хэлбэрээр 2003 онд боловсруулж, одоо үндэсний хөгжлийн урт хугацааны стратегийг боловсруулах ажлыг хийж байна.

Өнгөрсөн арван жилийн туршид Монголын эдийн засаг эрс хүйтэн өвөл, боомын тархалт, бараа түүхий эдийн үнийн хэлбэлзэл зэрэг хэд хэдэн гадаад цочролын нөлөөнд орсон. Түүнчлэн 1990-ээд оны эхээр коммунизмын дараахь эдийн засгийн анхны цочролд автаж, шилжилтийн хугацаанд хэд хэдэн санхүүгийн хямрал тохиолдсон. Эдгээрээс шалтгаалан тус улс саяхныг хүртэл тогтвортой болж чадаагүй байсан билээ. Сүүлийн хэдэн жилд Монголын эдийн засаг тодорхой хэмжээнд тогтворжин үзүүлэлт сайжирсан. Бодит ДНБ 2004 онд 10.6 хувь, 2005 онд 6.2 хувиар тус өссөн. Энэхүү өсөлт нь цаг агаарын байдал тогтуун, мөн ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнэ өндөр байсан, алтны олборлолт нэмэгдсэн, уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт өссөн, өрхийн орлого, гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулга нэмэгдсэний дүнд хэрэглээ өссөн явдлаар тайлбарлаж болно. Оёмол Сүлжмэл Эдлэлийн Олон Талт Хэлэлцээрийн хүрээнд үйлчилж байсан квотын горим дуусгавар болсонтой холбоотойгоор оёдлын үйлдвэрлэл үлэмж буурсан.⁴

⁴ Оёмол эдэл, хувцасны салбарт Худалдаа, Тарифын тухай Ерөнхий Хэлэлцээрийн (ГАТТ) дүрэм заавар саяхныг хүртэл мөрдөггүй байсан бөгөөд томоохон импортлогч улсуудын зүгээс олон янзын квот тогтоох нь хэвийн үзэгдэл байв. Үүнийг Оёмол Сүлжмэл Эдлэлийн Олон Талт Хэлэлцээр гэж нэрлэдэг. Гэвч Уругвайн Хэлэлцээрийн эцэст квотын тогтолцоогоо хэвээр хадгалахыг хүссэн улсууд уг тогтолцоог дэс дараатайгаар дуусгавар болгож 2005 оны 1-р сарын 1-нд сүүлчийн квотыг хүчингүй болгохоор тохиролцсон. Хятад улс энэхүү квотын хүрээнд тодорхой лимиттэй байсан бол Монгол Улс огт квотгүй байсан. Квот дуусгавар болсноор Монгол Улсын оёмол, сүлжмэл эдлэлийн салбар олон улсын өрсөлдөөнд бүрэн хэмжээгээр нээлттэй болсон.

Монгол Улсын валютын горимд зохицуулалттай хөвөгч ханшны тогтолцоо үйлчилдэг бөгөөд харилцах дансны гүйлгээний зориулалтаар валютыг бүрэн хөрвүүлэх боломжтой. Төв банкнаас валютын ханш, дотоодын үнийн түвшний аль алиныг тогтвортой байлгах зорилт тавьж ажилладаг. Сүүлийн жилүүдэд бодлого оновчтой байсан нь валютын ханшийн харьцангуй тогтвортой байдлаас харагдаж байна. Сүүлийн жилүүдэд нийт мөнгө асар хурдацтай (2005 онд 37 хувиар) өссөн нь гадаад валют их хэмжээгээр орж ирсэн, банкны зээл олголт нэмэгдсэнтэй шууд холбоотой. Үүний зэрэгцээ шатахуун, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, цахилгаан, ус, халаалтын үнэ тариф үлэмж өссөн. Эдгээрийн дүнд инфляцийн дарамт үүсч, 2005 оны 6-р сард жилийн инфляцийн түвшин дээд хэмжээнд буюу 18 хувьд хүрсэн. Хятадаас хямд өртөгтэй бараа ихээр орж ирсэн, хүнсний барааны үнийн өсөлт хумигдсаны дүнд жилийн инфляци 2006 оны 8-р сард 5 хувь хүртэл буурсан байна.

Өнгөрсөн хэдэн жилд улсын төсвийн гүйцэтгэл сайжирсан. 2005 онд эдийн засгийн өсөлт, бараа түүхий эдийн үнэ олон улсын зах зээл дээр өндөр байсны дүнд төсвийн орлого нэмэгдсэн. Төсвийн зарлагын тухайд Засгийн Газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн тогтолцоог нэвтрүүлсний ачаар зарлагын удирдлага сайжирч төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2004 онд 40 хувь байсан бол, 2005 онд 34 хувь болж буурсан. 2005 оны төсөв 50 сая ам. долл-ын ашигтай (ДНБ-ний 3.2 хувь) гарсан нь эдгээр нааштай өөрчлөлтийг илтгэх бөгөөд 1992 оноос хойш улсын төсөв анх удаа ийнхүү ашигтай гарчээ. Гэвч ирэх хэдэн жилд улсын төсвийн зарлага нэмэгдэх төлөвтэй байна. Тухайлбал, 2006 оны төсөв төсвийн албан хаагчдын цалинг нилээд хэмжээгээр нэмэх, нийгмийн салбарын зарлагыг өсгөх төлөвлөгөөнүүд тусгагдсан.⁵ Цаашилбал татварын шинэчлэлийн хүрээнд 2006 оны 7-р сард татварын шинэ хууль тогтоомжийг УИХ-аас батлан гаргаж (2007 оны 1-р сараас хүчин төгөлдөр болох) НӨАТ, орлогын албан татвар зэрэг хэд хэдэн гол татварын хувь хэмжээг бууруулсан.⁶ Эдгээр татварын шинэчлэл нь 2006 оны улсын төсөвт төдийлөн нөлөөлөхгүй хэдий ч, 2007 он болон цаашид илүү үр дагавар үүсэх нь мэдээж.

Урсгал данс ашигтай гарах болсноор гадаад худалдааны гүйцэтгэл мөн сайжирсан. Ийнхүү сайжирсан нь ашигт малтмалын үнэ өндөр байсан, мөн гадаадаас орж ирэх мөнгөн гуйвуулга нэмэгдсэнтэй зарим талаар холбоотой. 2004 онд экспортын хэмжээ 872 сая ам. долл байсан бол, 2005 онд 1,069 сая ам.долл-т хүрсэн (23 хувийн өсөлт). Гадаадаас орж ирэх мөнгөн гуйвуулга 2003 онд 74 сая ам. долл байснаа, 2005 онд 134 сая ам. долл болж нэмэгджээ (ДНБ-д эзлэх хувь нь 5 хувь, 7 хувь тус тус байсан). 2005 онд Монгол Улсад үлэмж хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн (258 сая ам. долл буюу ДНБ-ний 13.7 хувь). Нөхцөл байдал ийм байхад Монголбанк 2003 онд 178 сая ам. долл байсан гадаад валютын нөөцөө сэргээн бүрдүүлж 2005 оны эцэст 333 сая ам. долл-т хүргэж чадсан (2.1 сарын импорттой тэнцэх хэмжээ).

2003-2004 онд Оросын Холбооны Улсад 250 сая ам. долл-ыг нэг удаагийн төлбөрөөр шилжүүлснээр Монгол Улс шилжилтээс өмнөх үед хамаарах өрийг барагдуулж чадсан. Гэвч гадаад өр (Орос улсад төлөх хоёр талт өр ороогүй) нэрлэсэн хэмжээгээрээ 2002 онд 978 сая ам. долл байсан бол, 2005 онд 1,308 сая ам. долл болж аажмаар өсчээ. Тэгсэн хэдий ч, энэ хугацаанд эдийн засгийн өсөлт өндөр байсны дүнд өр, ДНБ-ний харьцаа 2002 онд 99 хувь байсан бол, 2005 онд 71 хувь болтол эрс буурсан байна (2006 онд 62 хувьд хүрэх тооцоотой). Монгол Улсын гадаадын өрийн ихэнх хэсгийг урт хугацааны туршид төлж барагдуулах бага хүүтэй олон талт зээл эзэлж байгаа явдал нь өнөөгийн өртгөөр илэрхийлсэн өр, ДНБ-ний харьцааг 43 хувь болтол бууруулж өгч байна. Өрийн үйлчилгээний жилийн зардал бага хэвээр байгаа (бараа үйлчилгээний экспортын 2.3 хувьтай тэнцэж байгаа) нь үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа урт байдагтай холбоотой. ОУВС, Дэлхийн Банкны хамтран хийсэн өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр, өрийн дарамтанд орох эрсдэл дунд хугацаанд дунд зэрэг

⁵ 2006 онд төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн, 2007 онд дахин 20 хувиар нэмэх талаар яригдаж байна.

⁶ Татварын шинэ хууль тогтоомжинд (2007 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болох) аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар (жилийн орлогын түвшнээс хамаарч ногдох одоогийн 15/30 хувийн шатлалаас 10/25 хувийн шатлал уруу), НӨТ-ийг 15-аас 10 хувь болгож бууруулах заалт орсон. Хүн амын орлогын албан татварын хувь хэмжээ орлогын хэмжээнээс хамааран ногдож байсан 10-30 хувиас 10 хувь дээр нэгтгэгдэж байгаа.

гэсэн дүгнэлт гарсан. Гэхдээ өрийн удирдлагын стратегиас хазайх, эсхүл томоохон гадаад цочрол үүсэх (жишээлбэл, худалдааны нөхцлийн цочрол) нөхцөлд гадаад өрийн үзүүлэлт тогтвортой байдлаа алдана гэдгийг мөн дурьдсан. Засгийн Газраас улсын өрийг зохистой удирдлагаар хангах шаардлагыг ойлгож байгаа бөгөөд хөнгөлөлттэй бус нөхцлөөр зээл авахаас татгалзах болно.

2.2.2 Шилжилтийн явцад хүрсэн ололт амжилт ба шийдвэрлэгдээгүй асуудлууд

2.2.2.1 Шилжилтийн явцад хүрсэн ололт амжилт

Банкнаас гаргадаг шилжилтийн үзүүлэлтээс харахад, Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих өнгөрсөн 15 жилд либеральчлал, бүтцийн өөрчлөлтийн чиглэлээр том амжилт гаргасан байна.⁷ ТТУХН-ийн шилжилтийн эдийн засаг бүхий улс орнуудтай харьцуулахад Монгол Улс харьцангуй сайн үзүүлэлттэй гарч байна (Хүснэгт 2-1-ийг үзнэ үү). Үнэ, худалдааг чөлөөлөх, жижиг болон томоохон хэмжээний өмч хувьчлалын тал дээр харьцангуй илүү амжилт гаргаж чадсан. Бусад тал дээр буюу санхүүгийн байгууллагад шилжилт хийх, үйлдвэрийн өөрчлөн байгуулалт, дэд бүтцийн салбарт ТТУХН-ийн дундажтай ойролцоо байна.

Монгол шилжилтийн эхний үе шатанд үнийг чөлөөлж, 1991-ээс 1993 оны хооронд цалин, ихэнх үнийн зохицуулалтыг зогсоож, 1996 онд бүх үнийг чөлөөлж дуусчээ. Худалдааг чөлөөлөх үйл ажиллагаа мөн хурдан явагдсан. 1993 онд урсгал дансыг бүрэн хөрвөх чадвартай болгож үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийг чөлөөтэй хөрвөдөг болгосон. Гадаад валютын зах зээл дээрх Монголбанкны оролцоо ханшны хэлбэлзлийг багасгах цорын ганц зорилго агуулж байдаг. Монгол улс импортын ихэнх тарифаа 1993 онд 10 хувь болгон бууруулж, түүнээс хойш худалдааны саадыг багасгах ажлаа үргэлжлүүлэн ДХБ-ын гишүүнээр 1997 онд элссэн. Одоогоор импортын хувьд 5 хувийн нэгдсэн тариф үйлчилж байна. 1991 оноос хойш гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, өмчийн эрх, компанийн тухай хууль, зохицуулалт, өрсөлдөөнийг зохицуулсан хууль тогтоомж нь олон улсын жишигт ерөнхийдөө нийцсэн боловч, хэрэгжилт нь сул гэж үздэг.

Хүснэгт 2-1 Монгол болон ТТУХН-ийн шилжилтийн үеийн үзүүлэлтүүд, 2006 он

Улсууд	Хувьчлал ба хувийн хэвшил			Зах зээл ба худалдаа			Санхүүгийн байгууллагууд		Дэд бүтэц
	Томоохон хувьчлал	Жижиг хувьчлал	Засаглал ба үйлдвэрийн өөрчлөн байгуулалт	Үнийн чөлөөлөлт	Худалдаа, гадаад валютын горим	Өрсөлдөөний бодлого	Банкны шинэчлэл ба зээлийн хүүгийн чөлөөлөлт	Үнэт цаасны зах зээл ба ББСБ	
Армени	4-	4	2+	4+	4+	2+	3-	2	2+
Азербайжан	2	4-	2+	4	4	2	2+	2-	2
Беларус	1	2+	1	3-	2+	2	2-	2	1+
Гүрж	4-	4	2+	4+	4+	2	3-	2-	2+
Казахстан	3	4	2	4	3+	2	3	3	2+
Киргиз	4-	4	2	4+	4+	2	2+	2	2-
Молдов	3	3+	2	4-	4+	2	3-	2	2+
Монгол	3	4	2	4+	4+	2	2+	2	2
Орос	3	4	2+	4	3+	2+	2	3-	3-
Тажикистан	2+	4	2-	4-	3+	2-	2	1	1+
Туркменистан	1	2	1	3-	1	1	1	1	1
Украин	3	4	2	4	3+	2+	3-	2+	2
Узбекистан	3-	3	2-	3-	3-	2-	2-	2	2-
ТТУ-ын дундаж	3-	3+	2	4-	3+	2	2+	2	2
ЕСБХБ-ны дундаж	3	4-	2+	4	4-	2+	3	2+	2+

Тайлбар: Индекс 1-ээс 4+ гэсэн үнэлгээ авч болох бөгөөд 1 нь амжилт бага буюу огт ахиц байхгүй, 4+ нь хөгжингүй эдийн засгийн стандарттай дүйцэхүйц түвшинг илэрхийлнэ. Аргачлалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2006 оны Шилжилтийн тайлангаас үзнэ үү.

Эх сурвалж: ЕСБХБ-ны 2006 оны Шилжилтийн тайлан.

⁷ Монгол улсын шилжилтийн үзүүлэлтүүдийг ЕСБХБ-наас тооцоолохдоо өнгөрсөн хугацааны тоо мэдээн дээр суурилсан бөгөөд АНУОУХА-ийн тус дэмжлэгийг авч 2006 оны 3-р сард бусад улсуудын хувьд ашигласан аргачлалыг хэрэглэсэн болно.

Хувийн хэвшлийн хөгжил

Жижиг хэмжээний хувьчлалыг харьцангуй хурдан хийж гүйцэтгэсэн. Хувьчлалыг 1990-ээд оны эхээр эрхийн бичиг тараах хөтөлбөрөөр эхлүүлж, 1993 он гэхэд жижиг аж ахуйн нэгжийн ихэнх нь хувийн өмчид шилжсэн байсан. Газрын тухай хоёр хуулийг баталж Монголын иргэд газар өмчлөх эрхтэй болсон бөгөөд гадаадын иргэд, компаниудад газар өмчлүүлэхийг хориглосон хэвээр байна. Томоохон аж ахуйн нэгжийн буюу өргөн цар хүрээтэй өмч хувьчлал 1997 онд эхэлж, хэд хэдэн төрийн өмчит аж ахуйн нэгжийг гол төлөв гадаадын компаниудад худалдсан билээ. Ингэснээр хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2005 онд 70 орчим хувь болж нэмэгдсэн. Засгийн Газраас өмч хувьчлалын шинэ стратегийг боловсруулж 28 аж ахуйн нэгжийн жагсаалтыг гаргасан боловч, ихэнх хувьчлал нь хойшлогдоод байгаа. Жагсаалтанд тусгагдсан аж ахуйн нэгжүүдээс Говь компани, нүүрсний уурхайнууд, МИАТ, эрчим хүчний салбарын компаниудын хувьчлал нилээд орлого авчрахаар байгаа. Говь компанийн хувьчлалыг 2006 оны эцэс гэхэд эцэслэх төлөвлөгөөтэй.

Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт удаан явагдсан. Төсвийн хязгаарлалтыг чангатгах, улсын төсвийн удирдлага, компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ аваад байна. Татаас, төрийн өмчит компани, ялангуяа ус, цахилгаан, дулааны компани хоорондын өрийн сүлжээ үлэмж хэмжээтэй хэвээр байна. Дампуурлын тухай хуулийг 1991 онд баталж 1994 онд нэмэлт өөрчлөлт оруулсан хэдий ч, хуулийн хэрэгжилт учир дутагдалтай байна. Компанийн засаглал мөн сул дорой байгаа нь компанийн тухай мэдээ мэдээллийг нээлттэй, ил тод болгодоггүй, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагддаггүйтэй зарим талаар холбоотой.

Бүсийн жишигтэй харьцуулбал Монгол Улс харьцангуй сайн бизнесийн орчинтой орон юм. Дэлхийн Банкнаас хийдэг Бизнес Эрхлэхүй судалгаагаар ихэнх үзүүлэлтүүд хөрш орон (Хятад, Орос), Төв Азийн орнуудаас өндөр гарсан байна (Хүснэгт 2-2-ийг үзнэ үү). Шинэ бизнес эрхлэх, тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал, ажилд авах, ажлаас халах, өмч хөрөнгө бүртгүүлэх зэрэг дээр сайн үзүүлэлттэй байна. Нэгдсэн дүнгээр 2006 онд судалгаанд хамрагдсан 175 орноос Монгол 45 дугаарт орсон байна.⁸ Татварын хуулинд хийсэн саяхны нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн татвар 30 хувиас 25 хувь, НӨТ 15 хувиас 10 хувь болж буурсан. Transparency International байгууллагаас гаргасан хамгийн сүүлийн Авилгын индексээр (CPI-2006) Монгол Улс ТТУХН-ээс илүү дээгүүр үнэлэгдэж, 163 орноос 99 дугаарт бичигдсэн байна. Харин энэ нь 2005 онд 158 орноос 85 дугаарт бичигдэж байсан үзүүлэлтээс ухралт болсон байна.

Хүснэгт 2-2 Дэлхийн Банкны Бизнес эрхлэхүй судалгаанаас авсан зарим үзүүлэлтүүд, 2006 он

	Монгол	Хятад	Орос	Казахстан	Киргиз
Шинэ бизнес эхлэхэд шаардагдах хугацаа (хоног)	20	35	28	20	21
Шинэ бизнес эхлэх зардал (нэг хүнд ногдох орлогын хувь хэмжээ)	5.1	9.3	2.7	7.0	9.8
Тусгай зөвшөөрөл авах журмын шат дамжлага (тоо)	18	29	22	32	20
Өмч хөрөнгө бүртгүүлэхэд шаардагдах хугацаа (хоног)	11	32	52	52	8
Зээл хялбар авах боломж (175 улстай харьцуулсан эрэмбэ)	65	101	159	48	65
Нийт татварын үүрэг (нийт ашгийн хувь)	32.2	77.1	54.2	45.0	67.4
Экспорт хийхэд шаардлагатай баримт бичиг (тоо)	11	6	8	14	NA
Экспорт хийх хугацаа (хоног)	66	18	39	93	NA
Гэрээг хэрэгжүүлэх хугацаа (хоног)	314	292	178	183	140

⁸ 2006 оны эрэмбэ 2005 оныхтой харьцуулахад сайжирсан байна (155 орноос 61 дүгээрт).

Эх сурвалж: Бизнес Эрхлэхүй 2006 оны тайлан, Дэлхийн Банк

Гэрээг хэрэгжүүлэх зардал (өр төлбөрийн дүнгийн хувь)	17.6	26.8	13.5	11.5	12.0
Бизнесийг хаах хугацаа (жил)	4.0	2.4	3.8	3.3	4.0
Бизнесийг хаах зардал (өмчийн хувь)	8.0	22.0	9.0	18.0	14.5

Уул уурхайн салбарын тухайд Монгол Улсад хийгдэж байгаа ашигт малтмалын хайгуулын ажил эрс нэмэгдсэн. Хайгуулын зориулалттай хөрөнгө оруулалт өндөр байгаа нь 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн үр нөлөө гэж үздэг бөгөөд энэ хуулийн үндсэн зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад оршиж байсан. 2005 оны сүүлээр Засгийн Газар Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачлагад нэгдэх бодолтой байгаагаа мэдэгдсэн. Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачлагын хүрээнд уул уурхайн компаниудын төлсөн татвар, түүнчлэн нефть, хий, уул уурхайн олборлолтоос улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг бүрэн хэмжээгээр нийтэлж тулган шалгах замаар байгалийн нөөцөөр баялаг орнуудын засаглалыг бэхжүүлэх чиглэлээр ажилладаг. Энэ нь Засгийн газрын зүгээс ил тод байдал, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хийж буй чухал алхам боловч, Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачлагыг хэрэгжүүлэх нь дунд хугацааны сорилт болох нь ойлгомжтой байна. Бараа түүхий эдийн үнэ буурах үед, мөн хөрөнгө оруулалтын заримыг санхүүжүүлэх зорилгоор ашигт малтмалтай холбоотой бүх орлогыг бүрдүүлэх зорилгоор Хөгжлийн сан бий болгосныг дурьдах нь зүйтэй.⁹

Нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодын аж ахуйн нэгжүүд Монголд бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийн талаар гомдол мэдүүлсэн хэвээр байна. Дэлхийн Банк саяхан хөрөнгө оруулалтын орчны тухай тайлан гаргасан бөгөөд уг тайланд хувийн хэвшлийн хөгжилд гол саад болж буй хүчин зүйлд (хөрөнгө оруулагчдын үзэж байгаагаар) авилгал ба Засгийн Газар, бизнесийнхний хоорондын харилцаанд ил тод байдал, тайлагнал дутагдаж байгааг дурджээ.

Үнийн өсөлтийн гэнэтийн ашгийн татварыг саяхнаас ногдуулж эхэлсэн, Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталсан нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулах зардлыг өсгөсөн байна. Зэс, алтны үнэ тодорхой түвшнээс давсан тохиолдолд олсон ашгаас 68 хувийн гэнэтийн ашгийн татвар авч байна.¹⁰ Ашигт малтмалын шинэ хуульд зааснаар уул уурхайн компаниуд хувьцаагаа Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалах үүрэг хүлээх (нийт хувьцааны 10 хувь) болсон. Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нэмж (2.5 хувиас 5 хувь болтол) Монгол Улсын нутаг дэвсгэр дээр олдсон стратегийн ач холбогдолтой орд газрын 50 хүртэл хувийг (хайгуулын ажлыг хувийн хөрөнгө оруулалтаар хийсэн бол 34 хувь) Засгийн Газар эзэмших эрхтэй болсон.¹¹ Татварын шинэчлэлийн хүрээнд татварын чөлөөлөлтийг хүчингүй болгосон. Ийнхүү шинэ арга хэмжээнүүд нь уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд тодорхой бус байдал, үйл ажиллагаа явуулах бодит зардлыг нэмлээ. Гэнэтийн ашгийн татварын тухай хуулийг баталснаас хойш Монголбанкинд тушаах алтны хэмжээ эрс буурч боловсруулах чиглэлээр хийхээр төлөвлөөд байсан томоохон хөрөнгө оруулалтууд хойшлогдлоо. Монгол Улсын хөрөнгө оруулалтыг татах чадварыг хадгалж үлдэх үүднээс Засгийн Газар, УИХ-аас хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай яригдаж байна.

Санхүүгийн салбарын хөгжил

⁹ Сангийн 2/3-ыг нийгмийн арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд зарцуулж 1/3-ийг ашигт малтмалын үнэ буурах үед ашиглах зорилгоор хадгална.

¹⁰ Нэг тонн зэсийн үнэ 2,600 ам. долл, нэг унц алтны үнэ 500 ам.долл, 2006 оны 11-р сарын дундуур зэсийн зах зээлийн үнэ 6,857 ам. долл, алтны үнэ 625 ам. долл байсан.

¹¹ Засгийн Газар уул уурхайн компанийн хувьцааг худалдаж авах хүсэлтэй байгаа бол бодит үнэ төлөх ёстой. Ашигт малтмалын шинэ хуулиар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хугацааг 30 жил болгож уртасгасан.

1990-ээд онд Монгол Улсад хэд хэдэн санхүүгийн хямрал болж өнгөрсөн (1994, 1996, 1998-1999). Эдгээр хямралуудын үед банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг нилээд өргөн цар хүрээтэй авч хэрэгжүүлсэн. Төрийн мэдэлд байсан бүх банкуудыг хувьчилж бусдыг нь татан буулгасан. Банкны салбарын өөрийн хөрөнгийн бааз суурь үлэмж нэмэгдсэн нь 2006 оны 3-р сард дүрмийн сангийн доод хэмжээг 8 тэрбум төгрөг (6.6 сая ам.доллтай тэнцэх) болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргасантай зарим талаар холбоотой. Одоогоор 17 банк үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрийн заримыг хувьчлах явцад гадаадын хөрөнгө оруулагчдад худалдсан билээ. Сүүлийн хэдэн жилд санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрс идэвхжиж дотоодод олгосон зээл, ДНБ-ний харьцаа 2002 онд 20 хувь байсан бол, 2005 онд 40 хувь болж хоёр дахин өсчээ.

Гэвч банкны салбар эмзэг хэвээр байна. Хувийн хэвшилд олгосон зээл эрс өссөхийн зэрэгцээ, чанаргүй зээлийн багц 2006 оны 8-р сарын байдлаар 30 хувиар нэмэгдсэн байна (гэхдээ чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурч байгаа).¹² Зээлийн дундаж хүү 20-иос дээш хувьтай байгаа учраас санхүүжилтийн өртөг өндөр хэвээр байна. Хадгаламжийн хүү, зээлийн хүүгийн зөрүү их хэвээр байгаа бөгөөд үлэмж хэмжээгээр буурсан байдал ажиглагдахгүй байна. Энэхүү зөрүү их байгааг өмчийн эрх баталгаажуулахгүй, нягтлан бодох бүртгэлийн стандартад итгэх итгэл байхгүй, зээлжилтийн ажиллагаа сул дорой байгаагаар тайлбарлаж болно. Нөгөө талаас, хадгаламжийн даатгал хөгжөөгүй байна. Гэхдээ хадгаламжийн даатгалын тухай төслийг боловсруулж байгаа.

Хөрөнгийн зах зээл бүрэн гүйцэд хөгжөөгүй хэвээр байна. Хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилждаг компанийн тоо хангалттай хэдий ч, арилжааны идэвхжил багаас гадна компаниуд хөрөнгийн зах зээлийг санхүүжилт бүрдүүлэх зорилгоор ашиглахгүй байна. 1990-ээд оны эхээр хөрөнгийн зах зээл өмч хувьчлалын эрхийн бичгийг хуваарилах үүрэгтэй байсан. 2006 онд 393 компанийн хувьцааны арилжаа явагдаж, үнэт цаасны зах зээлийн хөрөнгөжилт 68 сая ам. долл байлаа (ДНБ-ний 3.5 хувь). Зах зээл байгууллагын хөрөнгө оруулагчид, тэргүүлэх компаниуд байхгүй байгаагаас өмчийн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хүндрэлтэй байна. Даатгалын салбарт 22 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдний даатгалын хураамжийн орлого ДНБ-ний дөнгөж 0.7 хувьтай тэнцэж байна. Даатгалын компаниуд гол төлөв дараахь төрлийн даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: улсын нийгмийн даатгал, улсын эрүүл мэндийн даатгал, хувийн даатгал (өмчийн даатгал, гуравдагч талын хариуцлагын даатгал, гэнэтийн ослын даатгал). Даатгалын зах зээлийн 47 хувийг хамгийн том даатгалын компани эзэлж байгаа бөгөөд энэ зах зээл дээр өрсөлдөөн бараг байхгүй. Монголд хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоо, хөрөнгө оруулалтын сан үүсч хөгжөөгүй байна. 2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн дагуу Монголбанк нь даатгалын салбарыг зохицуулах үүрэг хүлээж байсан боловч, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах үүргийг Санхүүгийн Зохицуулах Хороонд саяхан шилжүүлжээ.

Дэд бүтцийн шинэчлэл

Зах зээлийн эрэлт хэрэгцээнд чиглэсэн дэд бүтцийн хөгжил Монгол Улсад дөнгөж бий болж байна. Дэд бүтцийн байгууламжийн ихэнх нь төрийн мэдэлд байсаар байгаа бөгөөд дэд бүтцийн компанийн өмч хувьчлал маш удаан явагдаж байна. Монголын төмөр замыг Монгол Улсын Засгийн Газар, Оросын төмөр зам хоёр 50 хувиар хуваан эзэмшдэг. Агаарын тээврийн салбарт нисэх онгоцны буудал, үндэсний агаарын тээврийн компанийн аль аль нь төрийн мэдэлд байж үйл ажиллагааг нь төр удирдаж байна (Монголд дотоодын нислэг үйлддэг хувийн агаарын тээврийн жижиг хэмжээний хэд хэдэн компани үйл ажиллагаа явуулж байна). Агаарын тээврийн компани, зарим усан хангамжийн компанийн удирдлагыг гадаадын компаниар гэрээний дагуу гүйцэтгүүлсэн туршлага бий. Эрчим хүчний салбарт 2001 оны 164-р дүгээр тогтоолын дагуу 18 хувьцаат компанийг үүсгэн байгуулсан боловч, хувьчлах асуудал түр хойшлогдоод байна. Харилцаа холбооны салбарт шугам сүлжээ төрийн мэдэлд байгаа. Суурин телефоны оператор болох Монголын Цахилгаан Холбоо Компанийн 40 хувийг Солонгосын

¹² Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ 1999 онд 51 хувь байсан бол, 2006 оны дундуур 6 хувь болж буурсан.

Корея Телеком компани эзэмшиж байна. Гэхдээ саяхан батлагдсан өмч хувьчлалын үндсэн чиглэл, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх тогтоолд суурин телефоны сүлжээг хүртээмжтэй болгох, цаашид Монголын Цахилгаан Холбоо компанийг хувьчлах асуудал тусгагдсан байна. Үүрэн телефоны салбарт хувийн хэвшлийн оролцоо хамгийн сайн хөгжиж чадсан. Одоогоор Мобиком, Скайтел гэсэн хоёр хувийн хэвшлийн оператор байгаа бөгөөд гуравдахь тусгай зөвшөөрлийг Юнител компанид саяхан олгосон.

Салбарын зохицуулалтын хувьд зохицуулалтын чиг үүрэг бодлого тодорхойлох, үйл ажиллагаа явуулахаас салангид хэрэгжиж байна (зөвхөн агаарын тээвэр, навигацийн үйлчилгээний салбарт зохицуулалтын чиг үүргийг үйл ажиллагаа явуулдаг компанид нэгтгэсэн байгаа). Сүүлийн жилүүдэд хэд хэдэн бие даасан зохицуулах агентлагийг байгуулсан. Тухайлбал, Харилцаа Холбооны Зохицуулах Хороог харилцаа холбооны салбарын зохицуулагчаар, Эрчим Хүчний Зохицуулах Газрыг эрчим хүчний зохицуулагчаар тус тус үүсгэн байгуулсан. Гэвч эдгээр агентлагууд нь саяхан байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрч амжаагүй бөгөөд зохицуулах чадавхи, үр ашгийг улам сайжруулах шаардлагатай. Монгол Улсад зохицуулалтын чиглэлээр тулгарч байгаа асуудалд үнэ тарифыг өртөг зардлыг нөхөхүйц хэмжээнд тогтоох, үйлчилгээг хөдөө орон нутагт бүх нийтэд хүртээмжтэй болгох, татаасын ил тод тогтолцоог нэвтрүүлэх зэрэг багтаж байна.

Монгол Улсад тарифыг өөрчлөн тогтоох нь улс төрийн хувьд эмзэг асуудал бөгөөд хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байсан. Төмөр зам (ачаа тээвэр), харилцаа холбооны салбар ашигтай ажиллаж байгаа ч, зарим нэг ашиглалтын компаниуд, тэр дундаа ихэнх эрчим хүч, усны компаниуд үйл ажиллагааныхаа зардлыг арай ядан нөхөж ажилласаар байна. Хандивлагч байгууллагууд зээлийг идэвхтэй олгож байгаа хэдий ч, олон компаниуд асар их өрөнд баригдаж зээлийн үйлчилгээний төлбөрөө хийхэд хүндрэлд орж байна. Тогтвортой үйл ажиллагаатай санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх нь Монгол Улсад зайлшгүй хэрэгцээтэй байгаа дэд бүтцийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байх болно.

2.2.2.2 Шилжилтийн үеийн шийдвэрлэвэл зохих асуудлууд

Энэхүү стратегийг хэрэгжүүлэх хугацаанд Монгол Улсад тулгарч буй шилжилтийн үеийн шийдвэрлэвэл зохих дараахь үндсэн асуудлууд байна. Үүнд:

Бизнесийн орчин, компанийн засаглалыг боловсронгуй болгох

ТТУХН-ийн шилжилтийн эдийн засаг бүхий орнуудтай харьцуулахад Монгол Улсын бизнесийн орчинг харьцангуй таатай гэж үзсэн байдаг. Гэсэн хэдий ч тус улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалт чухал ач холбогдолтой байгаа (тухайлбал, хөрөнгө, техник технологи оруулж ирэх г.м.), түүнчлэн ашигт малтмалын салбарт холбогдолтой батлан гаргасан хууль тогтоомжийн үр нөлөөний талаархи өнөөгийн сөрөг ойлголтыг харгалзан бизнесийн орчинг боловсронгуй болгоход саад тогтгор болж буй тодорхой бизнесийн хүчин зүйлүүдийг арилгах шаардлагатай байна (нэн ялангуяа авилгал, Засгийн Газар, бизнес хоорондын харилцаан дахь ил тод байдал, хариуцлагын хүрээнд). Цаашилбал ил тод байдал (түүний дотор нягтлан бодох бүртгэлийн стандарт ба мэдээллийг нээлттэй болгох асуудал), мөн компанийн засаглалыг улам боловсронгуй болгох шаардлагатай.

Хэдийгээр хувьчлалын үйл явц харьцангуй түргэн явагдсан боловч төрийн эзэмшилд үлдэж буй томоохон үйлдвэрийн газрын хувьчлал, тэдгээр дэх хувийн хэвшлийн оролцоог хойшлуулахгүй хэрэгжүүлэх нь зүйтэй. Хувьчлалын дараахь үе шатанд үйл ажиллагааны болоод санхүүгийн хүндрэлтэй тулгарч буй хувьчлагдсан үйлдвэрийн газруудын хувьд өөрчлөн байгуулалтын дорвитой арга хэмжээ үгүйлэгдэж байна. Төрийн өмчийн үйлдвэрүүдийг арилжааны хэлбэрт оруулах, корпорацжуулах ажлыг улам эрчимтэй явуулах шаардлагатай байна.

Санхүүгийн салбарыг бэхжүүлэн хөгжүүлэх

Хэдийгээр банкны салбарт ихээхэн ахиц гарсан боловч боломжийн хүүтэйгээр дунд ба урт хугацааны санхүүжилт авах боломж аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийн хувьд хүндрэлтэй хэвээр байна. Барьцаа, шүүхийн тогтолцоонд итгэх итгэл хангалтгүй байгаа нь зээлийн хүүг өндөр түвшинд хэвээр байхад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Дотоодын аж ахуйн нэгжүүдэд санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн зуучлалыг улам гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Нэн ялангуяа бизнес эрхлэгчид, бичил ба жижиг үйлдвэрүүдэд урт хугацааны санхүүжилт, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх шаардлагатай байна. Бодит салбар болон ипотек зэрэг шинэ бүтээгдэхүүнд зориулсан санхүүжилтийг шинээр хөгжүүлэх шаардлагатай болж байна. Хөрөнгийн зах зээлийн хөгжил эхний үе шатанд байгаа бөгөөд ил тод байдал, засаглал, зохицуулалт зэрэг бүхий л талаас нь бэхжүүлэн хөгжүүлэх учиртай. Эрэлт хэрэгцээний тал дээр, байгууллагын хөрөнгө оруулагчид болох даатгалын компани, хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан зэрэг тогтолцоог хөгжүүлэх нь нэн чухал болно.

Байгалийн нөөцийн салбарт өрсөлдөөнт ил тод орчныг бүрдүүлэх

Хэдийгээр 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг батлан гаргаснаар томоохон амжилтанд хүрсэн боловч түүнийг хэрэгжүүлэх журам заавар буюу хоёрдогч хууль тогтоомжийн хэрэгжилт удааширсан. Саяхан баталсан гэнэтийн ашгийн татвар, 2006 оны Ашигт малтмалын тухай хууль нь энэ салбарт үйл ажиллагаа явуулах өртгийг нэмэгдүүлж байна. Уул уурхайн салбар дахь бизнесийн орчин олон улсын түвшинд өрсөлдөхүйц байх явдлыг төр засгаас анхаарах ёстой. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагчдад үйл ажиллагаа явуулах тэгш нөхцлийг хангаж (Засгийн Газар, гадаадын хөрөнгө оруулагчдын хооронд эрсдлийг зохистой хуваарилах) Засгийн Газар, бизнесийн байгууллага хоорондын харилцан яриаг бэхжүүлэх үүргийг Засгийн Газар хүлээх учиртай. Цаашилбал Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачилгыг хэрэгжүүлэх нь шийдвэрлэвэл зохих томоохон асуудлын нэг хэвээр үлдэж байна.

Төрийн мэдлийн дэд бүтцийг арилжааны хэлбэрт оруулах ба хувийн хэвсгийн оролцоог дэмжих

Зах зээлд чиглэсэн өөрчлөлт шинэчлэлийн арга хэмжээ үгүйлэгдэж байгааг харгалзан төрийн мэдэлд хэвээр үлдэж буй үйлдвэрийн газруудыг арилжааны хэлбэрт оруулах буюу өөрчлөн байгуулахад чиглэсэн тууштай хүчин чармайлт шаардагдаж байна. Үнэ тарифыг шаардлагатай бол зохистой бөгөөд зардал нөхөхүйц түвшин хүртэл нэмэгдүүлэх, хараат бус зохицуулах байгууллагаар үр дүнтэй хянах учиртай. Үйлчилгээний төлбөрийн хураалтын хувь хэмжээг сайжруулахын зэрэгцээ татаасын шударга, ил тод тогтолцоог хөгжүүлж давхар татаасыг арилгах явдлыг дэмжих нь нэн чухал юм. Энэ асуудал нь нэн ялангуяа үйлчилгээний зардал өндөр, доогуур орлоготой хүн ам амьдардаг гэр хороололын хувьд хурцаар тавигдаж байна.

2.3 Хөрөнгө санхүүгийн хүртээмж

Монгол Улс нь томоохон газар нутагтай бөгөөд хүн ам нь нутаг дэвсгэрт тархан амьдардаг. Тээврийн найдвартай сүлжээ, бусад нэн шаардлагатай дэд бүтцийг бий болгоход ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг. Улсын төсвийн хөрөнгө оруулалт хоёр талт хандивлагчид, ОУСБ-ын албан ёсны санхүүжилтээс ихээхэн хамааралтай хэвээр байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улс хандивлагчдын хэд хэдэн зөвлөлдөх уулзалтыг амжилттай зохион явуулж хандивлагчдын хамтын нийгэмлэг тус улсын Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжих, Ядуурлыг Бууруулах Стратегийг дэмжихэд бэлэн байгаагаа илэрхийлсэн. Монгол Улс нь нийтдээ 250-300 сая орчим ам долларын Хөгжлийн Албан Ёсны Туслалцааг (ө.х. ДНБ-ийн 10 гаруй хувьтай тэнцэх) авч ашигласан. Томоохон хандивлагч нарын тоонд Япон, Азийн

Хөгжлийн Банк, Дэлхийн Банкны Бүлэг¹³ багтаж байна. Ойрын жилүүдэд буцалтгүй тусламжийн ихээхэн хэмжээний урсгал АНУ-ын Мянганы Сорилтын Корпорациас орж ирэхээр төлөвлөгдөж байна. Олон улсын санхүүгийн зах зээлээс зээлжих Монгол Улсын зэрэглэлийг авч үзвэл Фич байгууллага В+/Тогтвортой, Стандарт энд Пуэрс В/Эерэг, Муудис В+ гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна. Гэвч Засгийн Газар олон улсын бонд хараахан гаргаагүй байгаа болно.

Хувийн хэвшилд ч асар их хэмжээний хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага байна. Энэ нь нэн ялангуяа ордуудын давамгайлсан хэсгийг хараахан олборлоогүй байгаа уул уурхайн салбар, түүнчлэн өсөн нэмэгдэж буй өрхийн орлогыг дагаад түргэн өсч буй үйлчилгээний салбарт хамааралтай юм. Гэтэл дунд болоод урт хугацааны санхүүжилтийн олдоц харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна. Дотоодын зах зээл дээрх санхүүгийн хэлцэл үйлчилгээ нь голдуу богино хугацаагаар хийгдэж хүүгийн түвшин өндөр хэвээр байна. Ялангуяа бичил ба жижиг аж ахуйнууд, алслагдсан нутагт үйл ажиллагаа явуулдаг бизнесийн хувьд банкны зээл олдохгүй байна. Уул уурхайн салбар нь хувийн санхүүжилтийг татаж чадсан салбаруудын нэг мөн. Арван жилийн дотор энэ салбарт 700 гаруй сая ам. долл-ын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж иржээ. Худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, барилгын салбар нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж чадсан бусад салбарууд болно. Монгол Улсад хөрөнгийн бирж ажиллаж хувьцаа, үнэт цаасны аль алиныг арилжаалах боломжтой боловч тус зах зээлийн хөрвөх чадвар хязгаарлагдмал бөгөөд бизнесүүдийн хувьд санхүүжилтийн нэмэлт хөрөнгө босгох хэрэгсэл болж чадахгүй байна.

¹³ Монголд хуваарилсан хөгжүлийн албан ёсны туслалцааны хэмжээгээр эхний аравт орсон хандивлагчид (2003-04 оны дунджаар) - ОУЭЗХАБ-ын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Зөвлөлийн мэдээ.

3. Стратегийн үндсэн чиглэл

3.1 Банкны тэргүүлэх чиглэл

3.1.1 Хувийн хэвшлийн хөгжлийн санхүүжилт

Хувийн хэвшлийг дэмжих нь Банкны стратегийн хамгийн чухал зорилго мөн. Банк нь хөдөө аж ахуй, зочид буудал ба аялал жуулчлал, дэд бүтэц, хөрөнгө, үйлчилгээ, болоод хамгийн чухал нь уур уурхайн зэрэг хэд хэдэн гол салбарт шууд санхүүжилт хийх боломжийг судална. Түүнчлэн үлдэж буй томоохон өмч хувьчлал, төрийн өмчийн томоохон үйлдвэрийн газруудыг арилжааны хэлбэрт оруулах, корпорацжуулах ажлыг дэмжинэ. Энэ зорилгоор нэр хүнд бүхий олон улсын томоохон хөрөнгө оруулагчдыг татахыг зорьж ажиллана.

Монгол Улсыг ШЭҮШОДС-д (ETC Initiative) хамруулснаар Дунд Хэмжээний Хамтран Санхүүжүүлэх Хэрэгсэл (MCFF), Шууд Хөрөнгө Оруулалтын Хэрэгсэл (DIF) ба Зээлийн Шууд Санхүүжилтийн Хэрэгсэл (DLF), мөн тухайн компаниудын үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийх техникийн туслалцааны хөтөлбөрүүдэд хамрагдах, тус улсад санхүүжүүлэх төслүүдийг бэлтгэх боломжийг нэмэгдүүлэх юм. ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих хүчин чармайлтынхаа хүрээнд, Банк нь Удирдлагын Өөрчлөн Байгуулах Хөтөлбөр (TAM)-ийг хэрэгжүүлсэн туршлагад тулгуурлах ба цаашид Бизнесийн Зөвлөгөө Өгөх Хөтөлбөр (BAS)-ийг бий болгох чиглэлд ажиллана.

Бүрэлдэн хөгжиж буй хувийн хэвшлийн бүтцийг харгалзан Банкны зүгээс бичил бизнесийг тусгайлан анхаарч, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хувийн банкуудаас олгож буй бичил, жижиг бизнесийн зээлийн шугамыг бэхжүүлэн хөгжүүлэх, нэн ялангуяа илүү алслагдсан бүс нутагт хийгдэж буй үйл ажиллагааг хөгжүүлэх нь эн тэргүүний зорилт байх болно.

3.1.2 Санхүүгийн салбарыг бэхжүүлэх

Банкны хувьд санхүүгийн салбарт олгох дэмжлэг туслалцаа нь тэргүүлэх чиглэлийн гол зорилт байх болно. Арилжааны банкуудад урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр дутагдаж санхүүжилтийн өртөг өндөр байна. Банк нь санхүүгийн зуучлал, банкуудын нэгдэл нягтралыг бэхжүүлэх, ингэснээр тус орон дахь санхүүгийн хүртээмжийг сайжруулах зорилт тавьж байгаа. Энэ зорилгоор Банкны санхүүгийн ба үнэнч шударга байдлын (integrity) шалгуурыг хангасан арилжааны банкуудад төрөл бүрийн зээлийн шугам, өрийн санхүүжилтийн бүтээгдэхүүн олгох болно. Худалдааны санхүүжилт өндөр эрэлт хэрэгцээтэй байгаа тул Банк нь Худалдааг Дэмжих Хөтөлбөр (TFP)-ийг хэрэгжүүлэх ажлыг идэвхтэй эхлүүлнэ. Арилжааны банк, банк бус байгууллагуудад, ялангуяа нийслэлээс гадуур үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад зээлийн шугам нээх замаар бичил ба жижиг бизнесүүдэд зориулсан санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Монгол Улсыг үйл ажиллагааны орноор соёрхон баталснаас хойш хөдөө орон нутгийн санхүүжилтийн эрэлт хэрэгцээг дэмжих зорилгоор ЕСБХБ нь санхүүжилтийн анхны гэрээг бичил зээлийн тэргүүлэх байгууллагатай байгуулсан.

Банкны зүгээс банкнуудыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжийг эрэлхийлж, ингэснээр дотоодын банкнуудын хөрөнгөжилтийн суурийг бэхжүүлэн компанийн засаглалыг боловсронгуй болгох зорилго тавина. Түүнчлэн банк бус бичил санхүүгийн байгууллага, лизинг, орон сууцны ипотекийн зээл, хэрэглээний санхүүжилт, даатгал ба тэтгэврийн байгууллага зэрэг банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх явдлыг дэмжихэд хүчин зүтгэнэ. Улмаар хөрөнгийн зах зээлийн хөгжилд (дотоодын бонд, хувьцаа, ипотека, дотоодын валютаар санхүүжилт хийх) ихэвчлэн техникийн туслалцаа үзүүлэх замаар хувь нэмрээ оруулна.

Харьцангуй шинэ банк бус санхүүгийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, салбарын болоод түүний зохицуулагч (СЗХ)-ийн үндэс суурийг бэхжүүлэх зорилгоор Банк хандивлагчдын санхүүжилт, тэр дундаа ШЭҮОДС-ын Олон Талт Хандивлагчдын Хэрэгсэл (MDF) -ийн хөрөнгийг дайчлан гаргуулахад идэвхтэй ажиллах болно. Монгол Улсын Засгийн Газраас

дараах чиглэлийг дунд хугацаанд хөгжүүлэх зорилт тавьсан бөгөөд тэдгээрт техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор санхүүжилтийг эрэлхийлнэ. Үүнд:

- хөрөнгийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлж Хөрөнгийн Биржийг өөрчлөн байгуулах замаар Хөрөнгийн Биржийн үйл ажиллагааг идэвхижүүлэх;
- алслагдсан аймаг сумдад үйл ажиллагаа явуулдаг жижиг дунд үйлдвэрүүдэд тусгайлан шаардлагатай байгаа урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх;
- ипотекийн барьцаат үнэт цаасны зах зээлийг хөгжүүлж лизингийн үйлчилгээг нэвтрүүлэх;
- даатгал, тэтгэврийн тогтолцоог бий болгож нэн ялангуяа зохицуулагчийн чадавхийг бүрдүүлэх;
- сангийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх;
- банкны хяналт шалгалт, банк бус байгууллагын зохицуулалтыг дэмжих.

Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороотой бодлогын түвшинд хийх яриа хэлэлцүүлгийг идэвхтэй явуулж, ингэхдээ хяналт шалгалтыг боловсронгуй болгох, банкуудын нэгтгэл нягтралыг хөхиүлэн дэмжих, мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх зэрэг тодорхой асуудалд түлхүү анхаарна.

3.1.3 Байгалийн нөөцийн салбарын тогтвортой хөгжил

Монгол Улс ашигт малтмалын арвин их нөөцтэй бөгөөд энэ нь тус улсын ирээдүйг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах томоохон боломж бүрдүүлж байгаа юм. Дэлхийн Банкны ивээл дор боловсруулсан Ашигт малтмалын тухай хуулийг 1997 онд баталснаас хойш нааштай ахиц гарсан боловч, түүнийг хэрэгжүүлэх журам зааврыг хожимдуулж мөрдүүлсэн, мөн алт, зэс үйлдвэрлэгч нарт гэнэтийн ашгийн татварыг саяхнаас ногдуулах болсон нь энэ салбарт үйл ажиллагаа явуулах зардлыг нэмэгдүүлэхэд хүргэлээ. Гэнэтийн ашгийн татвар хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой мэтгэлцээнийг эцэслэн шийдвэрлэх шаардлагатай болж байна. 1997 онд хууль баталсны дараа Монгол Улсад ашигт малтмалын эрэл хайгуулын ажил огцом өссөн боловч уурхайн ашиглалтын чиглэлээр бодит хөрөнгө оруулалт хийгдсэнгүй. Энэхүү хуулийг 2006 онд шинэчлэн баталсан болно. 1997 оны хуультай харьцуулахад шинэ хуулийн заалтууд тодорхой биш, хөрөнгө оруулагч нарын хувьд төдийлөн ээлтэй бус боловч Засгийн Газраас орд ашиглалтанд хийгдэх бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэсэн оролдлогыг энэхүү хуулиар хийсэн болно. Банк нь ил тод байдал, засаглал, байгаль орчин ба салбарын зохицуулалт зэрэг асуудалд түлхүү анхааран энэ салбарын тогтвортой хөгжлийг дэмжих зорилт тавьж байгаа болно.

Цаашилбал Олборлох Салбарын Ил Тод Байдлын тухай Санаачилга (ЕИП)-ыг хэрэгжүүлэх асуудал нь шийдвэрлэвэл зохих асуудал хэвээр байна. Засгийн Газар Банк болон Дэлхийн Банктай бодлогын түвшинд яриа хэлэлцүүлэг хийсний дараагаар 2005 оны сүүлчээр ОСИТБС-ыг батлах тухайгаа зарласан боловч, түүний хэрэгжилт удаан байна. Банк нь ОСИТБС-ыг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэх талаар Дэлхийн Банк, Засгийн Газар, салбарын төлөөлөл болоод ТББ-уудын нийгэмлэгтэй нягт холбоотойгоор ажиллаж байна.

3.1.4 Үндсэн дэд бүтцийн хөгжлийг дэмжих

Дэд бүтэц дэх хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага асар их боловч улсын төсвийн хөрөнгө хязгаарлагдмал, засгийн газрын баталгаатай зээлийг авахдаа 35 хувиас доошгүй хувийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр авах гэсэн нөхцөл зэргээс хязгаарлагддаг юм. Дээрх нөхцөл байдлыг харгалзан, Банк нь засгийн газрын баталгаагүйгээр, зээлийн эргэн төлөлтийг хийхэд шаардлагатай бэлэн мөнгөний урсгал бүрдүүлж чадахуйц улсын эзэмшлийн бус дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх боломжийг судална. Ийм боломж нисэх, цахилгаан харилцаа холбоо, зарим нийтийн аж ахуйн үйлчилгээ, түүнчлэн уул уурхайн салбарын хөгжлийг дагасан эрчим хүчний ба тээврийн шинэ дэд бүтцийг байгуулах чиглэлд байж болох юм. Улмаар, Банк нь ус, салхины эрчим хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчний үр ашигтай байж болох төслүүдийг судлах болно.

Банк нь засгийн газрын баталгаатай улсын эзэмшлийн дэд бүтцийг тодорхой сонголт хийх үндсэн дээр санхүүжүүлэхэд бэлэн байна. Ингэхдээ, санхүүжилтийн өртгийг бууруулах, зохих хөнгөлөлттэй нөхцлийг хангахын тулд хандивлагчдын буцалтгүй тусламжийн хөрөнгийг дайчлан гаргуулан өөрийн санхүүжилтийн хамт ашиглах болно. Шилжилтийн Эхний Үе Шатан дахь Орнуудыг Дэмжих Санаачилга, хоёр талт тусламжийн хүрээнд ийм хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж өгөх юм. Жижиг хэмжээний, зорилтоо зөв тодорхойлсон (болж өгвөл олон улсын санхүүгийн бусад байгууллагуудаас санхүүжүүлэх томоохон хэмжээнээс бусад) төслүүд дээр анхаарлаа төвлөрүүлснээр Банк нь дорвитой үр дүнд хүрэх боломжтой гэж үзэж байна.

АХБ, ДБ ба Мянганы Сорилтын Корпораци зэрэг хоёр талт үндсэн хандивлагч нартай хамтран ажилласнаар онгоцны буудал, авто зам, төмөр зам, эрчим хүч дамжуулах шугам барих төслүүдэд оролцох боломж Банкинд нээгдэх болно. ДБ ба АХБ-ны Монголд хуримтлуулсан туршлагыг харгалзан, Банк нь аливаа давхардлыг арилгах, мөн эдгээр байгууллагуудаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд өөрийн хувь нэмрийг оруулж чадах төслүүдийг тодорхойлох зорилгоор тэдэнтэй нягт холбоо тогтоон ажиллах болно. Аль ч тохиолдолд Банк нь тус улсын хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийн асуудлууд дээр бусад хандивлагч нар, ОУСБ ба Монгол Улсын Засгийн Газартай нягт уялдаа холбоог ханган зохицуулна.

3.1.5 Бодлогын яриа хэлэлцүүлэг

Тухайн бүсэд үйл ажиллагаа явуулж хуримтлуулсан өвөрмөц туршлага ба мэдлэгт үндэслэн Банк нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, бизнесийн орчинг боловсронгуй болгох, өөрчлөлт шинэчлэлийн хүчин чармайлтыг дэмжих зорилгоор төр засгийн байгууллагуудтай иж бүрэн бодлогын түвшний яриа хэлэлцүүлэг хийнэ. Либералчлал, арилжааны хэлбэрт оруулах ажлыг үргэлжүүлэх, сайн засаглал, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон Засгийн Газар хоорондын яриа хэлэлцүүлгийг илүү үр дүнтэй болгох нь Банкны шууд оролцоотой шийдвэрлэгдэх асуудлууд байх болно. Энэ зорилгоор Банк нь эрх бүхий байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалтын орчны асуудлаар зөвлөлдөх шинэ зөвлөл байгуулах санал дэвшүүлж байна. Банк нь уул уурхайн салбарыг хөгжүүлэх урт хугацаанд тогтвортой, шударга шийдлийг эрэлхийлэхэд Засгийн газар ба УИХ-д дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн болно. Ингэхдээ бусад ОУСБ ба бизнесийн хамтын нийгэмлэгтэй ажлаа нягт уялдуулан зохицуулна. Банкны Байгаль орчны талаархи бодлого ба Олон нийтэд өгөх мэдээллийн бодлого Монгол Улсад хэрэгжүүлэх бүх төслүүдэд хамаарах болно.

3.2 Салбарын шийдвэрлэвэл зохих асуудлууд ба Банкны үйл ажиллагааны зорилго

3.2.1 Хувийн хэвшил

Тус салбар дахь Банкны шилжилтийн үндсэн зорилго нь эдийн засаг дахь хувийн хэвшлийн бааз суурийг бэхжүүлэхэд оршиж байна. Салбарын зах зээлийг зохих ёсоор ажиллуулах, өрсөлдөөн, компанийн засаглал, ил тод байдлын стандартыг сайжруулж бизнесийн үйл ажиллагаандаа дэлхий нийтийн шилдэг практик ажиллагаа ба хэрэглэгчид чиглэсэн чиг хандлагын шалгуур стандартыг нэвтрүүлж чадах хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Ихэнх хөрөнгө оруулалт жижиг тул (ингэснээр уламжлалт үйл ажиллагаа явуулах замаар дорвитой үр нөлөө гаргах Банкны боломжийг хязгаарлаж байгаа болохоор) ШЭҮШОД Санаачилгыг илүү чухал ач холбогдолтой болгож байна. Тус Стратегийг баримтлах хугацаанд Банк нь:

- Засгийн Газар, хөрөнгө оруулагчдаар компанийн засаглалын хатуу стандартыг батлуулахын төлөө хүчин зүтгэнэ. Дотоодын компаниудад зориулан ШЭҮШОД Санаачилгыг хэрэгжүүлнэ. Банкны шууд үйл ажиллагаатай нягт уялдуулан ТАМ Хөтөлбөрийг сэргээж, BAS Хөтөлбөрийг нэвтрүүлэхийг зорино.

- ШЭҮОД Санаачилгын хүрээнд Дунд Хугацааны Хамтран Санхүүжилтийн Хэрэгсэл, Шууд Зээлжилтийн Хэрэгсэл зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр түнш банкуудын томоохон харилцагчдад хүрэх боломжтой болно. Жижиг төслүүдийн хувьд Банкны санхүүжилтийг илүү үр дүнтэй болгохын тулд эдгээр хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад Банк дотроо нягт хамтран ажиллаж техникийн туслалцааг дайчлан шаардлагатай болно.
- Өмчийн хөрөнгө: өөрийн хөрөнгийн санхүүжилт хүрэлцээгүй байгаагаас түргэн хурдацтай хөгжиж буй бизнесийн байгууллагууд хөрөнгийн дутагдалд ордог. Иймээс Банк ШЭҮОД Санаачилгаар дамжуулан Шууд Хөрөнгө Оруулалтын Хэрэгслийн өөрийн хөрөнгийн санг нэмэгдүүлнэ.

3.2.1.1 ШЭҮОД Санаачилгын Олон Талт Хандивлагчдын Сан

2004 оны эхээр “Шилжилтийн Эхний Үе Шат дахь Орон” дахь үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх зорилгоор Банк шинэ санаачилгыг эхлүүлсэн юм. Түүнд ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулдаг буурай хөгжилтэй Армени, Азербайжан, Гүрж, Киргиз, Молдов, Тажикистан, Узбекистан зэрэг орнууд багтаж байна. 2004 оны 11 дүгээр сард үйл ажиллагаагаа эхэлсэн ШЭҮО-ын Олон Талт Хандивлагчдын Сан нь ШЭҮО Санаачилгад багтсан орнууд дахь Банкны туслалцааны үр дүнг нэмэгдүүлэх, хандивлагчдын дэмжлэг туслалцааны ерөнхий уялдаа зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн юм. ШЭҮО Сан нь хоёр талт хандивлагчдын санхүүжилтийн сувгаар дамжуулан үзүүлдэг туслалцааны хүрээнд ажилладаг. Өнөөдрийг хүртэл тус Санд 12 хандивлагч орноос нийт 37 сая еврогийн тусламжийн хөрөнгийг амлаад байгаа. ШЭҮО Сангийн хөрөнгө нь зах зээлд суурилсан эдийн засагт шилжиж буй орнуудын тогтвортой хөгжлийг, ингэснээр эдгээр орнууд дахь ядуурлыг бууруулахыг дэмжсэн төсөл санаачилгад зориулагддаг.

Монгол Улсыг ШЭҮО-ны найм дахь орноор Банкны Захирлуудын Зөвлөл баталж 11 дүгээр сарын 17-ны өдөр ШЭҮО-ын Олон Талт Хандивлагчдын Сангийн тусламжийг хүлээн авах эрх нь нээгдсэн. Монголд хэрэгжүүлэх техникийн туслалцааны санхүүжилтийн гол эх үүсвэр болж байсан Монголтой Хамтран Ажиллах Сан одоо төслийн бэлтгэл хангах техникийн туслалцаа (техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан дүн шилжилгээ гэх мэт) болон Улаанбаатар хотын нийтийн тээврийн төслийн техникийн туслалцаа гэсэн үндсэн хоёр чиглэлд төвлөрч зарцуулагдаж байна. МХАС нь 2007 оны 6 дугаар сар гэхэд үйл ажиллагаагаа зогсоож, 2008 оны сүүлчээр тусламжийн хөрөнгийн эцсийн зарцуулалт хийгдэхээр төлөвлөсөн. Үүнээс хойш ШЭҮО-ын Сан ба хоёр талт хандивлагчдын шууд санхүүжилт халааг нь бүрэн авах болно.

ШЭҮО-ын Олон Талт Хандивлагчдын Сангийн хүрээнд ШЭҮО-ын хүлээн авагчийн хувьд Монгол Улс тус Сангийн явуулдаг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээр техникийн туслалцааны санхүүжилт авах эрхтэй болж байна. Монгол Улсад хэрэгжих Сангийн үйл ажиллагаа нь дараахь зорилтыг шийдвэрлэхэд чиглэгдэх болно. Үүнд:

- хувийн хэвшлийг хөгжүүлэхэд таатай эрүүл орчинг бүрдүүлэх;
- хувийн өмчит аж ахуйн нэгж, нэн ялангуяа ЖДҮ /БЖҮ-ийг хөгжүүлэх;
- санхүүгийн салбар, боломжийн өртөг бүхий үндсэн үйлчилгээний хүртээмж хангамжийг сайжруулах;
- байгаль орчныг сайжруулах, шинэлэг санааг дэмжих;
- алслагдсан бүсүүдэд хүрэх санаачилга.

2006 оны 11 дүгээр сард техникийн туслалцааны анхны төсөл батлагдсан. 1 сая еврогийн дүн бүхий энэхүү техникийн туслалцааны төслийн хүрээнд БЖДҮ, Лизингийн зээлийн талаархи зөвлөгөө өгөх үйлчилгээг арилжааны 4 банк, банк бус бичил зээлийн нэг байгууллагад үзүүлэх юм. Монгол Улс түүнчлэн дотоодын банкуудад ШЗХ, ШХОХ ба ДХХСХ-ийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах техникийн туслалцааг хүлээж авах эрхтэй болсон юм. ШЭҮО-ын Сангаар дамжуулан олгох буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтийн хүрээнд Нидерландын хандивын хөрөнгийн тодорхой хэсгийг одоогоор бэлтгэл шатандаа байгаа

Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх төсөлд чиглүүлэхээр 2006 оны 11 дүгээр сард болж өнгөрсөн ШЭҮО-ын Сангийн Чуулга уулзалтын үеэр шийдвэрлэсэн болно.

3.2.1.2 Хувийн компаниудад бүтэц зохион байгуулалтын чиглэлээр үзүүлэх дэмжлэг: TAM/BAS

Монголын компаниудын хөгжил өсөлт нь Банкны үйл ажиллагааны тулгуур зорилго байх юм. Хөрөнгө оруулалт дангаар эдийн засгийн хөгжлийн бүх хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй. Компаниудад бизнесийн стратегийн болоод маркетингийн төлөвлөгөө боловсруулах, удирдлагын ур чадварыг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн боловсруулах, экспортод тавигддаг бүтээгдэхүүний чанарын стандартыг боловсронгуй болгох гэх мэт чиглэлээр яаралтай туслалцаа шаардагдаж байна. Эдгээр зорилгод хүрэхийн тулд тухайн компанийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, асуудлыг онож шийдвэрлэн, хүлээсэн үр дүнд хүрэх тодорхой зорилт бүхий туслалцаа үзүүлэх нь зүйтэй. TAM/BAS Хөтөлбөрийн дадлага туршлага, мэдлэгийн тусламжтайгаар хувийн компаниудын эдгээр асуудлыг шийдвэрлэж бизнес эрхлэх шинэ санааг хөхиүлэн дэмжих боломжтой.

TAM Хөтөлбөр 2001 оноос эхлэн Монгол Улсад идэвхитэй хэрэгжиж байна. Бизнесийн олон салбарт нийт 24 TAM төсөл хэрэгжиж эдгээр төслүүдэд Монголтой Хамтран Ажиллах Сангаас 2.3 сая евро зарцуулаад байна. Төслүүдийг 12 салбарт хэрэгжүүлснээс зонхилсон салбар нь хүнс/ундаа (30 хувь), хөнгөн үйлдвэрийн салбар байсан ба дуусгавар болж, үнэлгээ хийгдсэн нийт төслүүд 90 хувийн амжилт үзүүлсэн.

Уг Хөтөлбөрийн хүрч чадах чухал үр нөлөөг харгалзан TAM Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад ирэх 3 жилийн хугацаанд 20-иос доошгүй төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд Япон Улс 1.55 сая евро гаргахаа мэдэгдсэн. Түүнчлэн Монголд BAS Хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийн талаархи судалгааг хийхээр төлөвлөж байна. TAM хөтөлбөрийг үргэлжлүүлэх, хэрэв судалгаагаар BAS хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гарвал, түүнийг эхлүүлэхэд 2.8 сая орчим евро хандивлагчдаас шаардагдах болно.

TAM/BAS Хөтөлбөрийг Банкны үндсэн үйл ажиллагааны хувьд нэгтгэх талаархи Банкны ерөнхий бодлого мөрдөж хэрэгжүүлсний үр дүнд Банкны доторхи нэгжүүдийн уялдаа сайжирч, Банкны шилжилтийн үр нөлөө нэмэгдэж байна. TAM/BAS Хөтөлбөрийн өвөрмөц давуу талуудыг (тэр дундаа салбарын талаархи тусгайлсан мэдлэг туршлагатай TAM Хөтөлбөрийн Ахлах Зөвлөхүүд, Банкны үйл ажиллагаа явуулдаг орнууд дахь зохих мэдлэг бүхий дотоодын зөвлөхүүдийн BAS мэдээллийн сан) Банкны санхүүжилт хариуцсан Багууд бүрэн хэмжээгээр ашиглаж байна. Энэхүү ажил Монголд нэн даруй эхлэх болно. Энэ утгаар авч үзвэл, TAM ба BAS Хөтөлбөр нь гадаадаас санхүүжилт авах боломжтой компаниудыг бэлтгэж өгөх юм. Учир нь компаниудад ийнхүү зөвлөлгөө өгч тэдэнтэй ажиллах нь маш үр дүнтэй шалгалт болж өгдөг. Цаашилбал хөрөнгө оруулалтын дараахь үе шатанд компанийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад TAM/BAS мэдлэг туршлагыг мөн ашиглаж болох талтай.

3.2.2 Санхүүгийн байгууллагууд

Санхүүгийн салбарыг дэмжих нь Банкны тэргүүлэх чиглэл байх болно. Энэ салбарын тухайд арилжааны банкууд одоогоор ОУСБ-уудаас өөр эх үүсвэрээс хугацаат санхүүжилт авах боломж одоогоор хязгаарлагдмал байна. Арилжааны банкуудын байгууллагын болоод иргэдийн харилцагчид боломжийн нөхцөлөөр зээл авахад хүндрэлтэй тулгардаг учир шинээр бизнес эхлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үл хөдлөх хөрөнгө худалдан авах буюу шинэчлэх зэрэг боломжийг нь хязгаарлаж байна. Банкны санхүүгийн болоод нэгдмэл байдлын шалгуурыг хангасан арилжааны банкуудад төрөл бүрийн зээлийн шугам нээх, зээлийн бүтээгдэхүүнийг олгох замаар санхүүгийн зуучлалыг бэхжүүлэх, улмаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорино. Дунд, жижиг ба бичил бизнесийн байгууллагуудад зориулсан хугацаат санхүүжилт эн тэргүүнд тавигдах боловч бусад зээлийн хэлбэр болох компанийн ерөнхий

зорилгод зориулсан зээл, ДХХСХ болон орон сууцны ипотекийн зээлийн хүрэн дэх хамтарсан санхүүжилт буюу эрсдэл хуваах сонголтыг санал болгох болно.

Банкны зүгээс Бүсийн Худалдааг Дэмжих Хөтөлбөрийг (TFP) хэд хэдэн банкуудтай хамтран хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах болно. Худалдааны санхүүжилт хийх зорилгоор арилжааны банкуудаас зээлийн шугам авах боломж хомс байгаа тул Худалдааг Дэмжих Хөтөлбөр өндөр эрэлт хэрэгцээтэй байна.

Банк арилжааны банкуудад хувь эзэмших боломжийг эрэлхийлж, ингэснээр эдгээр банкуудын өөрийн хөрөнгийг бэхжүүлэн компанийн засаглалыг сайжруулна. Үүнийг шууд өөрийн хөрөнгийн санхүүжилтийн хэлбэрийн зэрэгцээ, хувь эзэмших болон холимог хэлбэрээр оролцох (quasi equity) бусад хэлбэрийг мөн харгалзан үзнэ. Хоёрдогч зэрэглэлийн ба хөрвөх зээлийн хэлбэр, түүний дотор хувийн хөрөнгө оруулалтын санд (private equity fund) оролцох хэлбэрийг мөн харгалзан үзэх болно.

Хэдийгээр лизинг, хэрэглээний санхүүжилт, даатгал, тэтгэвэр, банк бус бичил санхүүгийн байгууллага зэрэг санхүүгийн байгууллагууд сайтар хөгжиж чадаагүй ч, эдгээр байгууллагуудыг дэмжин ажилахыг зорино. ББСБ-уудыг санхүүжүүлэх үндсэн арга бол өөрийн хөрөнгийн санхүүжилтийн хэлбэр байх боловч, дунд ба урт хугацааны зээлийн санхүүжилтийг лизинг, хэрэглээний санхүүжилт, банк бус бичил санхүүгийн байгууллагын хувьд мөн харгалзан үзнэ.

Байгууллагыг бүрэлдүүлэн бий болгох, шилжүүлсэн ур чадварын тогтвортой байдлыг хангах зорилгоор хандивлагчдаас техникийн туслалцааны санхүүжилт хүсэх болно. БЖДҮ-ийн санхүүжилтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй банкуудыг дэмжих зорилгоор техникийн туслалцаа шаардагдана. Өнөөдрийн байдлаар бичил жижиг бизнесийн санхүүжилтийг зөвхөн хоёр банк гол төлөв барьцааны үндсэн дээр хийж байгаа бөгөөд ЖДҮ-ийн санхүүжилт тус улсад богино түүхтэй юм. Худалдааг Дэмжих Хөтөлбөрийг дэмжих зорилгоор Худалдааны Санхүүжилтийн талаар Зөвлөлгөө Өгөх Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай болно. Аливаа өөрийн хөрөнгийн санхүүжилт хийхэд техникийн туслалцаа шаардагдах бөгөөд үүнийг олон улсын банктай хамтран ажиллах хөтөлбөрийг ('twinning' programme) хэрэгжүүлэх болно.

Банк бус санхүүгийн байгууллагуудын хөгжил удааширч байгааг харгалзан, энэ хүрээнд Банкны зүгээс гаргах санаачилгыг дэмжих зорилгоор техникийн туслалцааг үзүүлэх шаардлагатай болно. Цаашилбал ББСБ, хөрөнгийн зах зээлийн, нэн ялангуяа үнэт цаас, бонд, ипотека, даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх, үндэсний валютаар санхүүжилт хийх зэрэг асуудалд анхаарлаа төвлөрүүлнэ.

Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороотой бодлогын түвшинд яриа хэлэлцүүлэг өрнүүлж хяналт шалгалтыг боловсронгуй болгох, банкууд нэгдэхийг дэмжих, түүнчлэн мөнгө угаахаас сэргийлэх, алан хядагч ажиллагааг санхүүжүүлэх зэрэг онцгой асуудалд анхаарлаа төвлөрүүлнэ. Эцэст нь тогтвортой хэрэгжих боломжтой төслүүдийг тодорхойлсон нөхцөлд дотоодын эх үүсвэрээс үндэсний валютаар дунд хугацааны санхүүжилт хийх боломжийг судлах болно.

3.2.3 Байгалийн нөөцийн салбар

Монгол Улс ашигт малтмалын асар их нөөцтэй бөгөөд түүнийг арилжааны хэлбэрээр ашиглах ихээхэн хэмжээний үйл ажиллагаа хүлээгдэж байгаа билээ. Байгалийн нөөцийн салбарт дэмжлэг үзүүлэх нь Монгол Улсад явуулах Банкны үйл ажиллагааны эн тэргүний чиглэл байх болно. Энэ салбарт ОУСБ-аас хийж буй санхүүжилтээс өөр урт хугацааны санхүүжилтийн хүртээмж нэн хязгаарлагдмал байна.

Уул уурхайн салбарт ажиллаж буй гадаад дотоодын аж ахуйн нэгжүүдэд зориулсан урт хугацааны санхүүжилтийг бий болгох нь эн тэргүүний зорилт байна. Зохих шалгуур нөхцөл хангагдсан нөхцөлд газрын тос, байгалийн хий, үйлчилгээний салбар, улсын үйлдвэрийн

газруудад зориулсан санхүүжилтийг мөн дэмжих бөгөөд дээрх шалгуур нөхцөл нь арилжааны хэлбэрт оруулах, корпорацжуулах, ил тод байдал, байгаль орчин ба эрүүл мэндийн стандартын удирдлагыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байх явдал юм. Банкны зүгээс уул уурхайн салбарын хөгжлийн дараагийн үе шатанд шаардлагатай урт хугацааны томоохон хэмжээний хамтарсан санхүүжилт хийх, өөрийн хөрөнгийн санхүүжилт хийхэд бэлэн байна. Үүний зэрэгцээ, шаардлагатай бол, уул уурхайн салбарын төсөв татвар, хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох явдлыг дэмжихэд чиглэсэн техникийн туслалцааг Засгийн Газарт үзүүлж болно.

Банкны зүгээс бизнесийн ёс зүй, байгаль орчныг хамгаалах стандартыг өндөр түвшинд тогтоон хэвшүүлэхийг зорино. Монголын харьцангуй залуу байгалийн нөөцийн салбарын байгууллагыг бүрэлдүүлэн бий болгох, шилжүүлсэн ур чадварын тогтвортой байдлыг хангах зорилгоор Банк нь салбарын зохицуулах байгууллага болох АМГТХЭГ болон Геологи, уул уурхайн сургуулийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэхийн тулд хандивлагчдын санхүүжилтийг татаж төрийн өмчит томоохон уул уурхайн компаниудыг арилжааны хэлбэрт оруулах, корпорацжуулах ажлыг гүнзгийрүүлэх, дотооддоо болон бүсийн хэмжээнд өрсөлдөх чадвартай эрч хүчтэй ЖДҮ-ийн салбарын хөгжлийг дэмжихэд шаардлагатай ур чадвар, мэдлэгийг олгохыг зорих болно.

Яам болон АМГТХЭГ-тай хийх бодлогын яриа хэлэлцүүлэг үргэлжилж, ялангуяа байгалийн нөөцийн салбарын хууль тогтоомжийг (түүний дотор татварын) боловсронгуй болгох, Олборлох Үйлдвэрүүдийн Ил Тод Байдлын тухай Санаачилгыг зохих ёсоор хэрэгжүүлэхэд анхаарах болно. Ингэхдээ ДБ, Засгийн Газар, салбарын төлөөлөл, ТББ-уудын нийгэмлэгтэй үргэлжлүүлэн нягт холбоотой ажиллана.

3.2.4 Агробизнес

Хөдөө аж ахуй нь тус улсын эдийн засгийн зонхилсон салбар боловч, одоогийн байдлаар Банкны зүгээс энэ салбарт хэрэгжүүлэх төслийг хараахан тодорхойлоогүй байна. Аль ч талаас нь авч үзсэн, агробизнесийн үйл ажиллагаа анхан шатны боловсруулалтын түвшинд байгаа бөгөөд мал аж ахуйн үйлдвэрлэл үндсэн дэд салбар нь болж байна. Анхан шатны үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой эрсдэл хэзээд өндөр байдаг тул Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын зөвлөхийн тусламжтайгаар үйл ажиллагаа нь амжилттай явагдаж байгаа хүнсний үндсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдийг Банк олж тогтоохыг оролдож, боловсруулах салбарын чанар, үр ашгийг удирдлагыг сайжруулах замаар дээшлүүлэхийг зорино. Боловсруулсан махны экспортыг хөгжүүлэх ажиллагааг дэмжиж болох талтай. Шинэ зах зээл рүү орох гэж байгаа өнөөгийн шатанд Банкны санхүүжилтийг дараахь дэд салбаруудад хандуулах болно. Үүнд: жижиглэн худалдаа, чихэр боов, шар айраг/ундааны үйлдвэрлэл. Хөрөнгө оруулалтын боломжит чиглэлийг тодорхойлох зорилгоор тус улсын дурдсан салбар дахь санхүүжилтийн боломжийг тодорхойлж үнэлэх ажлын хэсгийг аль болох ойрын үед зохион байгуулах болно.

3.2.5 Дэд бүтэц

Банкны зээлийн үйл ажиллагаанд тавигдах хөнгөлөлтийн шаардлага

Орлого багатай болоод ихээхэн өртэй бусад орнуудын адил ОУВС-аас тавигддаг шаардлагын дагуу арилжааны нөхцөлөөр зээл авахыг Монгол Улсад зөвшөөрдөггүй. Энэхүү шаардлагыг 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Монгол Улсын Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулинд тусгасан бөгөөд ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжихгүй байгаа ч гэсэн энэхүү заалт хүчин төгөлдөр хэвээр байна. Улсын хэвшлийн авах гэж буй зээлийн 35-аас доошгүй хувийг (ӨЦҮЦ-ээр тооцсон) буцалтгүй тусламж бүрдүүлж байгаа нөхцөлд зээлийг авах боломжтой. Орон нутаг, бүсийн эрх бүхий байгууллагууд зөвхөн төв засгийн газраас зээлж болно (Улсын төсвийн удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 57-р зүйл). Орон нутгийн захиргаанаас баталгаа гаргах эсэх талаар хуулинд заалт ороогүй ч орон нутгийн захиргаа зээлийн баталгаа гаргах эрхгүй гэж Сангийн Яам үздэг. Өнөөг хүртэл ОУСБ буюу хоёр талт

хөнгөлөлттэй аливаа зээлийн баталгааг засгийн газар гаргаж, улсын эзэмшлийн эрчим хүч, дулаан, нийтийн аж ахуйн байгууллагуудад дамжуулан зээлдүүлж иржээ.

Ийм нөхцөл байдалд Банк эн тэргүүнд хувийн хэвшлийн үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлэх боловч улсын хэвшилд хэрэгжих төслүүдийн хувьд хөнгөлөлттэй ба буцалтгүй тусламжийн санхүүжилтийг эрэлхийлэх болно. ШЭҮО-ын Олон Талт Хандивлагчдын Сан ба хоёр талт дэмжлэгт тулгуурлан дээрх хөрөнгийн эх үүсвэрийг гаргах боломжтой байх болно. 2006 оны 11-р сард Нидерландын Засгийн Газар 5 сая еврогийн хөрөнгийг буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтийн эх үүсвэрт зориулан ШЭҮО-ын Олон Талт Хандивлагчдын Санд өгөх тухайгаа мэдэгдсэн нь Засгийн Газрын хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх боломжийг Банкинд олгож байна.

3.2.5.1 Тээвэр

Энэ салбарт тулгараад байгаа шийдвэрлэвэл зохих үндсэн асуудал нь тээврийн дэд бүтцийн чанарыг сайжруулах, ингэхдээ төсвийн хөрөнгийн хязгаарлагдмал байдалд нийцүүлэн, боломжтой тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтыг татах замаар дэд бүтцийн аж ахуйн нэгжүүдийн ирээдүйн тогтвортой үйл ажиллагааны үндэс суурийг бий болгохуйц байдлаар хэрэгжүүлэх явдал юм. Банк нь тус улсын зээл авах чадавхи хязгаарлагдмал байгааг харгалзан шинэ хөрөнгө оруулалтыг сайтар сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр дэмжих болно.

Иргэний агаарын

Энэ салбарт амжилттай хэрэгжүүлсэн техникийн туслалцааны хоёр төслийг үндэслээд (Монголын иргэний нисэхийн компанид менежментийн туслалцаа үзүүлэх ба иргэний нисэхийн салбарын мастер төлөвлөгөө боловсруулах) орон нутгийн дөрвөн онгоцны буудлын зурвасыг нөхөн сэргээх, агаарын навигацийн зарим тоног төхөөрөмж нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх асуудлыг ИНЕГ-аас Банкинд тавьсан юм. Энэ хоёр асуудлыг нислэгийн аюулгүй байдал, алслагдсан бүсүүдийг нийслэл хоттой холбох зам харилцааг хангах шаардлага, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд үзүүлэх эерэг үр нөлөөг харгалзан тус салбарын мастер төлөвлөгөөнд эн тэргүүний хөрөнгө оруулалт болгон тодорхойлсон юм. Банк Монголтой Хамтран Ажиллах Сангаас техникийн туслалцааны санхүүжилтийг авч төслийн бэлтгэл ажлыг 2007 онд эцэслэхээр төлөвлөж байна.

Банк түүнчлэн хувийн хэвшлийн боломжит төсөл, нэн ялангуяа иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа, ачаа тээврийн үйлчилгээний төслүүдийг эрэлхийлж дэмжихэд бэлэн байна. Ингэхдээ техник эдийн засгийн зохистой үнэлгээг үндэслэнэ.

Авто зам

Нийт 49,250 км авто замын сүлжээнээс зөвхөн 12 хувийг хатуу хучилттай, 13 хувийг хайрган, 75 хувийг шороон зам тус тус эзэлж байна. Замын нягтрал дөрвөлжин км-т 0.03 км байгаа нь маш доогуур үзүүлэлт юм. Иймд энэ салбар дахь хөрөнгө оруулалтын хэрэгцээ асар их юм. Гэвч хөрөнгө оруулалтыг улсын төсвийн хязгаарлалт боогдуулдаг. Банк тус салбарын өөрчлөлт шинэчлэлийг ОУСБ-уудтай уялдуулан зохицуулж АХБ ба ДБ-тай хамтран санхүүжүүлэх боломжийг судлах болно.

Төмөр зам

Монголын Төмөр Замыг Монгол Улсын Засгийн Газар, Оросын Төмөр Зам хоёр 50/50 харьцаагаар эзэмшдэг. Компанийг 1940-өөд оны сүүлчээр засгийн газар хоорондын гэрээний дагуу байгуулсан учир, тэрээр эрх зүйн хувьд өвөрмөц статустай байгууллага юм (тухайлбал ашгийн ямар ч татвар төлдөггүй). Өмчлөлийн өвөрмөц бүтэц, эрх зүйн байдал нь одоогоор шууд хамтын ажиллах боломжийг хязгаарлаж байна. Гэвч төмөр замын компанийг компанийн бүтцэд шилжүүлэх тал дээр зохих амжилт гаргасан тохиолдолд вагон паркийн шинэчлэл, зам тавих байгууламжийн өргөтгөл, дэд бүтцийн шинэчлэлийг дэмжих боломжийг Банк судлана.

3.2.5.2 Нийтийн аж ахуй ба байгаль орчны дэд бүтэц

Энэхүү салбарт ОУСБ болон хэд хэдэн хоёр талт хандивлагчдаас үлэмж хэмжээний зээл олгогдоод байгаа. Бүх зээлийн гэрээг Засгийн Газар байгуулж, эцсийн зээлдэгчдэд дамжуулан зээлдүүлсэн. Хэдийгээр дамжуулан зээлдүүлэх зарчим нь шилдэг практик ажиллагааны дагуу хийгдэж байгаа боловч, зээлийн хөтөлбөрт хамрагдсан ашиглалтын аж ахуйн нэгжүүдэд (ус, дулаан, цахилгааны) хуримтлагдсан зээлийн өр төлбөр тогтвортой түвшингээс даваад байна. Үүний улмаас хэд хэдэн нийтийн аж ахуйн ашиглалтын компаниуд өр төлбөр хариуцах чадвараа алдаж, зээлийн эргэн төлөлт хийхэд хүндрэлтэй тулгараад байна. Энэ нь нэг талаар хүн амын төлбөрийн чадвар хүрэхгүй гэсэн бодит үнэлэлт буюу төсөөлөлтэй холбоотойгоор орон нутгийн захиргаа буюу төв Засгийн Газраас үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлж чадахгүй байгаатай холбоотой юм. Ер нь, ОУСБ-аас үнэ тарифын зохицуулалт хийх талаар тавьж байсан шаардлагууд огт хэрэгжээгүй байна.

Засгийн газрын баталгаа гаргуулах боломж хязгаарлагдмал, түүнчлэн Монгол Улсад зээлийг баталгаатай эргэн төлөх чадвартай хотын захиргаа бараг үгүйг харгалзан, Банкны зүгээс жижиг хэмжээний төслийг хувийн хэвшлийнхэнтэй ба/буюу буцалтгүй тусламжийн хөрөнгийг дайчлан зохих төслийг сонгон шалгаруулж улсын хэвшилтэй хамтран ашигтай хэрэгжүүлэх боломжийг олж тогтооход анхаарах шаардлагатай байна. Хамтран ажиллаж болох хувийн хэвшлийнхний тоонд зээл авах боломжтой хотын нийтийн тээврийн хувийн компаниуд багтаж байна.

Банк өнөөгийн төлбөрийн чадварын хязгаарлалтын хүрээнд үйлчилгээний чанар, өртөг зардлын хяналтыг сайжруулахад арилжааны чиг хандлагыг нэвтрүүлэх, нөгөөтэйгүүр зардлаа нөхөх хэмжээний үнэ тарифыг аажмаар нэвтрүүлж үйлчилгээний төлбөр хураалтын тогтолцоог боловсронгуй болгох замаар хотын нийтийн аж ахуйн ба үйлчилгээний байгууллагуудын санхүүгийн тогтвортой ажиллагааг дунд хугацанд хангах зорилтыг дэмжинэ. Үүний тулд бүтэц зохион байгуулалтын томоохон ажил хийгдэх болно. Шинэ хөрөнгө оруулалтыг авч хэрэгжүүлэхийн тулд нийтийн аж ахуйн компани болон хотын захиргаанд төслийн хэрэгжилт, хяналт шалгалтын чадавхийг зохистой түвшинд бүрдүүлсэн байх явдлыг хотын захиргаа хангасан байх учиртай.

3.2.5.3 Эрчим хүч

Монголын эрчим хүчний салбар шийдвэрлэвэл зохих томоохон асуудлуудтай тулгарч байна. Тухайлбал техникийн болоод арилжааны ихээхэн хэмжээний алдагдалд хүргэж буй хуучирсан сүлжээний тоног төхөөрөмж, хүчин чадал ба үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хийхэд шаардлагатай ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, нэгэнт өндөр түвшинд хүрсэн үнэ тариф нь түүнийг цаашид өөрчлөх боломжийг хязгаарлаж байгаа явдал зэргийг дурдаж болох юм. Үүний зэрэгцээ тус салбарын зарим үндсэн нэгжүүд томоохон хэмжээний засгийн газрын баталгаатай зээлээр санхүүжүүлсэн төсөл хэрэгжүүлж байгаа нь нэмж зээл авах, хэрэгжүүлэх чадавхийг хязгаарлаж байна.

Банкны зүгээс жижиг хэмжээний эрчим хүч дамжуулах төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг судлана. Ингэхдээ болж өгвөл засгийн газрын баталгаагүйгээр барьцаат хэлцлийн хэлбэрээр хийх болно. Цаашилбал одоо байгаа эрчим хүч дамжуулах сүлжээг нөхөн сэргээх, Баруун ба Зүүн бүсийн сүлжээнд, түүнчлэн ашигт малтмалын ордуудын хайгуулын ажил, ашиглалттай холбоотойгоор эрчим хүчний эрэлт хэрэгцээ ирээдүйд асар их нэмэгдэх Өмнөд бүстэй холбох эрчим хүч дамжуулах шинэ шугам барих төслийг судлана. Дунд хэмжээний усан буюу салхины зэрэг сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэх боломжийг судлана.

Эрчим хүчний салбарт хэрэгжүүлсэн техникийн туслалцааны явцад хуримтлуулсан туршлагыг үндэслэн эрчим хүчний зохицуулалт, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар холбогдох эрх бүхий байгууллага, ОУСБ-уудтай үргэлжлүүлэн хамтран ажиллана. Нэн ялангуяа үнэ тарифын аргачлалыг боловсронгуй болгох, Эрчим хүчний тухай хуулийн

шинэчилсэн найруулга (зохицуулагчийн бие даасан байдлыг бэхжүүлэх, эрчим хүчний зах зээлийн дүрмийг боловсруулах), Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль эдгээр болно.

3.2.5.4 Харилцаа холбоо

2004 оны 3 дугаар сард Монголын харилцаа холбооны салбарын хувьчлалын хувилбар нэртэй ехнийн туслалцааны төсөл батлагдсан. Уг техник туслалцаа дараахь тодорхой зорилтыг хангах ёстой байв. Үүнд: (а) харилцаа холбооны өмч хөрөнгийг үргэлжүүлэн хувьчлах асуудлаар холбогдох талуудтай зөвшилцөлд хүрэхэд Засгийн Газарт туслалцаа үзүүлэх; (б) хувьчлалыг ямар хэлбэрээр явуулах талаар бусад хувь оролцогч талууд, юуны өмнө Кореа Телеком ба хандивлагч нартай зөвшилцөлд хүрэхэд Засгийн Газарт туслалцаа үзүүлэх; (в) шаардлагатай бол, хөрөнгө шилжүүлэх ба хувьчлал явуулахад Засгийн Газарт туслалцаа үзүүлэх. Анхны байдлаар хийсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүн, түүнчлэн, Японы Харилцаа Холбооны Инжинирингийн Зөвлөх Үйлчилгээний компанийн зөвлөмжийг үндэслэн зөвлөхүүд сүлжээг ажиллуулах үүрэгтэй Нетко компани болон зөвхөн үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Сервко компаниудаас бүрдсэн бүгдэд хүртээмжтэй бүтцийг санал болгосон. Энэхүү зөвлөмжийг 2005 оны 7 дугаар сард УИХ-аас баталсан Хувьчлалын Үндсэн Чиглэлд тусгасан болно. Ийнхүү баталсан арга хэмжээний хэрэгжилт 2006 оны эхээр Засгийн Газар солигдсонтой холбоотойгоор хойшлогдсон. Одоогоор Засгийн Газар нь хувьчлалын угтвар нөхцөл болгон Нетко компанийг байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилтийг хангах, КТ-тэй гэрээ хэлэлцээрийг үргэлжлүүлэн хийхэд туслах зорилгоор техникийн туслалцааны төслийг 2006 оны 9 дүгээр сард сунгасан юм.

Сервко ба Нетко компаниудыг тусгаарлах, түүний дараагийн үе шатанд Монголын Цахилгаан Холбоо компанийг хувьчлах явцад Банк Засгийн Газар хоорондын яриа хэлэлцүүлэг үргэлжлэх болно. Түүнчлэн хувьчлалын өмнөх зээл буюу бусад зохистой хэрэгслээр Сервко ба Нетко компаниудыг санхүүжүүлэх асуудлыг судлана. Үүний зэрэгцээ хувьчлалын явцад эдгээр компаниудад хувь эзэмших асуудлыг Банк судлана. Үүрэн телефоны салбарын хувьд гуравдагч хувийн оператор лицензээ 2006 онд авсан. Банк санхүүжилтийн өргөн хүрээний хэрэгслийг, түүний дотор компанид олгох зээлээс өөрийн хөрөнгийн санхүүжилт, нэхэмжлэлийн хоёрдогч эрх бүхий санхүүжилт зэрэг хэрэгслийг ашиглан хувийн хэвшлийн компаниудыг санхүүжүүлэх боломжийг тодорхойлохыг зорино.

4. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон олон талт хандивлагчид

Банк 10 гаруй жилийн туршид Монгол Улсын зах зээлд чиглэсэн шилжилт, хөгжлийн явцад тусалж ирсэн ОУСБ-ууд болон хандивлагч орнуудтай хамтран ажиллана. Хамтын ажиллагаа нь хамтарсан санхүүжилт хийх, харилцан бие биенээ нөхсөн төсөл хэрэгжүүлэх, бодлогын яриа хэлэлцүүлгийг уялдуулан зохицуулах зэрэг ажиллагааг багтаах болно. Хамтын ажиллагааг Банкны Улаанбаатар дахь Суурин Төлөөлөгчийн Газраар дамжуулан сар бүр зохион байгуулагддаг хандивлагчдын уулзалт болон хоёр болон олон талт байгууллага, хандивлагч нартай байнгын холбоотой ажиллах замаар хамтын ажиллагааг хангана. Жлын түвшинд тогтмол хийгдэж байдаг хоёр болон олон талын уулзалтуудаар хангана. Тодорхой хөрөнгө оруулалтын төслүүдэд хандивлагчийн хамтарсан санхүүжилт дайчлан гаргуулах тал дээр Банк хичээж ажиллана.

4.1 Олон Улсын Валютын Сан (ОУВС)

Монгол Улс 1991 оны 2 дугаар сард ОУВС-д нэгдэн орсон. Өнгөрсөн хугацаанд Монголын Засгийн Газрын эдийн засгийг шинэчлэх, ядуурлыг бууруулах талаархи Засгийн газрын хүчин чармайлтыг ОУВС дэмжсээр ирсэн. 1993 оны 6 дугаар сард ОУВС-ийн Бүтцийн Зохицуулалтын Хэрэгсэл өөз 3 жилийн хөтөлбөр(ESAF)-ийн 40.8 сая ЗТЭ-ийн 3 жилийн хөтөлбөр ээр бабатлагдсан боловч, энэ нь 1996 оны 6 дугаар сараас зогссон. Үүний дараа 1997 оны 7 дугаар сард ОУВС-ын Захирлуудын Гүйцэтгэх Зөвлөлөөс БЗХ/Ядуурлыг бууруулах ба өсөлтийг дэмжих 3 жилийн (33.4 сая ЗТЭ), 2001 онд Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах 3 жилийн (ЯБӨДХ, 28.4 сая ЗТЭ) хөтөлбөрүүдийг тус тус баталжээ. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь төсвийн зардлыг бууруулах, хянахаас гадна хувьчлал, банк, санхүүгийн салбарын

бүтцийн өөрчлөлт, мөнгөний бодлого зэргийг дэмжихэд оршиж байлаа. Гэсэн хэдий ч энэ хөтөлбөрийн гуравдах болон дараа дараачийн шалгатлууд хийгдээгүйгээр 2005 оны 7 дугаар сард хөтөлбөрийн хэрэгжилт зогссон ба одоогийн байдлаар ОУВС-аас хэрэгжүүлж буй хөтөлбөр байхгүй. Сан нь 2005 оны 9 дүгээр сард Зүйл IV-ийн талаархи зөвлөлдөөн болон Урт хугацаат хөтөлбөрийн дараахь үнэлгээний хэлэлцүүлгийг эцэслэж, одоо шинэ хөтөлбөр эхлүүлэх боломжийг судалж байна.

4.2 Дэлхийн Банкны Бүлэг

1991 оны 2 дугаар сард Монгол Улс ОУСБХБ, ОУХА, ОУСК-ын гишүүн болсон. Дэлхийн Банкны Бүлэг нь Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги (ЭЗӨДЯБС)-н дагуу тус улс дахь ядуурлыг бууруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх, санхүүгийн салбарыг шинэчлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд тусалж ирсэн. Дэлхийн Банк нь 325 сая ам.долларын зээлийн болон техникийн тусламжийн төслүүдийг амласнаас, ОУХА-аас 207.7 сая ам.долларын 12 зээлийн төслийг хэрэгжүүлээд байна. Санхүүжилтийн багцад дэд бүтцийн төслүүд давамгайлж санхүү, хувийн хэвшлийн хөгжлийн төслүүд, цаашилбал ядуурлыг бууруулах, төрийн байгууллагуудын шинэчлэлтэй холбоотой төслүүд удаалж байна. “ОУХА-14” буцалтгүй тусламжийн шалгуур тооцох аргачлалын дагуу Монгол Улс нь 2006 оны санхүүгийн жилд “зөвхөн буцалтгүй” тусламж авах нөхцлийг хангасан хэвээр байгаа юм.

Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) нь Монголд хувийн хэвшлийг дэмжих цөөн тооны төслүүд хэрэгжүүлж ирсэн. Тэрээр анхны хөрөнгө оруулалт (1.75 сая ам.доллар, түүнээс 0.3 сая ам.долларын өөрийн хөрөнгийн санхүүжилт)–аа 1996 онд арьс боловсруулах үйлдвэрт хийсэн. 2002 онд бичил болон жижиг дунд бизнесийг санхүүжүүлэх зорилгоор санхүүгийн салбарт, тухайлбал, ХасБанкинд (0.4 сая ам.доллар) хөрөнгө оруулалт хийсэн. 2004 онд Худалдаа Хөгжлийн Банкинд шууд хөрөнгө оруулалт (1.5 сая ам.доллар) болон нэхэмжлэлийн хоёрдогч эрх бүхий зээл (3.5 сая ам.доллар) олгох хэлбэрээр нийт 5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийснээс гадна, мөн ондоо Хаан Банкинд 1.2 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт, жижиг дунд бизнесийг Монгол орон даяар дэмжих зорилгоор 1.8 сая ам.долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурсан. 2005 оноос бизнесийг лизингийн аргаар дэмжих зорилгоор Монголд Лизинг Хөгжүүлэх талаархи техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

Одоо хэрэгжиж буй Дэлхийн Банкны 2004-2007 онд Монгол Улсыг Дэмжих Стратеги нь 2004 оны 4 дугаар сард батлагдсан ба тэрээр ЭЗӨДЯБС–тэй нийцэж буй болно. Дурдсан Стратеги нь (а) зах зээлийн эдийн засагт шилжих үлй явцыг гүйцээх, (б) хот, хөдөө дахь эмзэг байдлыг бууруулах, (в) бодлого болон нөөцийг үр дүнд чиглүүлэх гэсэн 3 гол чиглэлд төвлөрч байгаа юм. ОУХА-ын багцыг энэ 4 жилд ойролцоогоор 60 сая ЗТЭ байхаар төлөвлөж байна. Дэлхийн Банк нь төрийн удирдлага/төрийн үйлчилгээний ба санхүүгийн салбарын өөрчлөлт шинэчлэл, хувийн хэвшлийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын шинэчлэл, хот хөдөөгийн хөгжил, дэд бүтэц болон шүүх засаглалын шинэчлэлийг хамарсан эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулахад чиглэсэн бүтцийн өөрчлөлт шинэчлэлийн асуудлаархи өргөн хүрээний харилцан яриа, хэлэлцүүлгийг хийж байна. Дэлхийн Банк нь нийгмийн амьжиргааны үзүүлэлтүүд улам буурсаар байгаа тул, ядуурлыг бууруулах ба нийгмийн салбар дахь тусламжаа нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлсээр байна.

4.3 Азийн Хөгжлийн Банк (АХБ)

Монгол Улс нь 1991 онд АХБ-нд гишүүнээр элссэн бөгөөд 2005 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт 616 сая ам.долларын 36 зээл, 59 сая ам.долларын буцалтгүй тусламжийн 121 техникийн туслалцааг хөдөө аж ахуй, аж үйлдвэр, санхүү, засаглал, эрүүл мэнд, боловсрол, харилцаа холбоо, тээвэр, нийтийн аж ахуй болон нийгмийн хамгааллын салбарт аваад байна. Хувийн хэвшлийн хувьд тус улсын хамгийн том арилжааны банкиг дэмжих зорилгоор 6 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалтыг хийгээд байна. Бодлогын шинэчлэл хийх, техник технологийн шинэчлэл хийх, арилжааны горимд шилжүүлэх зорилгоор олгосон зээлүүд нь үндсэндээ эдийн засгийг зөв голдрилд нь оруулахыг зорьсон. Дэд бүтцэд хийсэн хөрөнгө

оруулалт нь тухайн байгуудамжуудын техникийн үзүүлэлтийг сайжруулахад хувь нэмрээ оруулснаас гадна, салбаруудыг задлах үндэс суурийг тавих, хувийн хэвшлийн оролцоог хөхиүлэн дэмжихэд хувь нэмрээ оруулсан. ХАА-н салбарт үзүүлсэн туслалцаа нь зорилтот бүс нутгуудад нэгдсэн цогц үйлчилгээг хүргэх замаар ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн орлогыг нэмэгдүүлснээс гадна эмзэг байдлыг бууруулсан. Салбарыг өргөн хүрээнд нь хамрах аргыг боловсролын салбарт нэвтрүүлснээр салбарын удирдлага, хандивлагчдын уялдаа зохицуулалтыг сайжруулж, үйлчилгээний чанарыг дээшлүүлж байна.

2005 оны 8 дугаар сард батлагдсан 2006-2008 онд баримтлах Монгол Орны Стратеги ба Хөтөлбөртөө Засгийн Газрын стратегийн үндсэн хоёр тулгуур болох (а) өргөн хүрээнд тогтвортой өсөх, (б) нийгмийн бүх давхаргыг хөгжүүлэх зорилтыг дэмжихээр заасан. Хөтөлбөр нь үр дүнд суурилсан арга барилаар хөдөө аж ахуй, тээвэр, боловсрол, эрүүл мэнд, нийтийн аж ахуйн хөгжилд туслах, эдгээр салбаруудад нэгдсэн уялдаатай зохицуулалтыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр тогтсон. 2006-2008 онд 85 сая ам.долларыг зээлд, 5.6 сая ам.долларыг зээлийн бус арга хэмжээнд зарцуулахаар, мөн 40 сая ам.долларыг Бүс нутгийн сан болон бусад хамтран санхүүжүүлэгч эх үүсвэрээс гаргуулахаар төлөвлөөд байна.

4.4 НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)

НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр нь 1973 оноос Монгол Улсад ажиллаж байгаа. 2001 оны 7 дугаар сард батлагдсан 2002-2006 онд Монгол Улстай Хамтран Ажиллах Хоёр дахь Хөтөлбөрт дараахь таван чиглэлд төвлөрч ажиллахаар зааж өгсөн. Үүнд: (а) ардчилсан засаглал, (б) хүний хөгжил ба ядуурлыг бууруулах, (в) эдийн засгийн хөгжил, (г) байгаль орчин ба байгалийн нөөцийн тогтвортой удирдлага (жишээ нь: эрчим хүчний алдагдлыг бууруулах, орчны бохирдлын хяналт), (д) гамшгийн удирдлага зэрэг багтаж байна. НҮБХХ-ийн Хөтөлбөр нь НҮБ-ийн Орны Нийтлэг Үнэлгээ болон НҮБ-ийн Тусламжийн Үндсэн Зарчим дээр суурилсан. Одоогоор хэрэгжүүлж буй хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээ 9.1 сая ам.доллороор төлөвлөгдөөд байгаа.

III. ХАВСРАЛТ

- ХАВСРАЛТ 1 УЛС ТӨРИЙН ҮНЭЛГЭЭ**
- ХАВСРАЛТ 2 БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН НИЙГМИЙН ГОЛ АСУУДЛУУД**
- ХАВСРАЛТ 3 САНХҮҮЖИЛТ ХИЙХЭЭР БЭЛТГЭЖ БУЙ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**
- ХАВСРАЛТ 4 ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨСЛҮҮДЭД АМЛАСАН ДҮН**
- ХАВСРАЛТ 5 ТӨЛӨВЛӨЖ БУЙ ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨСЛҮҮД**
- ХАВСРАЛТ 6 ЭРХ ЗҮЙН ҮНЭЛГЭЭ**
- ХАВСРАЛТ 7 ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**
- ХАВСРАЛТ 8 ХОЁР ТАЛТ ТУСЛАЛЦАА**
- ХАВСРАЛТ 9 МОНГОЛЫН ГАЗРЫН ЗУРАГ**

Хавсралт 1- Улс төрийн үнэлгээ

Зүйл 1-д нийцсэн байдал

Монгол Улс ЕСБХБ-ийг Үүсгэн Байгуулах Гэрээний Зүйл 1-д заасанчлан, олон намт ардчилал, олон ургалч үзэл ба зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг мөрдөн хэрэгжүүлэх тал дээр тууштай зогсож, эдгээр зарчмуудын биелэлтэд дэвшил гаргаж байна. Эдгээр зарчмуудыг тууштай хэрэгжүүлэх нь тухайн орон дахь ардчиллын ололт амжилтыг бататгахад тус нэмэр болно.

Монгол Улс нь ардчилсан шилжилтийг амжилттай хэрэгжүүлж байгаа орон юм. Шилжилтийн үйл явц эхэлснээс хойшхи хугацаанд Монгол Улс либерал ардчилсан үндсэн хуулийг батлан, өрсөлдөөнт улс төрийн намуудын тогтолцоог бий болгон, хүчтэй иргэний нийгмийг үүсгэн, зах зээлд чиглэсэн өөрчлөлт шинэчлэлийн арга хэмжээг хэрэгжүүлсээр байна. Хэвлэл мэдээлэл харьцангуй чөлөөтэй болсон бөгөөд хуулийг дээдлэх ёс, хүний эрхийн зарчмуудыг хүндлэх нь нэмэгдэж байна.

Хэдийгээр дээрх ололт амжилтад хүрээд байгаа ч, Монгол Улс олон тооны сорилуудтай тулгарч байна. Эдгээр нь олон тооны улс төрийн хямралын улмаас Засгийн газар ойр ойрхон солигдож, болж ядуурал өргөнөөр тархан, цалин бага, эрүүл мэнд болон боловсролын хүртээм хязгаардагдмал хэвээр байгаа зэрэг асуудлууд юм.

Энэхүү өөрчлөлтөнд тууштай байж, улс төр, эдийн засгийн өнөөг хүртэл хүрсэн ололт амжилтад үндэслэн, бүхий л томоохон оролцогчдын оролцоог хангасан улс төрийн үйл явцыг удирдах нь тогтвортой амжилтад хүрэх хүрэх гол арга байж болох юм.

Улс төрийн орчин

1990 он хүртэл Монгол Улс нь Зөвлөлтийн тогтолцоогоор загварчлагдсан, зөвхөн Коммунист Нам албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж болдог байв. Зүүн Европ болон хуучин Зөвлөлт Холбоот Улсад 1990-ээд оны эхэн үед гарсан ардчиллын салхи нь Монголд тусгалаа олсноор тус улс 1990 онд анхны олон намт парламентын сонгуулийг явуулж, 1992 онд анхны ардчилсан үндсэн хуулийг баталсан.

Монгол нь далайд гарцгүй, Орос, Хятад улсуудтай хил залгаа, хүн ам цөөнтэй орон юм. Эрс тэс цаг ууртайгаас гадна нийгмийн суурь үйлчилгээг хүргэхэд хүндрэлтэй. Ядуурал, ажилгүйдэл, хот хөдөөгийн хоорондох асар том ялгаа нь Монгол Улсын хөгжилд томоохон саад болж байгаа зүйлс юм.

Гэсэн хэдий ч Монгол Улс олон намт ардчилал, олон ургалч үзлийг бий болгох явцад ихээхэн дэвшил гаргасан. Тус орон улс төрийн олон намтай, түүний дотор жинхэнэ сөрөг хүчний нам ч байдаг бөгөөд төрийн бус байгууллагуудын хүчирхэг сүлжээтэй болж чадсан. Одоогоор 5000 гаруй төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулсаар байна. Хэвлэл мэдээлэл харьцангуй чөлөөтэй болсон бөгөөд хүний эрхийн стандартыг хүлээн зөвшөөрч мөрддөг болжээ.

1992 оны Үндсэн хуулиар парламентын засаглалтай байхаар тогтсон. Хэдийгээр Ерөнхийлөгч хуульд хориг тавих эрхтэй ч, түүний шийдвэрийг 76 суудалтай нэг танхимт парламентын дийлэнх олонх болох гуравны хоёр нь хүчингүй болгох боломжтой. 1990 оноос хойш Монгол Улс ардчиллын амжилтаа олон улсын стандартын дагуу явагдсан парламентын 5 сонгууль, ерөнхийлөгчийн 4 сонгуулиар бататгаад байна.

Бага зэргийн хууль бус ажиллагаа ажиглагдсан хэмээн сонгуулийн ажиглагчид үзсэн 2005 оны 5 дугаар сард болж өнгөрсөн сонгуулиар Ерөнхий Сайд асан, Улсын Их Хурлын Дарга асан, Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүн Намбарын Энхбаяр Ерөнхийлөгчөөр сонгогдсон. Сонгуульд оролцогсдын хувь хэмжээ 75 хувьтай байснаас Намбарын Энхбаяр 53 хувиар ялсан.

Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь суудалдаа дөрвөн жилийн хугацаагаар хоёр удаа сонгогдох боломжтой юм. Ерөнхийлөгч нь Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл болон Зэвсэгт Хүчнийг удирддаг. Засгийн газрын байнгын өөрчлөлт нь Ерөнхийлөгчийн үүрэг хариуцлагыг улам нэмэгдүүлж байна.

Үндэсний парламент болох Улсын Их Хурлын гишүүд нь дөрвөн жилийн хугацаатайгаар шууд сонгогддог. Сүүлчийн парламентын сонгууль 2004 оны зургаан сард болсон бөгөөд аль ч нам дийлэнх олонхийн засгийн газар байгуулж болохуйц хангалттай суудал авч чадаагүй. Үүний үр дүнд Монгол Ардын Хувьсгалт Нам, гол сөрөг намуудаас бүрдсэн Эх-Орон Ардчилал Эвслээс Монголын анхны эвслийн засгийн газар (Их Эвсэл) бий болсон юм. 2004 оны арван хоёрдугаар сард Эх-Орон Ардчилал Эвсэл задарсны улмаас засгийн газрын хямрал нүүрлэснийг Эх-Орон Ардчилал Эвслийн хамгийн том нам болох Ардчилсан Нам Монгол Ардын Хувьсгалт Намтай бүлэг байгуулснаар аварсан.

Их Эвсэл нь хоёр жил ч болж чадсангүй. 2006 оны нэгдүгээр сард МАХН УИХ дахь гурван жижиг намтай хамтран Улаанбаатар хотын Засаг Дарга асан Миеэгомбын Энхболдоор тэргүүлүүлсэн Засгийн газрыг байгуулсан. Өөрсдийн гэсэн засгийн газрыг байгуулж байсан намууд болох Монгол Улсын Хувьсгалт Нам, Ардчилсан Намуудын хооронд засгийн эрх шилжүүлэх үйл явц нам тайван, эмх цэгцтэй болж өнгөрсөн.

Шинэ засгийн газар нь ядуурал, ажилгүйдэл, бага цалин, байгалийн нөөцийн асуудлыг шийдэх гэсэн томоохон асуудлуудтай нүүр тулсан. 2006 оны дөрөвдүгээр сард нийслэлд болсон жагсаал цуглаан нь Монгол Улсын байгалийн нөөцийн ашиглалтад гадаадынхан ихээхэн үүрэг оролцоотой болж байгааг эсэргүүцэж байв. Хэдийгээр засгийн газар эсэргүүцэгчдийн тавьж буй асуудлыг авч үзье хэмээн эсэргүүцлийг намжаасан боловч, ядуу орны хувьд гадаад компаниуд ашигт малтмалын баялгийг олборлох нь маш эмзэг асуудал хэвээр байна. Засгийн газар үндэсний болон үйлдвэрлэгчдийн эрх ашгийн хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахыг эрмэлзэн, уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдын итгэлийг аль болохоор хөсөрдүүлэхгүй байхыг хичээж байна.

Хуулийг дээдлэх ёс ба хүний эрхийг хамгаалах нь

Монгол Улсын ардчилсан шилжилтийн нэг онцлог нь хуулийг дээдлэх ёс болон хүний эрхийн зарчмуудыг тууштай хүндэтгэн дагаж мөрдөж ирсэн явдал юм. Монгол Улс ардчиллын үйл явцад ихээхэн ололт амжилтад хүрсэн хэдий ч, эрх бүхий байгууллагуудын анхаарлыг шаардаж байгаа хэд хэдэн асуудлууд байсаар байна. Эдгээрт ардчилсан засаглалыг сайжруулах, ардчиллын төлөөллийг бэхжүүлэх, засаг захиргааны удирдлагын төвлөрлийг сааруулах, хариуцлага тооцох ил тод байдлыг нэмэгдүүлэх асуудлууд орно.

Монгол Улс хүний эрхийн талаархи бүх үндсэн тунхаглал, протокол, түүний дотор Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын найман үндсэн конвенцийг соёрхон баталсан. Олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагынхаа дагуу Монгол Улс холбогдох тайлангаа тогтмол тавьдаг. Түүнчлэн хүний эрхийн өргөн хүрээний асуудлыг хамран ажиллах бие даасан Хүний Эрхийн Үндэсний Комисс байгуулаад байна.

Төр, Засгийн газар иргэдийнхээ хүний эрхийг ерөнхийдөө хүндэтгэдэг. Гэхдээ АНУ-ын Хүний Эрхийн Хэрэгжилтийн 2005 оны Тайланд хэд хэдэн асуудлууд тусгагджээ. Үүнд: хоригдол болон сэжигтнүүдийг цагдаа нар хүчирхийлдэг; шоронгийн нөхцөл муу; дур мэдэн баривчилдаг; саатуулах хугацаа урт, шүүх эрх мэдлийн тогтолцоо авилгалд автагдсан; хэвлэл мэдээллийг засгийн газар нь айлган сүрдүүлдэг байж болзошгүйн улмаас хэвлэл мэдээлэл өөрийгөө хянадаг; гэр бүлийн доторх эмэгтэйчүүдийн хүчирхийлэл; хүүхдийн хүчирхийлэл болон хил давуулан хүн наймаалах тохиолдол зэргийг дурдсан юм.

Өнгөрсөн жил Монгол Улс нь НҮБ-ын Авилгалын Эсрэг Конвенцийг соёрхон баталсан нь авилгалтай тэмцэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд томоохон алхам болсон. Энэ нь АХБ/ОУЭЗХАБ-ын Авилгалтэй Тэмцэх Хөтөлбөрийн хүрээнд авсан үүрэг амлалтуудтай

уялдаж байгаа юм. Авилгал, хээл хахуулийг таслан зогсоох улс төрийн хүсэл зориг нь Мянганы Хөгжлийн Зорилгод “Авилгалыг үл тэвчих” хэмээн тусгайлсан зорилго тавьснаар дахин нотлогдож байна. Засгийн газар Авилгалтай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийг баталсан бөгөөд Авилгалтай Тэмцэх УИХ-ын Ажлын Хэсэг болон Хөтөлбөрийг зохицуулах Үндэсний Зөвлөлийг байгуулаад байна. Хэдийгээр эдгээр арга хэмжээг авсан ч, авилгал нь шийдвэрлэвэл зохих асуудал хэвээр байгаа нь түүнтэй илүү дорвитой тэмцэх шаардлагатай байгааг илтгэнэ.

Хэвлэл мэдээлэл ерөнхийдөө чөлөөтэй бөгөөд Засгийн Газрын бодлогод шүүмжлэлтэй ханддаг. Хэдийгээр Засгийн Газар улсын мэдлийн үндэсний сувгийг өөрсдийн үйл ажиллагааг сурталчлахад ашигладаг ч, хэвлэлийн эрх чөлөөнд халдах нь ховор байдаг гэж хэвлэл мэдээллийн ажиглагчид дүгнэдэг. Мөн маш олон сонинтой ч, тэдгээрийн тараалт хязгаарлагдамал юм.

Хөдөлмөрийн эрхийн хувьд ямар нэгэн ноцтой асуудал байхгүй. Ажилчид хоорондоо нэгдэн үйлдвэрчний эвлэл байгуулах, эмх цэгцтэй цугларч цуглаан хийхийг хуулиар зөвшөөрдөг. Албадан хөдөлмөр хориотой бөгөөд 2005 онд ОУХБ-ын Албадан Хөдөлмөрийн эсрэг Конвенцийг тус орон соёрхон баталжээ. Түүнчлэн хүүхдийн хөдөлмөрийг хуулиар хориглодог бөгөөд хуулийг ерөнхийдөө дагаж мөрддөг боловч, зарим тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийг албан бусаар ашиглаж байгаа тухай мэдээлэл байдаг.

Гадаад харилцаа

Монгол Улс хөрш хоёр том гүрэнтэйгээ харилцах харилцаандаа тэнцвэрт байдлыг хадгалахыг хичээдэг. Орос болон Хятад улстай хоёр талын өргөн хүрээний хамтын ажиллагаа явуулдаг. Хуучин Зөвлөлт Холбоот Улс задран унасны дараа шинээр тусгаар тогтносон улс орнуудтай Монгол Улс харилцаа холбоогоо хөгжүүлж байна.

Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулахад ОХУ болон ТТУХН-ийн бусад улсуудтай тогтоосон харилцаа холбоо нь хувь нэмрээ оруулж байна. 2006 оны долдугаар сард Оросын Холбооны Улсын Ерөнхий Сайд Михаил Фрадков Монголд айлчлахад, түүнийг Оросын томоохон бизнесийн төлөөлөгчид дагалдан ирсэн нь хоёр улсын хоорондын уламжлалт эдийн засгийн харилцааг улам өргөжүүлэх талаархи Оросын компаниудын сонирхлыг илтгэн харуулав.

Монгол-Хятадын харилцаа 1980-аад оны дунд үеэс дахин сэргэсэн бөгөөд уг харилцаа 1994 онд оргил цэгтээ хүрч, хоёр улсын тусгаар тогтнол болон газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх зарчмыг тусгасан Найрамдал Хамтын Ажиллагааны Гэрээг баталжээ. Хятад улсын эдийн засгийн хүчтэй өсөлт нь хоёр улсын хамтын ажиллагааг өргөтгөх томоохон боломжийг нээж өгч байна.

Олон талт байгууллагын хүрээнд Монгол Улс зургаан орныг нэгтгэсэн, ач холбогдол нь улам чухал болж буй бүсийн бүлэг болох Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагад /ШХАБ/ ажиглагчийн статустай болсон. Энэхүү байгууллага нь Орос, Хятад хоёр улсаас гадна Казахстан, Узбекистан, Тажикистан, Киргиз гэх Төв Азийн дөрвөн улсаас бүрддэг. Энэхүү ШХАБ-аас санал болгож буй эдийн засгийн өргөтгөсөн хамтын ажиллагааны үр шимээс хүртэнэ хэмээн Монгол Улс найдаж байна.

Зөвхөн хөрш орноор зогсохгүй, Монгол Улс бүс нутгийн болоод дэлхий дахинд харилцаа холбоогоо хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Энэ утгаараа ч Япон, Өмнөд Солонгостой илүү бат бэх харилцааг хөгжүүлээд байна. Түүнчлэн Монгол Улс Европын орнуудтай болон Америкийн Нэгдсэн Улстай харилцаа холбоогоо өргөжүүлэхийг тулд нэлээд хүчин чармайлт гаргаж ирсэн юм. Монгол Улсад айлчилсан АНУ-ын анхны Ерөнхийлөгч бол Жорж Буш байлаа. Ерөнхийлөгч Буш Монгол Улсын ардчиллын хөгжлийг сайшаагаад, АНУ-ын Мянганы Сорилын Санд багтсанд нь баяр хүргэсэн.

Хавсралт 2 – Байгаль орчны болон нийгмийн зангилаа асуудлууд

Байгаль орчны зангилаа асуудлууд

Монголын уул, тал, говь цөлийн бүсийг хамарсан газар зүйн өргөн уудам нутаг нь ургамал болон амьтны олон зүйл ангитай болохыг илтгэнэ. Монголын засгийн газраас байгалийн 28 дархан цаазат газрыг байгуулаад байна. Одоогоор нийт газар нутгийн 13.1 хувь нь хамгаалалтанд байдаг. Одоо байгаа байгалийн төрөл зүйл, эко тогтолцоог хамгаалах үүднээс 2030 он гэхэд үндэсний паркийг оруулаад нийт газар нутгийн 30 хувийг хамгаалалтанд авах зорилтыг Байгаль Орчны Яамнаас дэвшүүлээд байна.

Монголд байгаль орчны талаар санаа зовоож байгаа хэд хэдэн асуудал байна. Үүнд: ус, ой мод, бусад нөөц, дархан цаазат газар түүнчлэн хамгаалалтанд байгаа болон устах аюулд ороод байгаа төрөл зүйлсийн талаарх нарийн мэдээлэл, тооцооны хомс байдал; байгалийн нөөцийн тогтвортой удирдлагын төлөвлөгөө байхгүй; хууль бусаар ан хийх, ой модыг сүйтгэх, бүс нутгийг эвдэн амьтны амьдрах орчинг алдагдуулснаас хэд хэдэн төрөл зүйлсд сөнөх аюул тулгараад байгаагаас гадна биологийн төрөл зүйл буурч байгаа; үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас (уурхай, томоохон усан цахилгаан станц) үүссэн гол нууранд учруулж буй хохирол гэмтэл; бэлчээрийн зохисгүй дадлаас үүсч байгаа цөлжилт болон бэлчээрийн талхлалт; уул уурхайн үйлдвэрлэлээс үүссэн усны бохирдол, газрын доройтол болон хөрсний элэгдэл; хууль бус мод огтлол, гал түймрээс үүссэн ой модны сүйрэл; хурдацтай өсөн нэмэгдэж байгаа усны эрэлт нийлүүлэлт ба хүрэлцээгүй байдал болон гол гол усны хагалбар газрын дагуу өсөн нэмэгдсээр байгаа эдийн засгийн үйл ажиллагаа; нүүрсээр ажилладаг цахилгаан станцууд, бусад үйлдвэр, хувийн орон сууцанд ашиглагддаг нүүрсээр ажилладаг халаалтын зуухнаас үүссэн агаарын бохирдол; аюултай болон аюулгүй хог хаягдлын зохисгүй менежмент зэрэг орно.

Монголд өвлийн улиралд байгалийн өвөрмөц гамшиг (зуд) тохиолддог бөгөөд үүгээр малчид олон толгой малаа алддаг. Зундаа ган болж, өвөлдөө хэт хүйтэрч цас их унах, цаашилбал зарим газрын бэлчээр талхлагдан, мал бэлчээр өвс ногоогүй болж ерөнхийдөө байгаль орчин доройтсон нь энэ байдлыг улам хурцатгадаг.

Байгаль Орчныг Хамгаалах Үндэсний Мөрийн Хөтөлбөр (БОХҮХ)

Монгол Улс 1993 онд Байгаль Орчныг Хамгаалах Үндэсний Мөрийн Хөтөлбөрийг боловсруулсан ба уг Хөтөлбөр нь 2010 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан юм. БОХҮХ нь Засгийн Газрын эн тэргүүний асуудлуудыг тодорхойлж, байгаль орчны чанарын хамгаалалт, байгалийн баялгийг хамгаалах, байгууллагын чадавхийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгасан. БОХҮХ нь дараах гурван хэсгээс бүрдэж байна, үүн: (1) Байгаль орчны үндсэн асуудлууд, энэ нь байгаль орчны хамгаалал, байгалийн баялгийн менежмент, байгаль хамгаалал, байгалийн гамшгийг бууруулах гэсэн дөрвөн дэд хэсэгт хуваагдана. (2) Нийгэм эдийн засгийн асуудлууд, (3) Бусад механизм болон хариу үйлдлүүд.

БОХҮХ нь цөлжилт, ой мод, биологийн төрөл зүйл, ус, ховор төрөл зүйлийг хадгалан хамгаалах гээд ойролцоогоор 25 орчим байгаль орчны үндэсний хөтөлбөрийг агуулдаг. Үндэсний хөтөлбөрүүд нь бодлогын болон үйл ажиллагаанд чиглэсэн дэд хөтөлбөрүүдэд хуваагддаг. Санхүүжилтийн асуудлаас болоод БОХҮХ-ийн мөрдөлт, хэрэгжилт хангалтгүй байна. БОХҮХ нь нарийвчилсан ажлын төлөвлөгөөтэй хэдий ч, тооцоолсон төсөвгүй, хангалттай эх үүсвэргүй байгаа нь хэрэгжилтийг саатуулж байна.

Байгаль орчны талаархи хууль тогтоомж

Байгаль Орчны Яамнаас мэдээлж байгаагаар, анхны байгаль орчны тухай хууль нь 1994 онд батлагдсан ба үүний дараа 1995-1996 онуудад байгаль орчны бусад олон хуулиуд нэмэгдэн гарчээ. Байгаль орчны үндсэн хуулиудад Байгаль орчныг хамгаалах тухай Хууль (1995), Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1997), Байгалийн баялаг ашигласны төлбөр, хураамжийн тухай Хууль (1995-97), Ой, зэрлэг амьтад болон ан агнуурын тухай хуулиуд (1995), Газрын нөөц хамгааллын тухай хууль (1995), Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль (1997)–ууд тус тус орно. Ашигт малтмалын тухай шинэ хуулийг 2006 оны 7 дугаар сарын дундуур баталсан болно.

Хэдийгээр эдгээр байгаль орчны хуулиуд маш ойлгомжтой гэж Байгаль Орчны Яамнаас үздэг боловч, одоогоор үйлчилж байгаа 28 салангид хууль, 160 орчим журам стандартыг өөр хооронд нь нийцүүлэх цэгцлэх шаардлагатай байна. Одоогоор байгаль орчны талаархи хуулиудыг нийцүүлэн цэгцлэх ажил явагдаж байгаа хэдий ч, уг ажлыг үр дүнтэй болгохын тулд олон улсын туршлага, мэдлэг бүхий мэргэжилтнүүдийг энэ ажилд татан оролцуулахыг Байгаль Орчны Яам хүсч байгаа юм.

Монгол Улс нь Озоны Давхрагыг Хамгаалах Венийн Конвенц, Озоны Давхрагыг нимгэрүүлдэг химийн бодисын талаарх Монреалын Протокол, Цаг Уурын Өөрчлөлтийн Конвенц, Биологийн Төрөл Зүйлийн Конвенц, Цөлжилтийн Эсрэг Конвенц, Зэрлэг ан амьтан, ургамлын устах аюулд ороод буй төрөл зүйлийн Олон Улсын Худалдааны Конвенц, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, устгах ажиллагаанд хяналт тавих тухай Базелийн Конвенц, Нүүдлийн зэрлэг ан амьтдын төрөл зүйлийг хамгаалах Конвенц, Киотогийн Протокол зэрэгт нэгдэн орсон.

Олон улсын байгууллагууд болон бусад төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа

Байгаль орчны болон хөгжлийн чиглэлээр ажилладаг хэд хэдэн олон улсын байгууллага, хөтөлбөрүүд Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

НҮБХХ-өөс ус, агаарын бохирдол, цөлжилт гэсэн дэлхий нийтийн нийтлэг асуудлуудаар Мянганы Хөгжлийн Зорилгод хүрэхээр хэд хэдэн төслүүдийг хэрэгжүүлж байна. Мөн түүнчлэн Монгол орон даяар мал маллагаа, ой мод, зэрлэг амьтдын менежментийн чиглэлд жижиг хамтын нийгэмлэгүүдийг түшиглэсэн санаачлагыг хөгжүүлэх талаар идэвхитэй ажиллаж байна. Одоогоор Монголын баруун дөрвөн аймагт газар нутгийг хамгаалах төсөл, төв болон хойд хэсгийн аймгуудад бэлчээрийн доройтлыг бууруулах бэлчээрийн газрын менежментийн төслийг хэрэгжүүлж байна. НҮБХХ нь түүнчлэн (1990-2001 онуудад дараалан тохиолдсон байгалийн гамшигт хөдөө нутаг, ялангуяа малчин ард огт бэлтгэгдээгүй байсан байдлыг засаж залруулах зорилгоор) Монгол дахь Гамшгийн менежментийн хүчин чадлыг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлсэн. Төслийн эхний үе шатанд байгууллагын тогтолцоог өөрчлөх, Онцгой Байдлын Газар байгуулах асуудлууд хамрагдсан. Хоёр дахь үе шатанд саяхан Засгийн Газраас батлагдаад байгаа Гамшгийн Удирдлагын Хуулийг боловсруулах асуудал багтсан. 2006-2015 оны Гамшгийн Удирдлагын Үндэсний Төлөвлөгөө удахгүй батлагдаж магадгүй байна.

ДАС: Монголын 2003-2010 оны хөтөлбөрийн чиглэлүүд нь Дэлхийн Амьтны Сангийн Дэлхий нийтийн хөтөлбөр болон Алтай Саяны Эко бүсийн мөрийн хөтөлбөрүүдээр тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэж байгаа юм. Уг хөтөлбөр нь тэргүүлэх ач холбогдолтой төрөл зүйлсийг хамгаалах, цэвэр усны экосистемийг хамгаалах, арчлах, зэрлэг ан амьтдын хууль бус худалдаа, уурхайн зохисгүй ажиллагаа, талхлалт, байгалийн баялгийг хэт ихээр олборлохоор тооцсон төлөвлөгөө зэргээс биологийн төрөл зүйлд учирч буй аюулыг дүгнэхийг зорьж байгаа юм.

Германы Техникийн Хамтын Ажиллагааны Сан, Бээжин дэх Нидерландын Элчин Сайдын Яамтай хамтран Монголын төвийн болон говийн бүс нутаг дахь хамгаалалттай газрын тогтвортой менежмент, хамгааллыг багтаасан Байгалийн Баялгийн Тогтвортой Удирдлага, Хамгаалалт хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөр нь орон нутгийн эдийн засгийн хөгжил, эко-жуулчлалын бүрдэл хэсгүүдийг өөртөө багтаасан.

Байгаль орчныг хамгаалах талаархи төрийн бус байгууллагын хөдөлгөөн нь ерөнхийдөө олон улсын хандивлагчдаар дэмжигддэг. Байгаль орчныг хамгаалдаг ихэнх төрийн бус байгууллагууд нь эхний ээлжинд байгаль орчны боловсрол, сургалтын үйл ажиллагаанд гол төлөв анхаардаг бол, байгаль орчныг хамгаалах, дахин ойжуулах зэрэг үйл ажиллагааг арай бага хэмжээгээр явуулдаг.

Нийгмийн зангилаа асуудлууд

Хөдөлмөрийн асуудлууд

2004 оны албан ёсны статистикт ажилгүйдлын хувь хэмжээ 3.6 хувиар гарсан нь хэт доогуур тооцсон мэт санагдана. Тэгвэл 2000 оны хүн амын тооллогоор ажилгүйдлийн бодит түвшин 17 хувиар тооцогджээ. Ажилгүйчүүдийн ихэнх нь залуучууд байгаа ба нийт ажилгүйчүүдийн дунд хөдөөнөөс ажил хайж хотод ирж суурьшсан хүмүүсийн эзлэх хувь өндөр байна.

Монгол Улс нь ОУХБ-ын үндсэн конвенцүүдийг бүгдийг соёрхон баталсан. Хуулиар хүчээр, эсвэл албадан хөдөлмөр эрхлэхийг хориглодог бөгөөд үүнийг ерөнхийдөө Засгийн Газар дагаж мөрддөг. Засгийн Газар ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн эсрэг Конвенцид гарын үсэг зурж, соёрхон баталсан. Ерөнхийдөө хуулийн дагуу 16-аас доош насны хүүхдийг хөдөлмөрлөхийг хориглодог, гэхдээ 14 буюу 15 насны хүүхдүүд эцэг эхийн зөвшөөрөлтэйгээр долоо хоногт 30 хүртэл цаг ажиллаж болдог. 18-аас доош насны хүүхдүүд шөнийн цагаар ажиллах, уул уурхайн, барилгын зэрэг хүнд, аюултай нөхцөлд ажиллахыг хориглоно. Хөдөлмөрийн байцаагчид цөөн байгаа, нөгөө талаас аж ахуйн нэгжүүдийн тоо хурдтай өсч байгаагаас дурдсан хуулийг дагаж мөрдүүлэх тал дээр дутагдалтай зүйлс байсаар байна.

Хүүхдүүд албан бус жижиг худалдаа эрхлэх, хог хаягдал ухах, жижиг хэмжээний зөвшөөрөлгүй уурхайд ажиллах, мал хариулах зэрэг ажил хийж байна. Хүүхдийн хөдөлмөр гол төлөв хөдөө аж ахуйд тохиолдож байгаа тул аюулгүй гэж тооцогддог. Архидалт ихээр нэмэгдэж, эцэг эхчүүд хүүхдээ хаяж байгаагаас хүүхдүүд өөрсдийгөө, ах эгч дүүгээ, заримдаа эцэг эхээ тэжээхийн тулд орлого олох зайлшгүй шаардлагатай болдог. 58,000 хүүхэд ажил эрхэлж байна гэсэн баримжаа тооцоо байдаг. Хүүхдийг хүчээр эсвэл албадан хөдөлмөр эрхлүүлэхийг Засгийн газар хориглодог, үүнийгээ ч үр дүнтэй хэрэгжүүлдэг.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тухай хуулинд УИХ-аас оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгод нийцсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээр арга хэмжээнд ажил эрхлэлтийн үйлчилгээг олон талт болгох, албан бус салбарт ажиллагсад, малчдыг ажил эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах, шинэ үйлчилгээг бий болгох, үйлчилгээг хүргэх шинэ арга боловсруулах, орлого бий болгох ба хуваарилах аргыг боловсронгуй болгох, болон Хөдөлмөр Эрхлэлтийн Сангийн удирдлагын бүтцийг сайжруулах зэрэг чухал арга хэмжээнүүд багтаж байна. Түүнчлэн Засгийн Газар Албан бус сектор дахь ажил эрхлэлтийн талаар баримтлах бодлого боловсруулж гаргасан.

Шилжилтийн эдийн засаг бүхий бусад орнуудын нэгэн адил Монгол нь албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн хувьд ашиглах зорилгоор эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийг хил дамнуулан гаргадаг эх сурвалж орон болсон. Мөн ашиг олох зорилгоор тус оронд хүүхдийг бэлгийн ажилд татан оролцуулах явдал байгаа нь Монгол Улсад тулгараад байгаа сэтгэл зовниулсан асуудал юм. Энэхүү хууль бус ажиллагаатайтэмцэх шаардлагыг Монгол Улс хангаж чадахгүй байгаа ч, үүнийг арилгахын тулд Засгийн Газар нь ихээхэн хүчин чармайлт гаргаж 2006 оны 3 дугаар сард Хүүхэд, эмэгтэйчүүдийг ашиг олох зорилгоор бэлгийн үйлчилгээний ажил эрхлүүлэхээс хамгаалах арга хэмжээний үндэсний төлөвлөгөөг батлан гаргасан. Энэ төлөвлөгөөний гол зорилго нь хүнийг хууль бусаар хил давуулахаас хамгаалах эрх зүйн хүчтэй орчныг бий болгох, энэ талаархи хүмүүсийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хохирогчийг хамгаалах болон сэргээх эмчилгээг сайжруулахад оршиж байгаа юм. Монголын

засгийн газар нь хууль бусаар хүн хил давуулахтай тэмцэх үйл ажиллагаанд ТББ-ууд, бүсийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хүн ам зүй болон бүс нутгийн ялгаа

Монгол Улсын хүн ам 2.6 сая орчим ба түүнийг газар нутгийнх нь хэмжээтэй (1.6 сая кв.км) харьцуулбал маш бага юм. Хүн амын дийлэнх нь нэг үндэстэн бөгөөд цөөн тооны ястангууд байдгийн нэг нь нутгийн баруун хэсэгт төвлөрдөг 100,000 орчим хүнтэй Казакууд юм.

Өнөөгийн байдлаар хүн амын 60 хувь нь хот газар амьдардаг ба 1999-2001 онд болсон байгалийн гамшгаас болоод хөдөөгөөс хот руу шилжин суурьшилт нь эрс нэмэгдсэн. Энэхүү гамшиг нь малчдыг орлогоо алдахад хүргэж, улмаар тэднийг ажил, амжиргааны бусад эх үүсвэр хайх, дэд бүтэц, үйлчилгээнд ойртохын тулд хот суурин газар руу нүүхэд хүргэж байна. Мэргэжлийн хүмүүс, түүний дотор эмч, багш нар мөн хөдөөнөөс хот руу шилжиж байна. Энэ нь эргээд хөдөө орон нутгийн нийгмийн дэд бүтцийн хүртээмж доройтоход хүргэсэн. Ихэнх суурин хүн ам Улаанбаатарт байдаг ба НҮБХХ судалгаагаар 1990-1998 онуудад Монголын нийслэлийн хүн ам 20 хувиар өссөн ба бусад долоон хотуудын хүн ам нь 17.6 хувиар буурчээ. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны тооцоолсноор Улаанбаатарт 800,000 хүн амьдардаг, гэтэл одоогийн дэд бүтэц нь 500,000 хүнийг л үйлчлэх хүчин чадалтай юм.

Энэхүү шилжин суурьшилтын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд хүн амын шилжин суурьшилтын талаар Үндэсний Чуулганыг зохион байгуулж шилжин суурьшилтын асуудлаар зөвлөмжүүдийг гаргасан. Шилжин суурьшилтын нөлөөг багасгахад засгийн газрын, иргэний нийгмийн, хувийн хэвшил, мөн гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байгааг эдгээр зөвлөмжид тусгасан. Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг хянахаар УИХ-ын Нийгмийн Бодлогын Байнгын Хорооны ажлын хэсэг байгуулагдсан.

Хүний хөгжил ба ядуурал

НҮБХХ-ийн “Монголын Эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” (2005) гэсэн тайланд эдийн засгийн эмзэг байдал 1990 оноос хойш улам нэмэгдсэнийг дурьджээ. Гэхдээ ядуурлын түвшин 2002¹⁴ онд 36 хувь байсан бол, 2006 онд 32 хувь болж, үргэлжлэн буурсаар байна. Ядуурал хөдөөд 43 хувь, хот суурин газарт 30¹⁵ хувьтай байна. Баруун бүсэд ядуурал Улаанбаатарынхаас хоёр дахин өндөр буюу нийт хүн амынх нь 50 гаруй хувь ядууд тооцогдож байна. Ядуучуудын дунд хамгийн том хэсгийг малчин өрхүүд эзэлж байна.

Монголын нийт хүн амын гуравны нэг нь мал маллагаагаар амьжиргаагаа залгуулдаг өрхүүдэд амьдарч байна. Малын хорогдол нь маш том эрсдэл байдаг бөгөөд малын гэнэтийн хорогдол нь малчин өрхүүдийн хэрэглээ болон тэдний аж амьдралд сөргөөр нөлөөлдөг.

Монголд бичиг үсэг тайлагдалтын түвшин хотод ч, хөдөөд ч өндөр. Боловсролын заавал эзэмшсэн байх түвшин 8 дугаар ангиар хязгаарлагддаг. Алслагдмал байдлын улмаас хөдөөд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж зарим талаар хязгаарлагдмал байдаг. Хөдөөд эрүүл мэндийн үйлчилгээг эмчлэх аргад¹⁶ зонхилон анхаардаг бол, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадал хангалтгүй байна.

Нялхсын эндэгдэл, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, цэвэр ус болон халуун усны хангамж зэрэг мөнгөн бус үзүүлэлтүүдээс харахад амьжиргааны түвшин дээшилсэн. Ус, цахилгааны хүртээмж ялангуяа ядуучуудын хувьд илүүтэйгээр нэмэгдсэн.

¹⁴ Ядуурлын үнэлгээ: Монгол улс 2006

¹⁵ Ядуурлын үнэлгээ: Монгол улс 2006

¹⁶ Азийн Хөгжлийн Банк нь өрхийн эмчийн тогтолцоог бүрдүүлэхэд нь туслах, анхан шатны эмнэлгийн тусламжийн тогтолцоог хөгжүүлэх болон эмнэлгийг сэргээн засварлах зэргээр Монгол Улсын засгийн газрын эрүүл мэндийн салбарт нь тусламж үзүүлж байгаа.

Монголын наад захын хэрэглээний багцын зөвхөн 44 хувийг хүнсний зүйлс, 56 хувийг хүнсний бус зүйлс, үүнд дулаан үлэмж хувийг эзэлж байна. Эрчим хүчний салбар дахь татаасын тогтолцоо нь ядуу, эмзэг бүлгийнхэнд хүрч чаддаггүй. Улаанбаатарт байгаа ядуу өрх хахир хатуу өвлийн улиралд¹⁷ нийт хэрэглээнийхээ тавны нэгийг зөвхөн түлшинд зарцуулдаг. Дулаанд (уламжлалт зуух ашиглан) зориулж байгаа зардал нь Улаанбаатарын хамгийн ядуу хэсэг буюу гэр хорооллынхонд маш том ачаалал болдог. Хөдөөгийн зарим нэг газруудад цахилгаан үүсгүүрийн хүчин чадал хангалттай биш байдаг ч, ерөнхийдөө Монголын хүн амын хувьд цахилгаан эрчим хүчний хүртээмж харьцангуй сайн байдаг.

Олон улсын байгууллагууд болон хөгжлийн хөтөлбөрүүдийн тусламжтайгаар Монголын Засгийн Газар нийгэм-эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхийг хичээн ажиллаж байна. Бодлогын салбар хоорондын зохицуулалтыг хийж байхаар тусгай Үндэсний Хороог, а) гэр бүлийн хөгжил; б) хүүхэд, өсвөр насныхан, залуучуудын хөгжил; в) өндөр настнуудын; г) тахир дутуу иргэдийн гэсэн дэд ажлын хороодуудтай байхаар байгуулсан. Одоогоор өрхийн болон хүн амын мэдээллийн баазыг бүрдүүлж байгаа нь хүн амын нийгэм-эдийн засгийн байдлыг бүртгэх, мэдээллийг боловсруулах, түүн дээр үнэлгээ хийх ажиллагааг эрс сайжруулах юм.

Эрх тэгш боломж ба жендерийн асуудал

Бүсийн бусад олон оронтой харьцуулахад Монгол Улс нь жендерийн эрх тэгш байдал хангагдаж байгаа мэт санагдана. Ажиллах хүчний тэн хагас эмэгтэйчүүд, түүнчлэн олон өрхийн үндсэн орлого бүрдүүлэгчид нь эмэгтэйчүүд байдаг. Гэхдээ эдийн засгийн шилжилтийн үр дагавар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд ялгаатай туссан нь саяхан хийгдсэн судалгаа¹⁸ болон үндэсний статистикийн жендерийн дүн шинжилгээнээс харгадаж байна. Энэхүү өөрчлөлтийн үе нь Монголын нийгэм эдийн засгийн олон хүрээнд урьд өмнө байгаагүй жендерын ялгавартай байдлыг бий болгож байна.

Ядуурлаас болж шилжин суурьшилт нэмэгдсэн нь нийгмийн хангамжийн сүлжээг эвдэхэд хүргэж, олон эмэгтэйчүүдийг гэрийн гадна, дотно олон төрлийн хариуцлагыг үүрэх их ачаанд, уламжлалт дэмжлэггүй үлдээсэн юм. Малыг хувьчилснаар улсын үйлдвэрлэлд ажиллаж байсан олон мянган өрх ажилгүй хоцорсон. 1999-2001 онуудад дараалан тохиолдсон зудын гамшгаас эдгээр өрхүүд малаа алдаж, ажил олохын тулд хот руу нүүхээс аргагүйд хүрсэн. Эмэгтэйчүүд, охидууд үйлчилгээний салбарт ажил олдоно гэсэн итгэлийг өвөрлөсөөр нүүцгээж байв. Гэтэл ажлын байр хязгаарлагдмал байгаагаас сум, аймгийн төв зэрэг жижиг суурин газруудад өрх толгойлсон ядуу эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр болоод байна.

Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад бизнесийн шинэ орчинд илүү амархан дасан зохицдог болохыг бичил болон жижиг дунд аж ахуйд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэгч байгууллагууд тэмдэглэсэн байна.

Боловсролын бүх шатанд хамрагдагсдын дунд үүссэн жендерын ялгаа нь мэдлэг боловсролын түвшингийн хувьд тэнцвэргүй байдлыг бий болгож, тэр нь эргээд эдийн засаг, нийгмийн томоохон үр дагаварт хүргэж байна. Ядуурлын улмаас илүү олон хөвгүүд эр хүн голчлон хийдэг мал маллах зэрэг ажил эрхэлж орон гэртээ орлого оруулахын тулд охидуудтай харьцуулахад илүү олноороо сургуулиас завсардаж байна. Мөн одоогийн боловсролын тогтолцоо ажил эрхлэх чадвартай боловсон хүчнийг бэлтгэж чадахгүй байгаа гэж олон эцэг эхчүүд үздэг болжээ. Эдгээр асуудлыг хариуцах, бодлого, хэрэгжилт, үр дүнг дүгнэн ажиллаж байхаар Ерөнхий сайдаар ахлуулсан Жендерын Тэгш Байдлын Үндэсний хороог 2006 оны Засгийн газрын 26 дугаар тогтоолоор байгуулсан байна.

¹⁷ Тэгээс доош хэмийн хүйтэн бүтэн 6 сарын турш үргэлжилдэг, Улаанбаатарт өвлийн 1,2-р саруудад дунджаар -25 хэм, хөдөөд -40 хэм хүрдэг.

¹⁸ Улс орны Жендерийн үнэлгээ: Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, 2005

Олборлох салбар ба түүний нийгэм-эдийн засгийн үр дагавар

Алт, зэс зэрэг байгалийн баялгийн олборлолт, мал аж ахуйн үйлдвэрлэл нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд гол тулгуур болсон салбар юм. Уул уурхайн салбарт албан ёсоор 12 мянган хүн, харин албан бусаар (“нинжа”) үүнээс хэд дахин олон хүн ажиллаж байна. Монголд урьд өмнө нь хувиараа гар аргаар болон жижиг хэмжээгээр ашигт малтмалын олборлолт хийдэггүй байсан хэдий ч, эдийн засгийн хүнд хэцүү үед энэ нь хэдэн арван мянган хүний (ойролцоогоор 30,000-100,000-ийн хооронд) амь амьжиргааны гол эх үүсвэр болон маш эрчимтэй өсч, байгалийн гамшигт малаа алдсан малчдын нийгмийн хамгааллын сүлжээ болтлоо өргөжөөд байна. Албан ёсоор уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчид болон орон нутгийн захиргааныхан тэдгээрийг хууль бусаар ажиллаж, мөн байгаль орчинд халтай ажиллагаа явуулж байна хэмээн шүүжилдэг. Гар аргаар ашигт малтмал олборлолтын тухай шинэ хуулийн төслийг боловсруулаад байгаа. Голдуу мэргэжлийн бус уурхайчид байдаг гар аргаар олборлогчид лицензтэй уурхай руу халддагаас тэдний хооронд сөргөлдөөн үүсэх нь олонтаа тохиолддог. Тэд алтны компаниудын хаягдлаас алт угааж гаргахын тулд мөнгөн ус зэрэг бодисуудыг ашиглаж байгаа нь байгаль орчин болон эрүүл мэндэд хортой нөлөөллийг бий болгож байна.

Анхаарал татсан өөр нэгэн зүйл бол уул уурхайн компаниуд болон орон нутгийнхны хоорондын харилцааны асуудал юм. Байгалийн нөөцийн олборлолт нь Монголын эдийн засгийн гол тулгуур салбар хэдий ч, энэ нь орон нутгийн хувьд хангалттай ажлын байрыг бий болгож чаддаггүй. Одоогоор газар болон байгалийн баялаг нь төрийн өмч байж, бэлчээрийн газар болон бусад нөөцийг мал аж ахуй эрхэлдэг хөдөөгийнхөн, хагас нүүдлийн аж ахуй эрхлэгчдэд үнэгүй ашиглуулдаг. Ашигт малтмалын ордуудын лицензийг орон нутгийн захиргаа болон нутгийнхантай зөвшилцөхгүйгээр Үйлдвэр худалдааны яам төвлөрсөн журмаар олгодог. Хөрсийг элэгдүүлж, гол усыг бохирдуулж, газар нутгийг ерөнхийд нь муутгаж байгаа нь орон нутгийнхныг бухимдуулж, орон нутгийнхан ба компаниудын хоорондын хурцадмал байдал улам ширүүсч байна. Уул уурхайн компаниуд хөгжлийн “нэмэлт” хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч, эдгээр хөтөлбөрүүдэд зориулж буй хөрөнгө чамлалттай байна.

Хавсралт 3 – Санхүүжилт хийхээр бэлтгэж буй төслийн жагсаалт¹⁹

Салбар	Төслийн тоо	Дүн Сая ам.дол	Улсын/ хувийн
Нэхмэл, сүлжмэл/ Ерөнхий боловсруулах аж үйлдвэр	5	16.5	Хувийн
Санхүү	8	46.0	Хувийн
Уул уурхай	1	20.0	Хувийн
Эрчим хүч	1	20.0	Хувийн
Хотын нийтийн аж ахуй, байгаль хамгаалах / Тээвэр	3	35.0	Хувийн/улсын
Үл хөдлөх хөрөнгө / Аялал жуулчлал	2	10.0	Хувийн
Нийт	20	147.5	

¹⁹ Санхүүжилт хийхээр бэлтгэж буй төслийн жагсаалт нь Банкны амлалт гэсэн үг биш. Тэрээр Стратегийн хэрэгжилтийн үе шатанд шинээр гарч ирэх боломжит төслүүдийг тусгаагүй болно.

Хавсралт 4 – Техникийн туслалцааны төслүүдэд амласан дүн (Монголтой Хамтран Ажиллах Сан)

	Амлалт мян.евро	Зарцуулалтмян.е вро
<u>Хувийн хэвшил</u>	<u>73</u>	<u>56</u>
ЖДҮ менежментийн сургалт	73	56
<u>Санхүүгийн байгууллагууд</u>	<u>1362</u>	<u>1306</u>
Хаан Банкинд бичил зээлийн зөвлөх	850	850
Монголын банкируудад зориулсан сургалтын хөтөлбөр	322	322
Банкируудад зориулсан зээлийн дүн шинжилгээ хийх сургалт	25	25
Олон улсын банкны үйл ажиллагааны сургалт	115	109
Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжил	50	
<u>TAM Хөтөлбөр</u>	<u>2395</u>	<u>1795</u>
TAM Хөтөлбөр (24)	2395	1796
<u>Дэд бүтэц ба байгалийн баялаг</u>	<u>3122</u>	<u>1788</u>
МИАТ удирдлагын гэрээ	675	643
Иргэний нисэхийн Мастер төлөвлөгөө	359	359
Орон нутгийн нисэх буудлыг сэргээн засварлах	350	
Улаанбаатар хотын нийтийн тээвэр	520	
Эрчим хүчний салбарын хувьчлал	500	271
Харилцаа холбооны хувьчлал (2)	550	466
Газрын тос боловсруулах боломж	49	49
Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын чадавхийг бэхжүүлэх	119	
<u>Эрх зүйн шинэчлэл</u>	<u>1207</u>	<u>264</u>
Компанийн засаглал	226	226
Харилцаа холбооны салбарын эрх зүйн шинэчлэл	801	38
Барьцаат хэлцэл	180	
<u>Бусад</u>	<u>735</u>	<u>718</u>
Захиргааны ТХА болон бусад (9)	735	718
<u>Нийт (55)</u>	<u>8894</u>	<u>5928</u>

Жич: Нэг зорилго, чиглэлтэй төслийн тоог хаалтад харуулав.

Хавсралт 5 –Төлөвлөж буй техникийн туслалцааны төслүүд

Төсөл	Салбар	Дүн Еврогоор
Биологийн төрөл зүйлийн төсөл	Байгаль орчин	50,000
Монголын банкуудад зориулсан Худалдааны санхүүжилтийн талаархи зөвлөлгөө өгөх үйлчилгээ	Депозитар зээл (Банкууд)	250,000
ЖДҮ-т дамжуулан зээлдүүлэх Банк дундын санхүүжилтийн хэрэгсэл	Депозитар зээл (Банкууд)	1,000,000
Монголын ипотекийн зах зээлийг хөгжүүлэх	Депозитар бус зээл (Банк бус)	1,000,000
Монголын банкуудыг бусад орны ижил төстэй банкуудтай холбож хамтран ажиллах хөтөлбөр	Депозитар зээл (Банкууд)	1,500,000
Институцианал байгууллагыг бэхжүүлэх хөтөлбөр (2 жил)	Бичил санхүү	2,000,000
Төслийн нарийвчилсан дүн шинжилгээ/ГЭЗҮ/Хөрөнгө оруулалтын дараах зөвлөх үйлчилгээ	Ерөнхий	425,000
Удирдлагыг Үндсээр нь Өөрчлөн Байгуулах ТАМ Хөтөлбөр- 10 аж аухйн нэгж	Төрөл бүрийн салбарын үйлдвэрлэл	744,000
Бизнесийн зөвлөлгөө өгөх BAS хөтөлбөр	Зөвлөх үйлчилгээ	500,000
Нийт		7,469,000*

Жич: ТТТ-д шаардлагатай дүнгийн 1.2 сая евро нь МХАС-ийн үлдэж буй хөрөнгөнөөс, үлдсэн 6.3 сая еврог Шилжилтийн Эхний Үе дэх Орнуудыг Дэмжих Сан болон хоёр талын бусад хандивлагчдаас дайчлан гаргуулна.

Хавсралт 6 – Эрх зүйн үнэлгээ

ЕСБХБ нь үйл ажиллагаа явуулдаг орнууд дахь эрх зүйн шилжилтэнд цуврал үнэлгээ өгч, түүнийгээ байнга шинэчилж байдаг. Ингэхдээ хөрөнгийн зах зээл, компанийн тухай хууль, компанийн засаглал, концесси, дампуурал, барьцаат хэлцэл, болон харилцаа холбоо гэсэн хөрөнгө оруулалттай холбоотой тодорхой асуудалд төвлөрдөг. Энэхүү үнэлгээг хийхэд хэрэглэдэг аргаар хүчин төгөлдөр хуулийн чанарыг “цаасан дээр байгаа байдлаар” (экстенсив талаас) нь, мөн тухайн хуулийн бодит хэрэгжилт (үр дүнгийн хувьд) гэсэн хоёр талаас нь үнэлдэг. Энэхүү хавсралтад Банкнаас Монголын талаар хийсэн эрх зүйн үнэлгээг, үнэлгээ хийсэн мэргэжилтний тайлбарын хамт нэгтгэн тусгалаа. Монгол Улс нь Банкны үйл ажиллагаагааны орноор саяхан шинээр батлагдсаны хувьд зарим нэг үнэлгээ төдийлөн тодорхой бус байгаа тул, стратегийн хэрэгжилтийн хугацаанд эдгээрийг тодруулах шаардлагатайг дурдах хэрэгтэй.

Хөрөнгийн зах зээл

Монголын үнэт цаасны зах зээлийг зохицуулсан үндсэн хууль тогтоомж нь Үнэт цаасны тухай хууль юм. Түүнийг Улсын Их Хурлаар 1994 оны 9 дүгээр сард батлан гаргаж, 1995 оны 1 дугаар сарын 1-нээс хойш мөрдөж байна.

Үнэт цаасны тухай хуульд 2002 оны 12 дугаар сард нэлээд нэмэлт өөрчлөлтийг оруулсан нь 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. Үнэт цаасны тухай хуулиар хөрөнгө оруулагчийг хамгаалах, үнэт цаас гаргах, арилжих, клиринг болон тооцоо хийх талаархи үндсэн заалтууд тусгагдсан.

Монголын хөрөнгийн бирж 1991 онд байгуулагдаж, 1992 оны 2 дугаар сараас хувьчлалын тасалбарыг арилжаалж эхэлсэн. Үнэт цаасны тухай хууль хүчин төгөлдөр болж, Үнэт цаасны хороо байгуулагдсаны дараа буюу 1995 оны 8 дугаар сараас үнэт цаасны хоёрдогч зах зээл үйл ажиллагаагаа эхэлсэн.

2006 оны 2 дугаар сард шинээр байгуулагдсан Санхүүгийн Зохицуулах Хороо нь банк бус санхүүгийн бүх байгууллагууд, түүний дотор үнэт цаасны компаниудын үйл ажиллгааг зохицуулахаар болсон. Тус Хороо нь зах зээлийг хянах ба зохицуулах болон банк бус санхүүгийн бүх үйл ажиллагаанд тохирох зохицуулалт хяналтын орчинг бий болгох үндсэн үүрэгтэй юм.


Компанийн хууль ба компанийн засаглал

Компанийн засаглалын тогтолцооны эрх зүйн үндсийг Иргэний хууль болон 1999 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Компанийн тухай хууль тавьж өгсөн. Компанийн тухай хууль нь 1999 оноос өмнө мөрдөгдөж байсан Нөхөрлөл, компанийн тухай хуулийн оронд гарсан юм.

ЕСБХБ-ны Компанийн засаглалын үнэлгээгээр хуулийн чанар буюу түүний хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийгээд, Монгол дахь компанийн засаглалын хууль тогтоомж нь ЭЗХАХБ-ын (OECD) Компанийн Засаглалын Зарчмуудаар тогтоосон олон улсын хэм хэмжээнд хэр зэрэг нийцэж байгааг тогтоожээ. Тухайн зарчмуудыг шалгуур болгон харьцуулж үзэхэд, ялангуяа хувьцаа эзэмшигчдийг ижил, тэгш байдлаар авч үздэг талаар илүү нийцэж байна.

Харин “Нийтэд мэдээлэх ба ил тод байдал” гэсэн үзүүлэлтийн хувьд нэлээд асуудлууд гарсан байна. Бүлгийн нэгдсэн тайлан гаргах болон захирлуудын зөвлөлийн гишүүдээс бусад компанид гол албан тушаал эрхэлдэг тухай ил тод мэдээлэхийг хуулиар шаарддаггүйг үнэлгээгээр тогтоосон байна. Улмаар, компанийн холбогдох баримт бичгийг (жишээ нь, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, дүрэмд орсон өөрчлөлт, чөлөөлөгдсөн болон шинээр томилогдсон захирлын нэр) нийтэд нээлттэй мэдээлэх эрх зүйн шаардлага тусгагдаагүй.

Компанийн засаглалын талаарх хууль тогтоомжийн чанар – Монгол Улс (2004)



Жич: Тэнхлэг бүрийн туйлын цэг нь ЭЗХАХБ-ын Компанийн Засаглалын Зарчмуудаар тогтоосон олон улсын стандартын дагуух төгс төгөлдөр байдалд нийцсэн дээд цэг байх юм. Тор хэдий чинээ туйлын цэгүүдэд ойртож очино, тус улсын компанийн засаглалын хууль нь тухайн стандартад дөхөж очиж байгааг илтгэнэ.

Эх үүсвэр: ЕСБХБ-ны Компанийн засаглалын үнэлгээ, 2003-04 он.

2005 онд ЕСБХБ компанийн засаглалын үр дүн (хууль хэрхэн амьдралд хэрэгжиж байгааг)-гийн талаархи судалгааг хийж эхэлсэн. Хөрөнгийн биржид бүртгэлтэй болон бүртгэлгүй компаниуд дээр хамааралтай этгээдтэй хийсэн хэлцлийн хоёр тохиолдлыг авч үзсэн юм. Хамааралтай этгээдтэй хийсэн хэлцлийг тухайн компани хийсэн эсэхийг цөөнхийн хувьцаа эзэмшигчид мэдэж авах боломж байна уу, мөн ямарваа нэгэн хохирол учирсан тохиолдолд тэр хохирлыг эргүүлэн төлүүлж чадах эсэх гэсэн асуултуудыг тавьж судалсан. Хуулийн үр дүнтэй байдлыг байгууллагын орчин, дүрэм журмыг мөрддөг байдал, нарийн түвэгтэй байдал болон түргэн шуурхай байдал гэсэн үндсэн 4 үзүүлэлтээр хэмжсэн.

Судалгаагаар Монголд хэд хэдэн дутагдалтай тал байгаа нь тогтоогдсон. Мэдээлэл олж авах, хохирол нөхөн төлөх журам дүрэм нь нилээд төвөгтэй, ялангуяа компани болон/эсвэл хяналтын багцыг барьдаг хувьцаа эзэмшигч жижиг хувьцаа эзэмшигчидтэйгээ хамтран ажиллахаас татгалзах тохиолдолд бүр ч төвөгтэй байна. Байгууллагын орчны хувьд компанийн мэдээ нь ихэнхдээ найдваргүй, аудиторуд нь ихэнхдээ хараат бус байдлаар ажиллаж чадахгүй байгаа нь судалгаагаар нотлогдсон. Энэ хоёр нөхцөл нь мэдээллийг олж авах боломжийг бууруулж байгаа юм.


Хуулийг тайлбарлан хэрэглэх заавар болж чаддаг жишгийн хуулийн тогтолцоо байхгүй нь шүүхийн шүүн хэлэлцэх ажиллагаанд сөргөөр нөлөөлсөөр байна. Шүүн хэлэлцэн ажиллагааны хугацааг нэг жил гэж тооцсон хэдий ч, тус ажиллагааг шүүгдэгч хялбархан сунжруулах боломжтой. Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдгийг тайланд дурьдсан байна. Ер нь шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх нь хэцүүгээс гадна их цаг зав зарцуулдаг. Хохирол нөхөн төлүүлэх хэргийн хувьд, доод шатны шүүх аж аухйн хэргийн талаар туршлага, мэдлэг дутмаг, түүнчлэн хараат бус байдлыг төдийлөн хангадаггүйг судалгаагаар тогтоожээ. Ялангуяа хүчтэй шүүгдэгчийн хэргийг хэлэлцэх тохиолдолд энэ нь бүр ч үнэн байх талтай. Үүнээс үндэслэн тус улсад компанийн засаглалын талаарх эрх зүйн тогтолцоо үндсэндээ сул байна гэж хэлж болохоор байна.

Концесси

Монголд хувийн болон улсын байгууллагуудын хоорондын түншлэлийг дэмжсэн бодлогын үндэс бүрэлдээгүйгээс гадна, концессийг зохицуулсан хууль байхгүй. Гэхдээ концессийн талаарх цогц зохицуулалтыг Төрийн болон Орон Нутгийн Өмчийн тухай Хуульд нэмэлт болгон оруулахаар Засгийн Газар ажиллаж эхлээд байна.

Одоогоор Монгол Улс нь дэд бүтэц, үйлчилгээний салбарт хувийн хэвшил болон төрийн хоорондын түншлэлийн талаар хязгаарлагдмал хүрээнд эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. ЕСБХБ-ын Концессийн үнэлгээний аргачлалаар гаргасан доорх диаграммаас харахад, олон улсын стандарттай харьцуулахад Монгол Улс нь концессийн эрх зүйн горимыг бүх чиглэлд сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Концессийн эрх зүйн орчны чанар – Монгол Улс (2005)



Жич: Тэнхлэг бүрийн туйлын цэг нь UNCITRAL-ын Хувийн санхүүжилттэй дэд бүтцийн төслийн хувьд баримтлах эрх зүйн зааварчилга зэрэг олон улсын стандартад нийцсэн төгс төгөлдөр дээд цэг байна. Тор хэдий чинээ түүнд ойртож очино, тус орны концессийн хууль нь тухайн стандартад дөхөж очиж байгааг илтгэнэ.

Эх үүсвэр: ЕСБХБ-ны Концессийн үнэлгээ 2005 он

Төрийн болон Орон Нутгийн Өмчийн тухай одоогийн хуулиар эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр төрийн өмчийн хөрөнгийг гуравдагч талд концессийн болон лизингийн гэрээгээр шилжүүлж болно. Харин газар, газрын хэвлийн асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулдаг. Концессийн тусгайлсан хууль байхгүй байгаа өнөөдөр ийм төрлийн асуудлыг Газрын тосны, Ашигт малтмалын, Усны, Төмөр замын тээврийн аюулгүй байдлын, Авто тээврийн, Эрүүл мэндийн, Боловсролын, Эрчим хүчний тухай салбарын хуулиудаар тус тус зохицуулж байна.

Ер нь Монголын эрх зүйн тогтолцоонд концесситэй холбоотой гэрээг тодорхойлсон тодорхойлолт, хамрах цар хүрээг тодорхой заасан заалт байдаггүй. Тухайлбал, Төрийн болон Орон Нутгийн Өмчийн тухай Хуульд “концесси”-ийн тодорхойлолт байхгүй. Эрх зүйн үндсэ ийнхүү хангалттай бус байгаагаас концессийн гэрээ уян хатан байх боломж дутмаг юм. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар концесси маягийн гэрээ байгуулахад сонгон шалгаруулалтын горимыг мөрдөхийг шаарддаг. Үүнээс гадна лиценз цуцлагдсан тохиолдолд концессийг хүлээн авагч этгээдэд нөхөн олговор олгох талаар ямар ч салбарын хууль (Ашигт малтмалын хуулиас бусад)-нд заалт тусгагдаагүй. Монголын хуулинд маргааныг (түүний дотор гадаадын тал оролцсон маргаан) шийдвэрлэх талаар харьцангуй дэлгэрэнгүй зохицуулалт тусгагдсан байдаг. Иргэний хуулиар талууд маргаан шийдвэрлэхэд хэрэглэх хуулийг сонгох, маргааныг арбитраар шийдвэрлүүлэх заалтыг гэрээндээ тусгахыг

зөвшөөрдөг. Салбарын хуулиудад дээрх зохицуулалт тусгагдаагүй тул, энэхүү уян хатан байдал нь концессийг авагч этгээдэд нэлээд боломжийг олгож байгаа юм. Гэхдээ зарим нэг салбарт (тухайлбал, Газрын тосны тухай хууль) зөвхөн Монголын хуулийг заавал мөрдөхийг зааж өгсөн.

Дампуурал

Дампуурлын асуудал нь 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулиар зохицуулагддаг. Энэ хууль нь дампуурлын хэрэг үүсгэх, түүнээс үүдэж гарах маргаан шийдвэрлэх хэрэгсэл болж байна. Гэхдээ дампуурлыг шийдвэрлэх ажиллагаа болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, шүүхийн зохистой мэдлэг, туршлагын тухайд асуудлууд байсаар байгаа. ЕСБХБ-ны Дампуурлын үнэлгээний аргачлалын дагуу, Монголын Дампуурлын тухай хууль нь олон улсын стандартад “муу нийцэж байна” хэмээн үнэлэгдсэн байна (Диаграмм 3-ыг үзнэ үү).

Муу нийцэж байна гэдэг нь уг хуульд нилээд их дутагдалтай зүйлс байгааг илтгэж байна. Төлбөрийн чадваргүйдэл гэдэг нь санхүүгийн үзүүлэлтээр тодорхойлогддог, гэтэл хуулинд өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний өрийн үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно гэсэн нь ойлгомжгүй байна. Энд нарийвчилсан тодруулга хийх шаардлагатай, ялангуяа хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хугацааг тодорхой зааж өгөх хэрэгтэй.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дампуурч байгаа компанийн санхүүгийн байдлын талаар мэдээлэл авах механизмыг хуулинд тусгаагүйгээс гадна, өртэй этгээд, эсвэл өртэй этгээдийн өмчийг эзэмшдэг гуравдагч этгээдийг итгэмжлэгдэгчтэй хамтран ажиллахыг хуулиар шаарддаггүй. Хүчин төгөлдөр бус хэлцэл, тухайн хөрөнгийн үнээс доогуур үнээр хэлцэл хийх зэрэгтэй холбоотой заалтууд тодорхой бус, тодорхойлогдоогүй нэр томъёо болон зорилгыг тогтоох шаардлага дээр үндэслэгдсэн байна. Түүнчлэн, тодорхой нэхэмжлэгчдэд давуу эрх олгосон байж болзошгүй хэлцлийг хянан шалгах хугацааг дампуурлын хэрэг үүсгэхээс өмнөх 120 хоногоор хязгаарласан нь хэтэрхий богино бөгөөд урвуулан ашиглах боломжийг олгож байна. Бүтцийн өөрчлөлтийн санхүүжилтийн асуудал мөн хуулинд тусгаадаагүй орхигдсон. Эцэст нь, хил дамнасан дампуурлын асуудлыг хуулинд огт орхигдуулсан.

Гол асуудлууд ийм байна. Дэрэхи дутагдлыг засан залруулах, тодорхой бус байдлыг арилган, урьдчилан харах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дорвитой шинэчлэлийг хийж чадвал, тус улсын хөрөнгө оруулалтын орчин эрс сайжрах боломжтой юм.

Дампуурлын тухай хуулийн чанар – Монгол Улс (2005)



Жич: Тэнхлэг бүрийн туйлын цэг нь Дэлхийн банкны Үр дүнтэй дампуурал ба Нэхэмжлэгчдийн эрхийн системийн Зарчмууд болон зааварчилгууд, UNCITRAL-ын ажлын хэсгийн “Дампуурлын тухай хуулийн эрх зүйн зааварчилгаа” болон бусад олон улсын стандартад нийцсэн төгс төгөлдөр дээд цэг байна. Тор хэдий чинээ түүнд ойртож очино, тус орны дампуурлын тухай хууль нь тухайн стандартад дөхөж очиж байгааг илтгэнэ.

Эх үүсвэр: ЕСБХБ Дампуурлын үнэлгээ, 2003/4 он

Барьцаат хэлцэл

Барьцааны асуудлыг зохицуулсан заалтууд 2002 оны Иргэний хуулинд нилээд нарийвчилсан тусгагдсан²⁰. Үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн эрхийн бүртгэлийн тухай хуулинд үл хөдлөх хөрөнгийг барьцаа болгон авч болох заалтыг зааж өгсөн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг зохицуулдаг. Гэхдээ саяхан Монгол Улс нь шүүхийн бус шийдвэрээр барьцааны хөрөнгийг шийдвэрлэх тухай хуулийг гаргаад уг хууль нь 2005 оны 12 дугаар сараас хүчин төгөлдөр болсон хэдий ч, тэр нь үндсэн хуультай зөрчилдөж байгаа гэж үзэж байгаа тул мөрдөж болох эсэх нь тодорхойгүй байна. Салбарын хуулиуд нь хамаарах заалтуудыг бас тус бүрдээ тусгасан байдаг. Жишээ нь: олборлолтын лицензийг барьцаалах талаарх заалт Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан байдаг.

Хэдийгээр Иргэний хууль нь харьцангуй шинэ ч, хөдлөх хөрөнгө (тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө, авлага г.м)-г барьцаанд авах заалт нь тэр бүр амьдралд хэрэгждэггүй нь цаашид дорвитой өөрчлөлтийг хийхгүйгээр зах зээлийг хөгжүүлэхэд хүндрэлтэй болохыг харуулж байна. Барьцаанд авах хөрөнгө хязгаарлагдмал, нийтлэг чанарын хөрөнгө (жишээ нь, бараа материалын нөөц, ирээдүйн тоног төхөөрөмж г.м)-ийг барьцаанд авахыг зөвшөөрдөггүй. Хөдлөх хөрөнгийн барьцааг Газрын бүртгэлд (хөрөнгийн эрхийг) бүртгэхийг тогтолцооны хувьд зөвшөөрдөг ч, ихэнх тохиолдолд энэ нь амьдралд нийцэж өгдөггүй. Урьд дурьдсанчлан гүйцэтгэлийн ажиллагаа өөрөө хангалтгүй, харин шүүхийн бус шийдвэрээр хэрэгжүүлбэл илүү боломжтой байгаа хэдий ч, энэ нь үндсэн хуультай зөрчилдөж байгаа юм. Дампуурлын тухай хууль нь барьцаа бүхий нэхэмжлэгчдэд давуу эрх олгох талаар туйлын хангалтгүй байгааг цогцоор нь шинэчлэх ажиллагаа (Германы Техникийн Хамтын Ажиллагааны Агентлагийн тусламжтайгаар) одоо явагдаж эхлээд байна.

ЕСБХБ нь барьцаат хэлцлийн эрх зүйн тогтолцоог шинэчлэхээр техникийн туслалцааны төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран хэрэгжүүлж байна. Үүнд хуулийн заалтуудыг бүрэн шинэчлэх, барьцааг бүртгэх тусгай бүртгэлийн тогтолцоог бий болгох асуудлуудыг хамруулах юм.

Харилцаа холбоо

Харилцаа холбооны салбар нь 2001 онд батлагдсан Харилцаа холбооны тухай хуулиар зохицуулагдаж, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ) салбарын зохицуулалтын гүйцэтгэдэг. 2004 оноос харилцаа холбооны салбарын бодлогын асуудал нь Дэд бүтцийн яам татан буугдсаны дараа байгуулагдсан Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар (МХХТГ)-г шилжсэн. МХХТГ нь Ерөнхий Сайдын шууд харьяанд байж мэдээлэл, харилцаа холбооны технологийн үндэсний бодлогыг боловсруулж, уялдуулан зохицуулах, түүний дотор харилцаа холбооны төрийн өмч, хөрөнгийг удирдах, салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

ХХЗХ нь 2001 онд харилцаа холбооны бие даасан зохицуулагч этгээд байхаар анх байгуулагдсан. Харилцаа холбооны тухай хуулинд зааснаар тэр нь өрсөлдөөнт орчныг бий болгох, лиценз олгох, тариф тогтоох аргачлалыг баталгаажуулах, харилцан холболтын гэрээний ерөнхий нөхцлүүдийг батлах гэсэн хэд хэдэн тусгай зорилтуудтай. Харилцаа холбооны тухай хуулиар ХХЗХ салбарын зохицуулалтыг хийх эрх бүхий этгээд хэдий ч, МХХТГ сүүлийн үед салбарын зохицуулалт бүхий шийдвэрүүдийг удаа дараалан гаргасаар байна.

²⁰ 153-185 дугаар зүйл.

Монголын харилцаа холбооны зах зээл нь үйлчилгээний хувьд одоо босоо хэлбэрээр сегментлэгдээд байна. Суурин шугамын монопольт байдалтай байсан Монголын Цахилгаан Холбоо компани нь суурин утас, факс, болон зарим нэг мэдээллийн үйлчилгээг, харин Мобиком, Скайтел болон бусад нь хөдөлгөөнт болон утасгүй холбоо, интернетийн үйлчилгээг үзүүлж байна. Монголын цахилгаан холбоо нь лицензийнхээ дагуу нийтийн харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэхийн тулд МХХХТ (төрийн өмчийн холбооны хөрөнгийг удирдах, хөгжүүлэх үүрэг бүхий МХХТГ-ын нэгж)-өөс төрийн өмчийн сүлжээг түрээслэдэг. МЦХК нь 1995 онд хэсэгчилсэн хувьчлалд орж, өмчийн 5 хувийг хувь хүмүүст, 40 хувийг Солонгосын Кореа Телеком компанид хувьчилсан. Монголын Засгийн Газраас Кореа Телеком компанитай байгуулсан хувьчлалын гэрээнд улсын эзэмшлийн үндсэн сүлжээний шугамыг давуу эрхтэйгээр түрээслэх, бусад гуравдагч операторууд болон интернет үйлчилгээ үзүүлэгчдэд дамжуулан түрээслэх эрхийг МЦХК-д олгосон.

Сүлжээний хөрөнгийг үйлчилгээний хэсгээс бүрэн салгаж, дэд бүтэц болон үйлчилгээ нь тусдаа байгууллагуудаар хангагдаж байхаар салбарт бүтцийн өөрчлөлт хийхээр Улсын Их Хурлаас “Хувьчлалын Үндсэн Чиглэл”-д тусган 2005 оны 7 дугаар сард батлан гаргасан. Үүгээр бүгдэд хүртээмжтэй сүлжээг ажиллуулах НЕТКО компани байгуулагдаад, нөгөө талдаа МЦХК бүрэн хувьчлагдаж үйлчилгээгээр дагнасан компани болох юм. Үүний гол зорилго нь операторууд дэд бүтцэд илүү оновчтой хөрөнгө оруулалт хийх, хүчтэй өрсөлдөөнийг бий болгосноор үйлчилгээний үнийг бууруулахад оршино. Энэхүү бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн тулд сүлжээний болон үйлчилгээний лицензийн аль нэгийг нь олгох, өөрөөр хэлбэл, операторт сүлжээний юм уу үйлчилгээний аль чиглэлээр ажиллах сонголтоо хийх шаардлагатай болж байна. Энэхүү санал болгоод байгаа бүтцийн өөрчлөлт нь одоогийн байгаа салбарын бүтцийг боловсронгуй болгох үйл явц бөгөөд үүнийг хэрэгжүүлснээрээр Монгол Улс нь сүлжээний болон үйлчилгээний операторуудыг бүрэн салгасан анхны зах зээлийн нэг болох юм.

ЕСБХБ нь энэхүү бүтцийн өөрчлөлт болон төрийн эзэмшилд үлдэж буй хөрөнгийг хувьчлах асуудлаар Засгийн Газарт зөвлөлгөө өгөх үйлчилгээг санхүүжүүлж байгаагаас гадна эрх зүйн тогтолцоог шинэчлэгдсэн салбарыг дэмжихүйц болгон өөрчлөх, байгууллагын бүтцийг шинэчлэх, бодлогын болон хуулийн заалтуудыг дахин шинэчлэхэд нь Монголын Засгийн Газарт болон салбарын удирдах дээд байгууллагад техникийн туслалцааг үзүүлж байна.

Хавсралт 7 - Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Монгол Улс

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Үйлдвэрлэл, Зардал	<i>(Хувийн өөрчлөлт бодит нөхцөлөөр)</i>						
ДНБ	1.1	1.0	4.0	5.5	10.6	6.2	6.0
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1.1	0.6	1.5	3.0	15.0	-0.9	Бөглөх боломжгүй
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1.6	1.0	5.0	3.7	17.7	7.7	Бөглөх боломжгүй
Хөдөлмөр эрхлэлт лт	<i>(хувийн өөрчлөлт)</i>						
Ажиллах хүчин /жилийн эцсээр/ ¹	-0.7	2.9	3.3	6.4	2.7	1.4	Бөглөх боломжгүй
Хөдөлмөр эрхлэлт /жилийн эцсээр/	-0.6	2.9	4.6	6.4	2.6	1.7	Бөглөх боломжгүй
Ажилгүйдэл /жилийн эцсээр/ ²	4.6	4.6	3.4	3.5	3.6	3.5	Бөглөх боломжгүй
Үнэ ба цалин хөлс	<i>(хувийн өөрчлөлт)</i>						
Хэрэглээний үнэ /жилийн дундаж/	11.6	8.0	0.3	5.1	8.3	12.5	4.1
Хэрэглээний үнэ /жилийн эцсээр/	8.1	8.0	1.7	4.7	11.0	9.2	6.6
Үйлдвэрлэгчийн үнэ /жилийн дундаж/	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй
Үйлдвэрлэгчийн үнэ /жилийн эцсээр/	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй	Бөглөх боломжгүй
Эдийн засаг дахь сарын нийт орлогын дундаж	33.5	4.7	9.4	22.0	16.0	23.5	Бөглөх боломжгүй
Улсын хэвшил	<i>(ДНБ-д эзлэх хувь)</i>						
Улсын төсвийн алдагдал/ашиг	-7.0	-5.4	-5.9	-4.9	-2.1	3.2	-3.1
Улсын төсвийн зардал	41.5	43.9	44.4	42.1	39.4	33.7	Бөглөх боломжгүй
Засгийн газрын ерөнхий өр ⁴	97.3	90.1	100.3	121.2	100.7	83.5	Бөглөх боломжгүй
Мөнгөний салбар	<i>(хувийн өөрчлөлт)</i>						
Нийт Мөнгө M2 /жилийн эцсээр/	17.6	27.9	42.0	49.6	20.5	37.1	Бөглөх боломжгүй
Дотоодын зээл /жилийн эцсээр/	6.5	6.1	42.9	147.3	23.1	22.2	Бөглөх боломжгүй
Нийт Мөнгө M2 /жилийн эцсээр/	25.4	29.7	37.9	48.1	44.3	51.2	Бөглөх боломжгүй
Хүү, Валютын ханш	<i>(жилийн хувиар, жилийн эцсээр)</i>						
Төв банкны бондын хүү	8.7	8.6	9.9	11.5	15.8	4.4	Бөглөх боломжгүй
Хадгаламжийн хүү ⁵	16.8	14.3	13.2	14.0	14.2	13.0	Бөглөх боломжгүй
Зээлийн хүү ⁵	32.8	30.2	28.4	26.3	25.4	23.6	Бөглөх боломжгүй
	<i>долларт ногдох төгрөгөөр</i>						
Валютын ханш /жилийн эцсээр/	1,097.0	1,101.3	1,122.2	1,168.3	1,211.8	1,221.0	Бөглөх боломжгүй
Валютын ханш /жилийн дундаж/	1,076.7	1,097.6	1,108.5	1,142.7	1,185.2	1,205.2	Бөглөх боломжгүй
Гадаад орчин	<i>(сая долларар)</i>						
Урсгал данс	-54	-77	-108	-99	27	28	70
Худалдааны тэнцэл	-140	-170	-229	-199	-149	-155	-72
Экспорт	536	523	524	627	872	1069	1295
Импорт	676	693	753	827	1021	1224	1367
Гадаадын шууд хөрөнгө оруулалт, цэвэр	40	43	78	132	129	258	215
Нийт нөөц, алтыг тооцохгүйгээр /жилийн эцсээр/	191	207	271	178	208	333	
Гадаад өр	837	854	978	1287	1360	1307	Бөглөх боломжгүй
	<i>(бараа үйлчилгээ импортын сараар)</i>						
Нийт нөөц, алт тооцохгүйгээр /жилийн эцсээр/	2.9	3.0	3.4	2.0	1.8	2.5	Бөглөх боломжгүй

	\бараа үйлчилгээний экспортод эзлэх хувь\						
Өрийн үйлчилгээ	3.8	5.3	4.5	34.0	7.4	2.5	2.6
Суурь үзүүлэлтүүд							
Хүн ам /жилийн эцсээр, сая/	2.5	2.5	2.6	2.6	2.6	2.7	Бөглөх боломжгүй
ДНБ /сая төгрөгөөр/	1,018,885	1,115,641	1,241,000	1,461,000	1,911,000	2,267,000	2,737,000
Нэг хүнд ногдох ДНБ /ам доллараар/	379	402	437	494	617	710	Бөглөх боломжгүй
ДНБ-д аж үйлдвэрийн эзлэх хувь /хувиар/		22.0	22.5	25.3	29.9	30.2	Бөглөх боломжгүй
ДНБ-д хөдөө аж ахуйн эзлэх хувь /хувиар/		24.9	20.7	20.1	20.9	21.7	Бөглөх боломжгүй
Урсгал данс/ ДНБ /хувиар/	-5.8	-7.6	-9.6	-7.7	1.6	1.5	3.1
Гадаад өр - нөөц /сая ам доллараар/	646	647	707	1109	1152	974	Бөглөх боломжгүй
Гадаад өр/ДНБ /хувиар/	88.4	84.0	87.4	100.7	84.3	69.5	Бөглөх боломжгүй
Гадаад өр/ бараа үйлчилгээний экспорт /хувиар/	130.8	134.1	138.0	154.1	112.5	88.1	Бөглөх боломжгүй

¹ Хөдөлмөр эрхлэлтийн газар бүртгэлтэй хөдөлмөрийн чадвартай хүн амын тоо

² Албан ёсоор бүртгэгдсэн. 2003 оны хүн амын тооллогоор ажилгүйдэл 17%-тай байсан

³ Улсын төсвийн рлого болон зарлагад буцалтгүй тусламж, цэвэр эзэлжлтийг оруулсан

⁴ Төв засгийн газрын шууд болон тооцоолсон өр, засгийн газрын батлгатай зээл

⁵ Бүх хугацааны зээлийн жигнэсэн дунджаар

Хавсралт 8 – Хоёр талт туслалцаа

Европын Холбоо

Худалдаа Хамтын Ажиллагааны Хэлэлцээр 1993 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр ЕХ-Монгол Улсын хоорондын хамтын ажиллагаа эхэлсэн. Түүнээс хойшхи хугацаанд Монгол Улс нь 70 орчим сая еврогийн ЕХ-ны хөгжлийн тусламжийг голчлон ТАСИС хөтөлбөр, 2004 оноос АЛА (Ази, Латин Америкийн хөгжиж буй орнууд) хөтөлбөрийн хүрээнд тус тус авч иржээ. Тусламж нь хүний нөөцийг хөгжүүлэх, ЖДҮ-ийг дэмжих, байгууллагын болон дэд бүтцийг хөгжүүлэх, шилжилтийн нийгмийн үр дагаврыг бууруулах зэрэг чиглэлээр зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжихэд төвлөрч байв. 2000 оноос ЕХ нь хөдөөгийн хөгжилд анхаарлаа төвлөрүүлж, нийт санхүүжилтийнхээ 80 хувийг энэ чиглэлд өгч байна.

TEMPUS (их сургуулиудын хамтын ажиллагаа), ТББ-ын үйл ажиллагааг дэмжих, ЕСНО хөтөлбөрөөр дамжуулан ган, зудын үр дагаврыг арилгах яаралтай тусламж үзүүлэх зэрэг нэмэлт арга хэмжээнүүдийг бүсийн хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсээр ирсэн. Хамгийн сүүлийн ЕСНО хөтөлбөрийн тусламж (2004 онд 1 сая евро, 2005 онд 900 мянган евро)-ийг гамшигт бэлтгэлтэй байхад зориулсан жижиг төслүүдэд зориулагдсан. Жишээ нь: өрхийн хэрэгцээний ногоо тариалах, гүйцтэгэсэн ажлын төлбөрийг бэлнээр хийх, усны системийг нөхөн сэргээх, хадлан бэлтгэх зэрэг болно. 2004 оноос Монгол Улс нь Азийн орнуудад хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой болсон.

Удахгүй гарах 2007-2013 онд Монголд үзүүлэх тусламжийн стратеги/ Үндэсний Индикатив Хөтөлбөрөөрөө хөдөөгийн хөгжилд тухайлбал хөдөөгийн ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийг тогтвортой орлогын эх үүсвэртэй болгох, тэдэнд нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгоход цаашид ч анхаарах болно. ЕХ нь бэлчээрийн эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх, хөгжүүлэх; бичил санхүүгийн үйлчилгээ болон орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүрээнд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна.

Үүний зэрэгцээ Монгол Улс нь ЕХ-ны бүсийн болон сэдэвчилсэн хэд хэдэн хөтөлбөрүүдэд үргэлжлэн хамрагдаж ардчилал, хүний эрх, төрийн бус байгууллагуудын хөгжилд оролцох оролцоо, цагаачлал, улс төрийн орогнол, хүний болон нийгмийн хөгжил, байгаль орчин, байгалийн нөөцийн тогтвортой удирдлага болон хүнсний аюулгүй байдлын чиглэлүүдэд дэмжлэг авах боломжтой.

ЕХ нь Дэлхийн Банк зэрэг бусад хандивлагчидтай хамтран ажиллахыг эрмэлздэг бөгөөд Тогтвортой Амьжиргаа хөтөлбөрт хамтран санхүүжүүлэгчээр оролцох асуудлыг судалж байна.

ХБНГУ

Монгол Герман хоёр нь БНАГУ-ын үеэс уламжилж ирсэн олон жилийн найрсаг харилцаатай улсууд юм. Монголд олон хүн германаар ярьдаг.

Өнөөг хүртэл үргэлжилж байгаа хөгжлийн хамтын ажиллагаа нь Монголд улс төр, эдийн засгийн өөрчлөлт гарсны дараа буюу 1991 оноос эхлэлтэй юм. Түүнээс өмнө Монгол Улс нь БНАГУ-аас хөгжлийн тусламж авч байсан. БНАГУ нь ЭЗХТЗ-өөр дамжуулан тусламжаа олгодог байсан ба ЗХУ-ын дараа ордог хамгийн гол хандивлагч орон байв.

Герман улсаас 1991 оноос хойш нийт 235 сая еврогийн²¹ тусламжийн амлалтыг аваад байгаа нь Германаас нэг хүнд ногдох хэмжээгээрээ хамгийн их тусламжийг авдаг орнуудын тоонд Монгол Улсыг багтааж байгаа юм. Энэ нь нэг талаас хоёр улсын олон жилийн найрсаг харилцааны үр дүн, нөгөө талаас Монгол Улс нь ардчиллыг сонгож, бүтцийн өөрчлөлт хийхийг зорин ядуурлаа бууруулахаар тэмцэж байгааг хүлээн зөвшөөрсний илрэл юм.

²¹ Санхүүгийн хамтын ажиллагаа ба нарийвчилсан хүрээний техникийн туслалцаанд 204.69 сая евро (1991-2001), өргөн хүрээний техникийн туслалцаанд 30.3 сая евро (1991-2001)-оос бүрдэнэ.

Герман-Монголын хөгжлийн хамтын ажиллагаа нь тус улсын дараах гол асуудлуудад төвлөрдөг:

- зах зээлийн эдийн засгийг бий болгох (түүнийг дэмжсэн эрх зүйн орчин, зохистой санхүүгийн тогтолцоо),
- тус улсын амин чухал салбар болох эрчим хүч, харилцаа холбооны дэд бүтэц,
- байгаль орчны хамгаалал (байгалийн нөөцийн хамгаалал, сэргээгдэх эрчим хүч).

Өөрчлөгдөн байгаа нөхцөл (улс орны хөгжил, бусад хандивлагчдын оролцоо) байдлыг харгалзан, мөн үр ашгийг өндөржүүлэхийн тулд хамтын ажиллагааг дараах чиглэлүүдэд нэн тэргүүнд хандуулахаар 2001 оны 10 дугаар сард тохиролцсон:

- эдийн засгийн шинэчлэл ба зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх
- байгаль орчны бодлого(эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчийг оролцуулан)

Түүнчлэн арга хэмжээг хөдөөд түлхүү төвлөрүүлнэ.

Амлалт (1992 оноос хойш):

	1992 (сая ДМ)	1993 (сая ДМ)	1994 (сая ДМ)	1995 (сая ДМ))	1996 (сая ДМ)	1997 (сая ДМ)	1998/99 (сая ДМ) (2 жилийн амлалт) ¹⁾	2000/01 (2 жилийн амлалт) хамгийн суулд (сая ДМ)	2002/03 (2 жилийн амлалт) (сая €)	2004/05 (2 жилийн амлалт) (сая €)	Амлалтын нийт дүн оноог хүртэл (1991 оноос) (сая €)
СХА	10	14	17	12	15	15	25 +17 ²⁾	20 + 8 ⁵⁾	10	9 +9.3 ⁸⁾	114.20
Нарийвчилсан хүрээний ТХА	5	11	11	13	14	15	25 + 3 ³⁾	20 + 6 ⁴⁾	10 + 1 ⁷⁾	11 + 1 ⁹⁾	90.49
Дэд дүн	15	25	28	25	29	30	70	54	21	24	204.69
Өргөн хүрээний ТХА											30.3
Нийт⁶⁾											234.99

1) 1998 оноос 2 жилээр амлалт гаргадаг болсон.

2) Ерөнхийлөгч Херцогыг Монголд айлчлах үеийн амлалт: “Харилцаа холбоо II, III” 17 сая ДМ.

3) Ерөнхийлөгч Херцогыг Монголд айлчлах үеийн амлалт: “Эдийн засгийн эрх зүйн шинэтгэлд зөвлөх үйлчилгээ” 3 сая ДМ

4) Засгийн газрын хэлэлцээрээс гадуур “Зуд 2000/2001 тусгай хөтөлбөр” 2 сая ДМ, Сэргээгдэх эрчим хүчний чиглэлд 2000 онд 4 сая ДМ.

5) 2001 онд Засгийн газрын хэлэлцээрээс гадуур “Сэргээгдэх эрчим хүч”-д 8 сая ДМ

6) Герман улсын төрийн болон яамдуудын санхүүжилтийг оруулахгүйгээр (1991-2000 онд: 21.88 сая евро (42,8 сая ДМ))

⁷⁾ Парламентын Төрийн нарийн бичгийн дарга Эйдсын Монголд хийсэн айлчлалын үеэр хийсэн амлалт: “Хуульчдыг сургах, давтан сургах- 1 сая евро

⁸⁾ а) Глобал ач холбогдолтой арга хэмжээнд зориулсан Тусгай сан (эрчим хүчний хэмнэлт) 3 сая евро, б) Бичил санхүүгийн байгууллага болох ХАС банкинд өөрийн хөрөнгийн онцлог бүхий хоёрдогч зээл (2005 онд амлалтын эрх нээгдсэн) 3 сая евро, в) Орон сууц барихад зориулсан зээлийн хөтөлбөр (2005 онд амлалтын эрх нээгдсэн) 3,3 сая евро

⁹⁾ Глобал ач холбогдолтой арга хэмжээнд зориулсан Тусгай сан (ДОХ-оос урьдчилан сэргийлэх арга хэмжээ)

Итали

2003 онд Венито муж “Богд дах Ундны Ус, Сэргээгдэх Эрчим Хүч” төслийн хүрээнд 118,000 Еврогийн санхүүжилтийг олгохоор баталжээ. Падовагийн Үндэсний Эрдэм Шинжилгээний Зөвлөл уг төслийн хэрэгжилтийг хариуцаж байгаа юм.

Үйлдвэрийн салбарын хувьд Италийн Төрийн Бус Байгууллага болох ХОН (Хөгжлийн Оролцооны Нийгэмлэг) Монголын дөрвөн бүс нутагт эмэгтэй удирдлагатай бичил болоод жижиг аж ахуйнуудад туслах санаачлагыг гаргасныг Италийн Хөгжлийн Хамтын Ажиллагаа дэмжиж, 250,000 орчим еврогийн санхүүжилтийг олгоод байна. 1995-2002 онд Италийн Хөгжлийн Хамтын Ажиллагаанаас Монгол Улсад 3.1 сая еврогийн хүнсний тусламж үзүүлсэн.

Монгол дахь Италийн Хөгжлийн Хамтын Ажиллагаанаас Монгол Улсын хэмжээнд цорын ганц Улаанбаатарын Эх-Нялхсын Эрүүл Мэндийн Эрдэм Шинжилгээний Төвийн Сайжруулалт нэр бүхий 2 жилийн хугацаатай төсөлд санхүүжилт хийхээр болоод байна. Италиас нийтдээ 5,556,000 еврогийн санхүүжилт хийсний 5.16 сая нь тусламжийн, үлдсэн 396,000 евро нь буцалтгүй тусламж юм. Тусламжийн зээл нь эмнэлэг, оношлогоо болон мэс заслын тоног төхөөрөмжүүдийг Италийн компаниудаас нийлүүлэх, эмнэлгийн ажилчдыг сургалтанд хамруулах, болон эмнэлгийн зарим хэсгийн бүтцийг өөрчлөхөд зарцуулагдана. Буцалтгүй тусламжаар Итали мэргэжилтнүүдийн техникийн болон хяналтын үйл ажиллагааны зардал, дотоодын зөвлөхийн зардал, төслийн зарим зардал болон тухайн төвийн менежер, эмч, техникчүүдийн Итали улсад хийх танилцах аялалын зардал зэргийг хангана.

Япон

1990 онд Монгол Улсад улс төрийн болон эдийн засгийн шилжилт эхэлснээс хойш Япон Улс албан ёсны хөгжлийн тусламжаараа дамжуулан энэхүү үйл явцад идэвхитэй оролцон, тусламж үзүүлсээр байна. Шилжилтийн эхэн үе болох 1990-1993 онуудад Япон улс нь төлбөрийн балансыг дэмжих тусламжаа эдийн засгийн хямралыг зогсоох нийгмийн хомсдлын нөлөөллийг бууруулахад (1990-1993 онд ойролцоогоор 140 сая доллар) төвлөрүүлж байсан бол, 1991-1995 онуудад төмөр зам, цахилгаан станц зэрэг гол дэд бүтцийн салбарыг сэргээн босгоход буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр дамжуулан хөрөнгө оруулалт (1991-1995 онд 160 сая доллар) хийж байжээ.

Эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж, ядуурлыг бууруулах Монгол Улсын оролдлогыг дэмжих үүднээс бусад хөгжлийн түншүүдтэй уялдуулсны үндсэн дээр Япон Улс нь тусламжаа дараах чиглэлд ач холбогдол өгч төвлөрүүлэхээр тогтоод байна.

- Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг түргэтгэх үүднээс байгууллагын болон хүний нөөцийг хөгжүүлэх
- Тодорхой бүс нутгийг хөгжүүлэх (мал аж ахуйг оролцуулан)
- Байгаль орчин болон уламжлалт амь амьжиргааны хэв маягийг хамгаалах ,
- Амьжиргаанд шууд холбоотой үйлдвэрлэл болон нийтийн аж ахуйн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх.

Иймээс Япон Улс саяхнаас тусламжийнхаа хүрээг өргөжүүлээд байна. Тухайлбал, 2005 онд байгаль орчныг хамгаалах үүднээс ЖДҮ-үүдэд хөнгөлттэй зээл (ойролцоогоор 25 сая ам доллар), усан хангамжийн системийг сэргээн засварлахад болон ерөнхий боловсролын салбарт (нийтдээ 25 сая ам долларын) буцалтгүй тусламжийг хуваарилжээ. Мөн нийгмийн салбар, төсөв/татварын орлогын менежмент, аудитын үйл ажиллагаанд үзүүлж буй техникийн туслалцааны хүрээгээ нэмэгдүүлээд байна.

Люксембург

ЕСБХБ-ны МХАС–д хандивлагчдын нэг болохын хувьд Монгол оронтой хоёр талын үр өгөөжтэй хамтын ажиллагааг өрнүүлдэг.

2000 оноос хойш 800 орчим мянган еврогийн техникийн туслалцааг Люксембург нь голчлон санхүүгийн сургалт болон зөвлөх үйлчилгээг үзүүлээд байна. Тусламжийг Люксембургийн Засгийн Газраас шилжилтийн эдийн засаг бүхий орнуудын банк санхүүгийн салбарт шинэ мэдлэг, ноу хау-г дамжуулах зорилготойгоор 1999 онд байгуулсан Санхүүгийн Технологийг Шилжүүлэх Агентлаг (АТТФ)–аараа дамжуулан үзүүлж байна (энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг СТША-ын www.attf.lu вэб хуудаснаас үзнэ үү).

АТТФ агентлагийн шугамаар танилцах аялал, курс, семинар, зөвлөх үйлчилгээг Люксембургт болон газар дээр нь дараах өргөн хүрээнд авсан. Үүнд: санхүүгийн төвүүдийн үйл ажиллагаа; банк, санхүүгийн байгууллагууд зах зээлийн эдийн засагт; зээлийн үнэлгээ; банкны эрсдэл; банкны үйл ажиллагааны үзүүлэлт; банкны маркетинг ба стратеги төлөвлөлт; салбарын удирдлага; гадаад болон дотоод аудит; олон улсын санхүүгийн зах зээл; глобалчлал; эрсдлийн

удирдлага; актив, пассивын удирдлага; хувийн банкны үйл ажиллагаа; санхүүгийн шинэ бүтээгдэхүүн; хүнтэй харилцаж ажиллах чадвар; манлайлал; хүний нөөцийн удирдлага; мөнгө угаалтын эсрэг тэмцэл. Зорилгод бүлгүүд нь банкны ажилтнууд (дээд удирдлага, гүйцэтгэх удирдлага болон бусад ажилтнууд), төрийн албаныхан болон төв банкны төлөөлөгчид байсан юм.

Үүнээс гадна 2005 оноос хойш Люксембургийн Санхүүгийн Сургуульд Монголын хэд хэдэн хүнийг сургаж, тэдний сургалтын зардлыг дааж байна. 2007 оноос хойш даатгалын салбарынханд дээрхтэй адил сургалт болон зөвлөх үйлчилгээгээр туслахаар төлөвлөөд байгаа.

АТТГ агентлаг нь банк, санхүүгийн сургалтыг үргэлжлүүлэн явуулах зорилгоор 2003-2004 онуудад ЕСБХБ-наас 200 мянган еврогийн санхүүжилт авсан.

Люксембург нь дараах салбаруудад өөрийн тусламжийг үзүүлж ирсэн. Үүнд:

- 2001 онд зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн төслөө Монголд эхэлсэн. 2001-2006 онуудыг хамарсан анхны санхүүжилтийн дүн 950 мянган евро бөгөө нэмэлт санхүүжилт болох 2.5 сая еврогийн эх үүсвэрийг 2007-2010 онуудад олгохоор Люксембургийн Засгийн Газар саяхан баталлаа.
- Монголын гамшгийн удирдлагыг сайжруулахаар 640 мян еврог НҮБХХ-д хандивлаад байна.
- 2007 онд Азийн Хөгжлийн Банкаар дамжуулан Тэтгэврийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлэхээр анхны санхүүжилт болох 500 мянган ам.долларын санхүүжилтийг хийх гэж байна.

Дээрх туслалцааг нэгтгэн харахад, Люксембург Улс нь Монгол Улсад нийтдээ (зарцуулсан болон амласан; олон талын болон хоёр талын шугамаар) 6.3 сая еврогийн тусламжийг үзүүлээд байна.

Нидерланд

Монголын эрх бүхий байгууллагуудын өмнө тулгарч буй асуудлын нэг нь сайн засаглал, өөрийн гэсэн өвөрмөц эвдрээгүй байгаа еко тогтолцоог хадгалан үлдээх явдал юм. Нидерландын Засгийн Газар нь Монгол Улсын байгаль орчин, ургамал, амьтны ертөнц, газар, усны менежментийн чиглэлийн төслүүд дээр илүү анхааран дэмжих болно. Энэ зорилгоор Монгол Улсад жилд 7.5 сая евро олгож байхаар хуваарилаад байна.

Мөн Монгол Улс нь ORET Хөтөлбөрийн (Хөгжилд нөлөөтэй экспортын хэлцэл) хүрээнд хамтын санхүүжилтэд хамрагдах боломжтой.

Америкийн Нэгдсэн Улс

АНУ нь эдийн засгийн болон цэргийн ихээхэн тусламжийг Монголд үзүүлдэг. Эдгээр тусламжийн ихэнх нь хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн түншүүдээр дамжуулан олгогддог.

- а) АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА) нь АНУ-аас Монголд үзүүлэх тусламжид тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. АНУ-ын ОУХА-гаас 1991-2006 онуудад олгосон тусламж нь 165 сая орчим ам.долларт хүрээд байгаа бөгөөд эдгээр нь бүгд буцалтгүй тусламж байсан юм. Хөтөлбөрийг Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ дээр байрладаг есөн хүнтэй АНУ-ын ОУХА-ийн Төлөөлөгчийн Газар удирдан хэрэгжүүлдэг. Тусгай төслүүдийг Монголын улсын болон хувийн хэвшлийн түншүүдтэй хамтран, гүйцэтгэгч болон баталгаа гаргагчдын сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлдэг.

АНУ-ын ОУХА-ын Монголд үзүүлдэг тусламж нь үр дүнд чиглэж, дараах 2 үндсэн зорилгыг өмнөө тавьдаг. Үүнд: хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн тогтвортой

өсөлт, илүү үр дүнтэй, хариуцлагатай засаглал зэрэг зорилго багтана. Монголд хэрэгжсэн төсөл бүхэн энэхүү харилцан уялдаатай үндсэн хоёр зорилгын аль нэгд чиглэгдсэн байдаг. Монголд туслах АНУ-ын ОУХА-ийн 2004-2008 оныг хамарсан одоогийн стратеги нь дараах төслийн бүрдэл хэсгүүдээс бүрдэж байна:

Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба Өрсөлдөх чадвар (ЭЗБШӨЧ) Техникийн экспертүүд нь Ерөнхий Сайдын албатай хамтран ажиллаж, худалдаа, хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөгжил гэсэн гол асуудлуудаар дүн шинжилгээ хийдэг. Эрчим хүчний салбарын шинэчлэл, Монголын өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэлийн салбарыг бэхжүүлэхэд тусгайлан ач холбогдол өгдөг.

Говийн Санаачилга ба Гэр Санаачилга: Говийн санаачилга нь хөдөөгийн бизнесийг хөгжүүлэхэд туслах замаар эдийн засгийн өсөлтийг хөхиүлэн дэмждэг. Үүнийгээ орон нутгийн банкуудын санхүүгийн үйлчилгээг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгох, малчдын бүлэг болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд техникийн дэмжлэг үзүүлэх, радио болон сар тутмын сэтгүүл зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан өргөн хүрээний бизнесийн мэдээллээр хангах үйлчилгээг хүргэх зэрэг үйл ажиллагаагаар хэрэгжүүлдэг. *Гэр санаачилга нь* Монголын хот суурин газрын ядуу иргэдэд чиглэсэн дээрхийн ижил төсөл юм.

Шүүх засаглалын шинэчлэлийн төсөл: Энэ төсөл нь шүүхийн мэргэжлийн болон байгууллагын чадавхийг дээшлүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх, мэргэшсэн байдлыг сайжруулах, шүүхийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд төвлөрөн хэрэгждэг.

Сонгуулийн болон Парламентын тогтолцоог дэмжих төсөл: Энэ төсөл нь Улсын Их Хурлыг илүү нээлттэй, үр дүнтэй болгох чиглэлээр Улсын Их Хуралтай, сонгуулийг чөлөөтэй, шударга байлгах чиглэлээр сонгуулийн байгууллагууд болон олон нийттэй хамтран ажиллаж байна.

Авилгалын эсрэг тэмцлийг дэмжих төсөл: Авилгал, хээл хахуультай тэмцэх үр дүн бүхий хууль боловсруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд энэ төслийн зорилго оршино.

- б) Монгол дахь Энх Тайвны Корпус нь эрэлтэд үндэслэсэн хөгжлийн тусламжийг анхан шатны түвшинд хүргэх, Америкчууд болон Монголчуудын хоорондын зан заншил, соёлын харилцан ойлголцлыг сайжруулахад бие сэтгэлээ зориулсан ажиллагсад болон сайн дурынхнаас бүрдсэн баг байдаг. 90 гаруй сайн дурынхан Монголын 21 аймгийн 18-д нь ажиллаж байна. Монгол дахь Энх Тайвны Корпус нь өөрийн 29 ажилтнуудаар (24 Монгол, 5 Америк) үйл ажиллагаагаа явуулж, сайн дурын идэвхтнүүдийг дэмжин ажилладаг.
- в) 2000 оноос хойш АНУ нь Монгол Улсын энх тайвныг сахин хамгаалах хүчнийг шинэчлэх зорилгод нь нийт 30 гаруй сая ам.долларын тусламжийг үзүүлээд байна. Үүнд тоног төхөөрөмж болон сургалт орж байгаа.
- г) АНУ-ын ХАА-н Департамент нь Монгол Улсад 60 сая ам.долларын хүнсний тусламжийг 1993 оноос хойш үзүүлээд байна.
- д) Өргөн хүрээнд зөвлөлдсөний үндсэн дээр 2005 оны 10 дугаар сард Монгол Улс нь Мянганы Сорилтын Санд саналаа эцэслэн хүргүүлсэн. Монголын саналд орсон төслүүдийг МСС судалж үзэж байгаа бөгөөд энэ үе шат 2007 оны эхээр дуусах төлөвтэй байна. Энэ үе шат дуусахаар МСС болон Монголын Засгийн Газрын хоорондын Гэрээг эцэслэн тохирох хэлэлцээр эхэлнэ.

Санал болгож буй Таван жилийн Гэрээ нь тус улсын ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг хангахад эрүүл мэнд, боловсрол, харилцаа холбоо, тээвэр, санхүү, өмчийн эрхийн хүрээнд шаардлагатай байгаа асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулж байгаа юм.

1.1 Хавсралт 9 – Монголын газрын зураг

